

**Архангай аймгийн Газар зохион байгуулалтын  
Ерөнхий төлөвлөгөөний агуулга**

**Нэгдүгээр бүлэг: Архангай аймгийн тухай Ерөнхий ойлголт,  
байгаль-цаг уурын нөхцөл, нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдал**

1.1. Аймгийн тухай ерөнхий ойлголт

1.2. Байгаль-цаг уурын нөхцөл

- 1.2.1. Уур амьсгал
- 1.2.2. Газрын гадарга
- 1.2.3. Хөрс
- 1.2.4. Ургамалжилт
- 1.2.5. Ус зүй

1.3. Нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдал

- 1.3.1. Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл ба дэд бүтцийн хөгжил
- 1.3.2. Хүн ам
- 1.3.3. МАА
- 1.3.4. Газар тариалан
- 1.3.5. Аялал жуулчлал, амралт, рашаан сувилал болон бусад үйлдвэрлэл, үйлчилгээ

**Нэгдүгээр бүлгийн дүгнэлт:**

**Хоёрдугаар бүлэг: Аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц,  
түүний ашиглалт, хамгаалалтын өнөөгийн байдал**

2.1. Аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц

2.2. ХАА-н газрын ангилал, түүний ашиглалт, хамгаалалт

- 2.2.1. Тариалангийн газар
- 2.2.2. Бэлчээрийн газар
- 2.2.3. Хадлангийн газар
- 2.2.4. ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар

2.3. Хот, тосгон бусад суурин газрын ангилал,  
түүний ашиглалт, хамгаалалт

- 2.3.1. Барилга, байгууламжийн дэвсгэр газар
- 2.3.2. Нийтийн эдэлбэрийн газар
- 2.3.3. Үйлдвэр, уурхайн газар
- 2.3.4. Гэр хорооллын газар

2.4. Зам, шугам сүлжээний газрын ангилал,  
түүний ашиглалт, хамгаалалт

- 2.4.1. Автозамын газар
- 2.4.2. Шугам сүлжээний газар

2.5. Ойн сан бүхий газар, түүний ашиглалт, хамгаалалт

2.6. Усны сан бүхий газар, түүний ашиглалт, хамгаалалт

2.7. Улсын тусгай хэрэгцээний газар, түүний ашиглалт, хамгаалалт

**Хоёрдугаар бүлгийн дүгнэлт:**

**Гуравдугаар бүлэг: Аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент**

- 3.1. ХАА-н газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент
  - 3.1.1. Газар тариалан, атаршсан газар болон хадлангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент
  - 3.1.2. Бэлчээрийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент
- 3.2. Хот, тосгон бусад суурин газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент
- 3.3. Зам, шугам сүлжээний газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент
  - 3.3.1. Автозамын ашиглалтын менежмент
  - 3.3.2. Эрчим хүч, холбооны шугамын ашиглалтын менежмент
- 3.4. Усны сан бүхий газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент
  - 3.4.1. Газрын гадаргын ус ашиглалтын менежмент
  - 3.4.2. Газрын гүний ус ашиглалтын менежмент
- 3.5. Ойн сан бүхий газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент
- 3.6. Улсын тусгай хэрэгцээний газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент
- 3.7. Архангай аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын зөвлөмж

**Аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад ашигласан ном, хэвлэлийн жагсаалт**

## **Нэгдүгээр бүлэг:**

**Архангай аймгийн тухай ерөнхий ойлголт,  
байгаль-цаг уурын нөхцөл, нийгэм-эдийн  
засгийн өнөөгийн байдал**

### 1.1.Аймгийн тухай ерөнхий ойлголт

Архангай аймаг нь 1923 онд байгуулагдсан бөгөөд Монгол орны төв хэсэгт Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Булган, Өвөрхангай аймгуудтай хил залган оршидог. Байгалийн бүс, бүслүүрийн хувьд өндөр уулын /Хангайн нурууны хойт хэсэг/, ойт хээрийн /газар нутгийн дийлэнхи хэсэг/, хээрийн /Хануй голын дунд хэсэг/ бүсийн төлөөллийг хамарсан нийт 55.3 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, 94.9 мянган хүн амтай /үүнээс 80.8% нь хөдөөгийн/ аймаг юм. Архангай аймаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр 19 сум, 99 багт хуваагддаг, нийслэл Улаанбаатар хотоос 521 км-ийн зайд оршино. Үүнээс 430 гаруй км зам нь хатуу хучилттай. Эдийн засгийн үндсэн салбар нь ХАА бөгөөд үүний дотор МАА-н үйлдвэрлэл зонхилно. Нийт малын тоо 1948.2 мянга, үүнээс тэмээ 0.7 мянга, адуу 191.2 мянга, үхэр 231.7 мянга, хонь 861.1 мянга, ямаа 663.6 мянга. Нийт малынхаа тоогоор Хөвсгөл, Өвөрхангай, Увс аймгийн дараа ордог. Үүнээс улсад адуугаар 1, үхрээр 2, хониор 5 дугаар байранд орно.

Тус аймагт “Хүнс–Архангай, “Илч-Архангай”, “Автозам–Архангай, “Шинэ өргөө”, “Тансаг трейд” зэрэг үйлдвэрлэл-үйлчилгээний 80 шахам ААН байгууллага ажилладаг.

Аймгийн хэмжээгээр ерөнхий боловсролын 35 сургууль, соёл урлагийн 30 гаруй цэг салбар, “Гэлэг” хувийн дээд сургууль, Багшийн коллежоос гадна сум дундын эмнэлэг 2, сумын эмнэлэг 17, бусад төрөлжсөн эмнэлгүүд үйл ажиллагаагаа явуулдаг.

Архангай аймаг далайн төвшнөөс дээш 1100-3600 метрт өргөгдсөн Суварга хайрхан, Баянзүрх, Дулаанхаан, Ноёнхангай, Халзан–бүргэдтэйн сарьдаг өндөр уулс, Хангай, Ар, өвөр Жаргалант, Бугат, Бөхөн шар, Булганы байгалийн үзэсгэлэнт уул нуруудаас гадна галт уулын дэлбэрэлтээс үүсэж тогтсон гойд сонин тогтоц бүхий Хорго, Сэнжит цохио, Уран мандал уул, Баян уул, түүнчлэн Хөх нуур, Гурван тамирын шугуйт хөндий, Тоглох, Хонгорж, Бургалтайн өргөн уудам талуудтай.

Хангайн нуруунаас эх авсан хойд, урд Тамир, Тэрх, Суман, Гичгэнэ, Чулуут, Хануй, Хүнүй, Орхон голуудтай бөгөөд Тэрхийн цагаан, Өгий, Дөрөө, Айраг зэрэг 188 нуур цөөрөм, 674 булаг шанд, 844 жижиг гол горхи тус аймгийн нутагт байдаг.

Эмчилгээ сувилгааны ач холбогдол бүхий Ноёнхангай, Мухар–хужирт, Шивэрт, Хадат, Бор тал, Цагаан сүм, Хануй, Улаан–Эргийн гэх мэт 50 гаруй халуун, хүйтэн рашаан бий.

Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 19.6 хувийг шилмүүст ой эзэлдэг. Ой бүхий газар 50 гаруй төрлийн мод бут, 1700 нэрийн ургамал ургадгаас түүний 20 орчим хувь нь эмчилгээний зориулалтаар ашиглагддаг ховор ургамал юм. Үүнээс гадна Архангай аймаг нь төрөл бүрийн ан амьтнаар баялаг бөгөөд хойлог, хур, хун, сойр, ёл, шонхор, бүргэд зэрэг 390 гаруй төрлийн жигүүртэн шувууд, 10 орчим овгийн 40 төрлийн загасны ихэнх нь тус аймагт байдаг нь судалгаагаар тогтоогджээ.

Ашигт малтмалын хувьд нүүрс, шатдаг занар, төмрийн ба зэсийн хүдэр, марганци, гантиг, болор, хүрмэн чулууны нөөц, илэрцүүд ажиглагдсан байна.

Тус аймагт байгалийн гоо үзэсгэлэнт газруудаас гадна 200000 жилийн өмнө амьдарч байсан эртний хүний гал голомтын үлдэгдэл, шинэ чулуун зэвсгийн дараах хүрлийн үеийн гойд өвөрмөц дурсгал “Бугын чулуу”, Түрэг улсын их хаан Бильге, түүний дүү хун тайж Культегиний гэрэлт хөшөө, Хар хорум хотын туурь зэрэг 582 онд босгосон хөшөө дурсгалуудаас эхлээд ХҮШ-Х1Х зууны үеийн бичигт буган хөшөөнүүд түүхийн эртний болон дундад үе, шинэ үеийн эд өлгийн зүйл нэлээд хэмжээгээр тохиолддог аж.

## **1.2.Байгаль – цаг уурын нөхцөл**

### **1.2.1.Уур амьсгал**

Архангай аймгийн газар нутгийн баруун ба баруун өмнө, өмнө хэсэгт далайн түвшнээс 2400-2500 м өндөрт өргөгдсөн Хангайн нуруу болон түүний салбар уулс, баруун хойд хэсэгт 3000 гаруй метрийн өндөрт өргөгдсөн Тарвагатайн нуруу, Зүүн, зүүн хойд, зүүн өмнө талаараа далайн түвшнээс дээш 1000–1500 метр өндөрт өргөгдсөн уулс, голын хөндий эзэлсэн тал хээрийн бүс нутаг зонхилдог бөгөөд энэхүү рельефийн харьцангуй ялгаа нь уур амьсгалын эрс тэс байдлыг нөхцөлдүүлдэг онцлогтой. Иймээс уур амьсгалын голлох үзүүлэлт болох хуурайн зэргийн тархалт (Кз), хур тунадас, агаарын температур зэрэг үзүүлэлтийг харгалзан нийт нутаг дэвсгэрийг ХАА-н уур амьсгалын 4 үндсэн мужид хувааж болно. Үүнд:

1. Чийглэг хүйтэн муж (Кз < 2.0)
2. Чийглэг хүйтэвтэр (Кз = 2.0)
3. Чийглэгдүү сэрүүвтэр муж (Кз = 2.0-3.0)
4. Хуурайвтар сэрүүвтэр муж (Кз = 3.0-5.0)

**Чийглэг хүйтэн муж нь:** Хангайн нурууны хойд хэсэгт орших Цахир, Хангай, Чулуут, Их тамир, Булган сумын нутаг дэвсгэрийн өндөрлөг өмнөд хэсгийг хамрах бөгөөд харьцангуй чийглэг муж юм. Хуурайн зэрэг (Кз<2), дулаан

хангамжаар муу буюу 10 градусаас дээших температурын дундаж нийлбэр 1200 градусаас бага, 5 дугаар сарын сүүлчээс 8 дугаар сарын сүүл хүртэлх хугацаанд 200-250 мм хур тунадас унана. Үндсэндээ газар тариаланд тохиромж муутай гэж үздэг.

Уг мужид чийг элбэг боловч таримал ургамлын боловсролтын хугацаа, нэмэх температуртай дулааны хангамж бусдаасаа харьцангуй бага.

**Чийглэг хүйтэвтэр муж нь:** Чийгийн байдлаар урдах мужтай адил боловч дулаан хангамжаар арай илүү буюу 10 градусаас дээших температурын нийлбэр 1200–1750 градус болж нэмэгдэнэ. Энэ мужид Жаргалант, Цэцэрлэг, Хашаатаас бусад сумдын нутаг дэвсгэр хамаарна.

**Чийглэгдүү сэрүүн муж нь:** Дээрх хоёр мужийг бодвол чийг хангамжаар муу ( $K_3 < 2.0-3.0$ ). 5 дугаар сарын дунд үеэс 9 дүгээр сарын эх хүртэлх хугацаанд 140–200 мм хур тунадас унадаг боловч дулаан хангамжаар илүү. Нийлбэр температур нь 1750–1950 градус хүрнэ. Энэ мужид Жаргалант, Цэцэрлэг сум бүхэлдээ, Хашаат сумын дийлэнх хэсэг хамрагдана.

**Хуурайвтар сэрүүвтэр муж нь:** 5 дугаар сарын эхээс 9 дүгээр сарын дунд үе хүртэл 90 – 140 мм хур тунадас унадаг. Чийг хангамжаар муу ( $K_3 < 3.0-5.0$ ). Дулааны хүрэлцээ сайн. Нийлбэр температур нь 1950–2250 градус байдаг /10<sup>0</sup> градусаас дээших/. Энэ мужид Хашаат сумын зүүн урд хэсэг бүхэлдээ хамрагдах бөгөөд малын бэлчээрийн нөөц сайтай. Усалгааны асуудал шийдэгдсэн үед олон төрлийн таримал ургамал тариалж арвин ургац авах боломжтой. Архангай аймаг нь газар зүйн солбилцлын хувьд 48 дугаар өргөрөгт байрладаг бөгөөд 48<sup>0</sup>-ын хойд өргөрөг нь Цахир, Тариат, Өндөр-Улаан, Өлзийт сумын төвөөс урагш дунджаар 10–15 км-ийн зайтай өнгөрнө.

Иймээс энэхүү өргөргөөр баримжаалан аймгийн цаг уур, орчны шинжилгээний 18 салбарын олон жилийн ажиглалтын материалд тулгуурлан 40 гаруй нэр төрлийн үзүүлэлтэд математик–статистик боловсруулалт хийж, “Архангай аймгийн уур амьсгалын эмхэтгэл”-г улсын цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан байна.

Газар зүйн 48<sup>0</sup>-ын өргөрөгт жилдээ 2800–2900 цаг нар гийгүүлэхээс ой мод, уул зүйн нөхцөл, нарны алслалт зэргээс хамаарч нар гийгүүлэлтийн хугацаа тус аймагт дээрх хэмжээнээс 25–30 хувиар буурдаг. Нарны гийгүүлэлт 12 дугаар сард 165 цаг буюу өдөрт 4–5 цаг, 6 дугаар сард 270–278 цаг буюу өдөрт 9.5 цаг байдаг. Өвлийн саруудад нарны шууд цацраг 700-800 вт/м<sup>2</sup> байдаг бол зуны саруудад 880 вт/м<sup>2</sup> байдаг нь нарны цацрагийн энерги багагүй байдгийн илрэл юм.

Жилийн дундаж агаарын температур 2000 м-ээс дээш өргөгдсөн газарт – 2.4°C-ээс –3.6°C, 1800 м хүртэл өндөрт 0.1°C-ээс 0.8°C байдаг. Хүйтэн өвөл үнэмлэхүй их хүйтний хэмжээ уулын бүсэд –40°C-ээс – 46°C, хонхор газраа - 48°C хүрдэг. Хамгийн дулаан сар нь 7 дугаар сар бөгөөд дундаж температур нь ууландаа + 12°C-ээс + 14°C, хөндий хотгор газраа + 16°C-ээс + 18°C байдаг байна. Зарим зун 2000 м-ээс дээш өндөр бүсэд + 28°C-ээс + 33°C, 1400 – 1800 м-т + 36°C-ээс + 41°C хүртэл халдаг ажээ. Тус аймагт харьцангуй чийгийн хамгийн бага нь өдрийн 13–14 цагт 44-50 хувь, хамгийн их нь өглөөгүүр 75–85 хувь орчимд хэлбэлздэг. Хангайн гол нуруунд жилд дунджаар 340–350 мм хур тунадас унадаг ч жил бүр харилцан адилгүй.

Далайн түвшнээс дээш 2000 м, түүнээс дээшхи газарт жилд 350 мм-ээс их, дулааны улиралд 227-339 мм хур тунадас унаж байхад 1500 м-ийн өндөрлөг газарт жилд 250–300 мм, үүнээс дулааны улиралд 267 мм хур тунадас унадаг. Архангай аймагт хур бороо элбэг жилдээ 50-60 өдөр бороотой байдаг боловч ялангуяа 7, 8 дугаар сард бороотой өдөр илүү үргэлжилдэг байна. Аймгийн нутаг дэвсгэрт жилдээ дунджаар зүс бороо 42- 45 удаа, аадар бороо 10-15 удаа, шиврээ бороо 4-6 удаа тохиолддог.

Цасан бүрхүүл 10 дугаар сарын эхээр үүсэж, 3 дугаар сарын сүүлчээр арилах боловч зарим жил үүнээс ч эрт арилах явдал тохиолддог.

Хангай, Тариат, Чулуут сумдын нутгаар цасны зузаан зарим үед 25-30 см хүрдэг бол бусад нутгаар 4-6 см байдаг. Уулархаг нутгаар цасны нягт 0.17-0.23 г/см<sup>3</sup>, тал хээрийн нутагт 0.15-0.20 г/см<sup>3</sup> байх нь нэлээд элбэг тохиолдоно.

Салхины жилийн дундаж хурд 2-4 м/сек бөгөөд цасан ба шороон шуургатай өдрийн хамгийн олон нь 3-5 сард ажиглагддаг. 15 м/сек-ээс дээш салхитай өдрийн тоо жилдээ өндөр уулын бүсэд 7-12, тал хээрт 14-16 удаа тохиолддог байна. Судалгаанаас үзэхэд салхины хурд хамгийн ихдээ 20-25 м/сек хүрч байжээ. Шороон шуурга уулархаг нутагт 15-20 удаа, тал хээрт 25-28 удаа ажиглагддаг бөгөөд бусад аймгуудтай харьцуулахад салхины хүчийг сааруулах ой мод сайтай, ургамлан бүрхэвч гайгүй тул тэр болгон шороон шуурга шуурдаггүй онцлогтой.

### **1.2.2.Газрын гадарга**

Аймгийн нутаг дэвсгэр нь мужлалын хувьд нутгийн зүүн хэсэг нь Орхон, Сэлэнгийн дундаж ба нам уулсын мужид, үлдсэн хэсэг нь Хангайн уулсын мужид хамаарагдана. Нутгийн баруун, баруун өмнөд, өмнөд хэсэгт далайн түвшнээс дээш 2400-3500 гаруй метр өргөгдсөн Хангайн нуруу болон түүний салбар уулс, баруун хойд хэсэгт 3000 гаруй метр өндөрт өргөгдсөн Тарвагатайн нуруу, зүүн, зүүн хойд, зүүн өмнөд талаараа далайн түвшнээс дээш 1000-1500

метр өндөрт өргөгдсөн уул толгод, голын хөндий эзэлсэн тал хээрийн бүс нутаг оршино. Түүнчлэн тус аймгийн нутаг дэвсгэрт 1.5-6.0 км<sup>2</sup> талбай бүхий Тэрхийн цагаан нуур, Өгий, Айраг зэрэг томоохон нууруудаас гадна Хангайн нуруу болон түүний салбар уулсаас эх авсан хойд мөсөн далайн ай савд багтах уулын түргэн урсгалт хойд, урд Тамир, Тэрх, Чулуут, Хануй, Хүнүй, Гичгэнэ, Орхон зэрэг томоохон голууд бусад жижиг гол горхитой. Хамгийн өндөр цэг нь Хангайн нурууны Ангархай уул далайн түвшнээс дээш 3540 метр бол хамгийн нам цэг нь Орхон голын хөндий 1000-1300 метрт байдаг.

Ерөнхий нутаг дэвсгэрийн хувьд Хангайн нурууны байрлалаас шалтгаалан баруун өмнөөсөө зүүн хойш намссан байдалтай байна.

Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн хувьд Хангайн нуруу нь Монгол орны байгалийн ерөнхий тэнцвэр, зохилдлогоог хадгалж улмаар ой, тайга, говь, цөлийн аль алиных нь тархалтын хүрээг хязгаарлаж, газар зүйн байрлал, уул зүйн тогтолцоо, ландшафтын тархац, түүний хуваарилалт, орон зайн хувьд яах аргагүй байгалийн бие даасан их мужийг үүсгэдэг онцлогтой юм.

Тус аймгийн газрын гадарга нь геоморфологийн шинжээр дараах гадаргуудаас бүрдэнэ.

**1.Уулт-атираат өргөгдлийн элэгдэл-тектоник гадарга /N-Q /**

а.Өндөр уул, нуруу: Энэ гадаргад нийт нутаг дэвсгэрийн 30 хувь буюу Хангайн нуруу ба түүний салбар уулс, Тарвагатайн нурууны зүүн хэсэг хамрагдана.

б.Дундаж өндөр уул, нуруу: Энэ гадаргад нийт нутаг дэвсгэрийн 50 хувь буюу хойд Тэрх, Чулуут, Хануй, Хүнүй, Хойд Тамир, Орхон голуудын хоорондох хэсэг, Өгий нуурын зүүн урд хэсэг хамрагдана.

**2.Тэгширсэн газар, уулс хоорондын ба уулын доторх хотгор, голын хөндий дэх хурмал хурдаст хотос гадарга /N<sub>2</sub>-Q<sub>1</sub>Q/**

Үүнд: Пролювийн, нуур-пролювийн, гол пролювийн хурдаст тал, мөрөн голын үйлдлээр үүссэн тал, голын хурдаст талын гадаргад хойд, урд Тэрх, Чулуут, Хануй, Хүнүй, хойд, урд Тамир, Орхон голын хөндий, тал газрууд хамрагдах бөгөөд нийт газрын гадаргын 19.4 хувийг эзэлнэ.



**3.Элэгдлийн хэвгий тал:**Геоморфологийн энэ хэв шинж бүхий гадаргад

Батцэнгэл сумын нутаг дахь хойд Тамирын голын хойд эрэг дагуу орших бага хэмжээний газар буюу нийт гадаргын 0.1 хувь хамрагдана.

**4.Ялимгүй сэргэж хэлбэршсэн, нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий үлдмэл уул:**

Геоморфологийн энэ хэв шинжид Булган, Их Тамир сумын зааг Хангайн нурууны салбар уулсын багахан хэсэг хамрагдана /0.2%/

**5.Тэгшрэлийн гадарга /К-Р,N/**

Энэ гадарга нь Хануй, Хүнүй, Орхон голуудыг дагасан хөндий тал газар, Хангайн нурууны зарим хэсэгт хэсэг бүлгээрээ тархсан байх бөгөөд нийт газрын гадаргын 0.3 хувийг эзэлдэг.

**1.2.3. Хөрс**

Архангай аймгийн хөрс нь өндөр уулын ба уулын ойн 4 төрлийн, ойт хээрийн 3 төрлийн, бүс дундын 1 төрлийн хөрснөөс тус тус бүрджээ. Дээрх 8 төрлийн хөрсний талбайг тус бүрт нь нийт нутаг дэвсгэрт эзлэх хувийг тодорхойлбол дараах байдалтай байна. Үүнд:

**1. Хангайн нурууны хойд хэсэгт орших хад асга, ян оргилыг хамарсан өндөр уулын тундрын хөрс.** Энэ төрлийн хөрс нь Хангайн нурууны уул нурууд, нам уул ухаа толгодын хад асга, ян оргилыг хамарч Булган, Чулуут, Хангай, Цахир сумдын нутгийн өмнөд ба баруун хэсэгт алаг цоог маягаар тохиолдоно. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 3 хувийг эзэлдэг.

**2. Өндөр уулын нугын ба нугат хээрийн хөрс.** Энэ хөрс нь Хангайн нуруунаас эх авсан хойд, урд Тамир, Чулуут, Гичгэнэ, хойд, урд Тэрхийн голын бүсэд түгээмэл тохиолдоно. Ялангуяа Цахир сумын нутаг дэвсгэрийн дийлэнх хэсгийг хамардаг. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 16.4 хувийг эзэлдэг.

**3. Уулын тайгын цэвдэгт ухаа шороон хөрс.** Энэ төрлийн хөрс нь Хангайн нурууны хойд хэсэг болон түүний салбар уулсыг бүхэлд нь хамарч тархсан байна. Ялангуяа Чулуут, Гичгэнэ, хойд, урд Тэрхийн голын баруун, зүүн талын өндөр, нам уулсын бүсэд түгээмэл тархаж, нийт нутаг дэвсгэрийн 25.4 хувийг эзэлдэг байна.

**4. Уулын тайгын ширэгт хөрс.** Энэ төрлийн хөрс нь урд, хойд Тамир, Хануй, Хүнүй, Чулуут голын хооронд орших далайн түвшнээс дээш 2000 м, түүнээс дээш орших Хангайн нурууны салбар уулс, Дулаанхан уулын хойд хэсгээр цоохорлон тархсан байдаг. Нийт нутаг дэвсгэрийн 13.4 хувийг эзэлнэ. Ялангуяа Жаргалант сумын нутаг дэвсгэрийн хойд, Цэцэрлэг сумын баруун хэсэгт нэлээн түгээмэл тохиолдоно.

**5. Уул нурууд, нам уул, ухаа толгод болон тал, хөндий, жижиг цав толгодын ойт хээрийн хар шороон хөрс.** Энэ хөрсний төрлийн дийлэнх нь Хануй, Хүнүй голын дунд болон баруун, зүүн хэсэг, далайн түвшнээс дээш 1500-3000 метрийн өндөрт орших уул нурууд, нам, уул, ухаа толгодын хэсгийг хамарч, баруун өмнөөс Хануйн голыг дагаж сунасан байдалтай байна. Тал, хөндий, жижиг цав толгодын хар шороон хөрсний гол цөм нь Цэцэрлэг сумын нутаг дэвсгэрийн зүүн хэсэг, Хануйн голын баруун эргийг хамардаг ажээ.

Уулын ба уулын бус дээрх төрлийн хөрс нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн 10.5хувийг эзэлнэ.

**6. Уул нурууд, нам уул, ухаа толгодын болон тал, хөндий, жижиг цав толгодын хар хүрэн хөрс.** Энэ төрлийн хөрсний уулын хэсэг нь Батцэнгэл сумын нутаг дэвсгэрийн дийлэнх, Цэнхэр, Төвшрүүлэх, Хотонт сумын тодорхой хэсгийг хамарна. Харин уулын бус хэсэг буюу тал, хөндий, жижиг цав толгодын хар хүрэн хөрс нь Хайрхан сумын зүүн хойд, зүүн хэсэгт бага зэрэг, Хашаат сумын нутгийн 90 гаруй хувьд тархжээ.

Түүнчлэн Өндөр-Улаан, Тариат сумдын дунд, Сумангийн голын хөндийг дагаж нэлээд хэмжээгээр тархсан байдаг. Уулын ба уулын бус хар хүрэн хөрс нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн 14.9 хувийг эзэлнэ.

**7. Тал, хөндий, жижиг цав толгодын хүрэн хөрс.** Энэ төрлийн хөрс нь Өлзийт сумын өмнөд, Батцэнгэлийн зүүн хэсэг, Өгийнуур, Хашаат, Хотонт сумын нутаг дэвсгэрийн зарим хэсэгт Орхон, хойд Тамир голын хөндийг даган далайн түвшнээс дээш 1000-1500 метрийн өндөрт Өгий нуурыг тойрон тархсан байна. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 6.0 хувийг эзэлдэг.

**8. Бүс дундын нугын, нугат намгийн, намгийн хөрс.** Энэ төрлийн хөрс нь Орхон, урд, хойд Тамир, Хануй, Хүнүй, урд, хойд Тэрхийн голын хөндийн ай сав газраар ихэвчлэн тархжээ. Ялангуяа хойд, урд Тамир, Орхон голын дагуу хамгийн их тархсан хөрс юм. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 10.4 хувийг эзэлнэ.

#### **1.2.4. Ургамалжилт**

Архангай аймгийн ургамалжилтын хэв шинжийг судалж үзсэний үндсэн дээр өндөр уулын, ойн, уулын хээрийн, хуурай хээрийн, нуурын хөндий, голын

татмын гэж хувааж үзэв. Эдгээрийн дотроос уулын хээрийн бэлчээр ургамлын хэв шинж зонхилж байна. Аймгийн нийт нутаг дэвсгэр дэх ургамалжилтын хэв шинжийг дараах байдлаар ангилж, контур тус бүрийнх нь талбайг тодорхойлон нийт нутаг дэвсгэрт эзлэх хувийг тооцож гаргалаа. Үүнд:

### **1.Өндөр уулын ургамалжилтын хэв шинж**

а.Өндөр уулын хагт, сөөгөнцөрт, улалж-бушилжит хэв шинжтэй ургамлан бүрхэвч. Энэ ургамалжилтын хэв шинж нь аймгийн хамгийн баруун захын сум болох Цахир сумын нутаг дэвсгэр дэх Хойт Тэрхийн голын хойт, баруун, зүүн хэсгээр зонхилон тархжээ. Тариат сумын нутаг–Тэрхийн цагаан нуурын хойд хэсгээр бага зэрэг тархсан байна. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 5.6 хувь орчмыг эзэлнэ.

б.Өндөр уулын хүйтсэг-чулуусаг бүлгэмдэл, бушилж-улалжит нуга. Энэхүү хэв шинж нь Хангайн нурууны арыг даган тархсан байх бөгөөд урд, хойд Тамир, Чулуут голын эхээр зонхилж нийт нутаг дэвсгэрийн 3.4 хувийг эзэлнэ.

### **2.Ойн бүрхэвч**

Судалгааны үндсэн дээр Архангай аймгийн ойн бүрхэвчийг ургамалжилтын байдлаар нь доорх төрлүүдэд хуваан үзэж байна.

**а. Сөөгт, ботууль, сөөгөнцөр хөвдөт, цармын шинэс, хушин ой.** Энэ төрлийн ой нь нийт ойн сангийн 4.5 хувийг эзлэх бөгөөд Хангайн нурууны ар, Тариат сумын нутгийн хойд хэсэг, Жаргалантын баруун хойд хэсэг зэрэг газраар бага хэмжээний нутаг дэвсгэрт цоохорлон тархжээ.

**б. Ногоон хөвдөт, сургарт, алирст бадаант, тэрэлжит, хааяа жодоо, гацуур оролцсон хуш, шинэсэн тайгын ой.** Ийм ургамалжилтыг агуулсан ой нь нийт ойн сангийн 2.2 хувийг эзлэх бөгөөд Цэнхэр сумын нутгийн өмнөд хэсгээр бага хэмжээний талбайд тархжээ.

**в. Алаг өвс-ритидиум хөвдөт, алирс-ритидиум хөвдөт, туйдиум хөвдөт тайгажуу шинэсэн ой.** Ийм төрлийн ургамалжилттай ойн дийлэнх хэсэг нь Хануй, Хүнүй голын дунд Хайрхан, Эрдэнэмандал, Их Тамир, Батцэнгэл сумдын нутгаар тархсанаас гадна Булган, Цэнхэр, Төвшрүүлэх сумдын урд хэсгээр хэсэг бүлгээрээ тархаж нийт ойн сангийн 6.8 хувийг эзэлдэг байна.

**г. Алаг өвс-цахилдагт, үетэн-алаг өвст, алаг өвс-улалжит, баврант, сорвоот шинэс нарсан ба орлож ургасан хусан тайгархаг ой.** Энэ төрлийн ой нь Хангайн нурууны араас эхлэн Хануй, Чулуут голын хоорондох уул нуруудыг даган Жаргалант, Өндөр-Улаан, Чулуут сумдын нутгийг дамжин тархсан байна.

Ялангуяа Жаргалант сумын нутгийн төв хэсгээр дийлэнх нь бусад хэсгээр алаг цоог хэлбэрээр тархжээ. Ийм ой нь нийт ойн сангийн 6.1 хувийг эзэлдэг.

### **3.Уулын хээр**

Аймгийн нутаг дэвсгэрт уулын хээрийн ургамалжилт бүхий 3 төрлийн ургамлан бүрхэвч тархсан байна гэж үзэж болно. Үүнд:

**а. Алаг өвс-дааган сүүлт ургамлан бүрхэвч.** Энэ төрлийн ургамлын бүрхэвч нь Хануй, Хүнүй, Тэрх, Суман голыг дагасан нам дор газруудаар зонхилон тархсан бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 6.8 хувийг эзэлдэг.

**б. Зүр өвст, алаг өвс-үетэнт, хиаг-хялгана, сөөгт ургамлан бүрхэвч.** Дээрх ургамлын бүрхэвч нь Цэцэрлэг сумын нутаг, Булган, Цэнхэр, Төвшрүүлэх, Хотонт сумын нутагт зонхилно. Зарим сумдын нутгаар алаг цоог хэлбэрээр тааралдана. Нийт нутгийн 9.0 хувийг эзэлнэ.

**в. Алаг өвс-жигж үетэнт, үетэн-улалж-ботуульт ургамлан бүрхэвч.** Энэ төрлийн ургамлан бүрхэвч нь аймгийн нийт нутаг дэвсгэрт жигд байдлаар хамгийн их тархсан бөгөөд нийт нутгийн 40.9 хувийг эзэлдэг. Уулын хээрийн ургамалжилт бүхий дээрх 3 төрлийн ургамлан бүрхэвч нь аймгийн гол бэлчээрийн газрыг бүрдүүлэх бөгөөд ерөнхий дүнгээрээ нийт нутаг дэвсгэрийн 56.7 хувийг эзэлдэг.

### **4.Хуурай хээр**

Хуурай хээрийн харгана, жигж үетэн хялганат, чулуулаг алаг өвс ботуульт ургамлан бүрхэвч нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн 10.2 хувийг эзлэх бөгөөд зөвхөн Өлзийт, Өгийнуур, Хотонт, Хашаат сумдын бэлчээр нутгийн гол цөмийг бүрдүүлдэг байна.

**5.Нуурын хөвөө, голын татмын ургамалжилттай бургас, улиас, хааяа шинэс, гацуур бүхий улалжит, үетэн-алаг өвст, дэрст ургамлан бүрхэвч** нь хойд Тамир, Орхон голыг дагасан хөндийгөөр тархсан бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 4.5 хувийг эзэлнэ.

#### **1.2.5. Ус зүй**

Архангай аймгийн нутаг дэвсгэр дэх Хангай нуруунаас эх авсан томоохон голууд нь газрын гадаргуугийн усны нөөцийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг бөгөөд Хойд мөсөн далайн ай сав нутагт хамаарагддаг байна. Энэ ай савд хамгийн их устай Сэлэнгэ мөрөн цутгал голуудынхаа хамт /Идэр, Дэлгэрмөрөн, Эг, Шишхэд гол/ Хүрэмтэй ба түүний цутгал голууд багтана. 2003 онд явуулсан Монгол орны гадаргын усны тооллогын нэгдсэн дүнгээс үзэхэд Архангай аймгийн нутаг дэвсгэрт нийт 546 гол горхи, 474 булаг, шанд, 31 рашаан, 249 нуур, тойром байдгаас 124 гол горхи, 123 булаг шанд, 3 рашаан, 32 нуур тойром ширгэсэн

гэсэн мэдээ бий. Энэ нь дэлхийн цаг агаарын дулааралт, байгаль-экологийн зарим хүчин зүйлээс шалтгаалсан гэж үзэж байна.

Гидрогеологийн нөхцөлийн хувьд нийт нутаг дэвсгэрийн 12.4 хувийг алаг цоог тархалттай ундарга ихтэй эсвэл их тархалттай бага, дунд ундрагатай устай давхарга, 70.7 хувийг газар доорх алаг цоог, хязгаарлагдмал нөөц бүхий устай сэвсгэр, тунамал бялхмал хувирмал чулуулагтай давхарга, 16.9 хувийг хүчиллэг, дундаж хүчиллэг, суурилаг, түрмэл чулуулагтай давхарга тус тус эзэлнэ.

Түүнчлэн галт уулын /Тэрхийн цагаан нуур, Хөдөө нуур/, тектоник хөдөлгөөний /Дөрөө цагаан, Өгий, Хөх нуур/, голын хөндийн /Өгий, Их нуур/ гарал үүсэлтэй нууруудаас гадна 5 км<sup>2</sup>-аас бага талбайтай эмчилгээний шавартай болон шаваргүй нуурууд тус аймгийн гадаргын ус зүйн сүлжээг бүрдүүлдэг.

Үүний зэрэгцээгээр тус аймгийн нутаг дэвсгэр нь азотын халуун рашааны мужид хамрагдах бөгөөд Цагаан сүм, Бор тал, Цэнхэр, Шивэрт, Чулуут, Улаан эрэг, Ноёнхангай зэрэг азотын хэд хэдэн халуун рашаантай. Мөн Хангайн нурууны ар болон түүний салбар уулуудаас эх авсан Орхон, хойд, урд Тамир, Хануй, Хүнүй, Чулуут, хойд, урд Тэрх зэрэг томоохон голууд гадаргын ус зүйн сүлжээг баяжуулж өгдөг байна. 2003 оны усны тооллогоор тус аймагт 965 худаг тоологдсоноос инженерийн хийцтэй 861, үүний дотор гүн өрмийн 250, богино яндант 300, бетонон хашлагатай 311 худагтай аж. Дээрхээс гадна энгийн уурхайн 104 худаг тоологдсон байна.

Гэхдээ гүний болон гадаргын усны хангамж нь бэлчээр усжуулалтын асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байгааг цаашид анхаарах ёстой.

Аймгийн нутаг дэвсгэрт байгаа нийт уст цэгийн 770 нь бэлчээрт байдаг бөгөөд үүний дотор гүн өрмийн 175, богино яндант 285, бетон хашлагат 229, бүгд 689 инженерийн хийцтэй худаг, 81 энгийн уурхайн худаг бэлчээрийн усан хангамжид ашиглагдаж байгаа тооцоо, судалгаа бий.

2001 оны гадаргын усны чанарын үнэлгээ, хяналт, шинжилгээний дүнгээр бохирдлын индексийг тооцож, усны чанарын зэргийг тогтоон үнэлгээ өгчээ. Бохирдлын индексийг бохирдуулагч бодисын тархац, хор хөнөөлийн зэрэг, хүчин зүйлүүдийг үндэслэн усанд ууссан хүчилтөрөгч, хялбар исэлдэх органик бодис, эрдэс азот болон фосфор, хром, зэс зэрэг хүнд металлуудаас 6-аас доошгүй үзүүлэлтүүдийг сонгон авч, жилийн дундаж агууламжийг нь “-4586-98” гэсэн “Усны чанарын стандарт”-тай харьцуулан гаргадаг.

Архангай аймгийн нутаг дэвсгэр дэх томоохон голуудын усны чанарын үнэлгээг дараах хүснэгтээс харж болно.

**Усны чанарын үнэлгээ**

№	Гол мөрөн-харуул	Бохирдлын индекс	Усны чанарын	
			зэрэг	Ангилал
1	Чулуут-Өндөр-Улаан	0.32	II	Цэвэр
2	Гичгэнэ-Тариат	0.42	II	Цэвэр
3	Суман-Тариат	0.34	II	Цэвэр
4	Хануй-Эрдэнэмандал	0.30	I	Маш цэвэр
5	Орхон-Хархорин	0.14	I	Маш цэвэр
6	Хойд Тамир-Ихтамир	0.26	I	Маш цэвэр
7	Урд Тамир-Цэцэрлэг	0.61	II	Цэвэр

Дээрх хүснэгтээс үзэхэд аймгийн томоохон голууд бохирдлын индексээрээ цэвэр, маш цэвэр гэсэн ангилалд багтаж байна.

**1.3.Нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдал**

**1.3.1.Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл ба дэд бүтцийн хөгжил**

Тус аймгийн нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл нь МАА, газар тариалан, хүний нөөц, аялал-жуулчлал, дэд бүтцийн хөгжил юм. Аймгийн нийт хүн амын тоо 2001-2004 онд 4 жилийн дунджаар 96.7 мянга болж, үүнээс 80 орчим хувь нь хөдөөд амьдардаг нь судалгаанаас харагдаж байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 4 жилийн дунджаар 42 хувийг эзэлж байна.

Хэдийгээр шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан аймгийн нийт хүн амын тоо жилээс жилд буурч байгаа боловч дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /оны дүнгээр/ жил бүр өсөж, 2004 оны байдлаар 33.4 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 79.3 хувийг, аж үйлдвэр, барилга 1.6 хувийг, бусад үйлчилгээний салбар 19.1 хувийг тус тус эзэлж байна. Орон нутгийн төсвийн орлого сүүлийн 4 жилийн дунджаар 1657.0 сая төгрөг болж, урсгал орлого жил бүр нэмэгдсээр иржээ. Судалгаанаас үзэхэд тус аймаг нь улсын төсвөөс жилд дунджаар 1478.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авдаг байна. Иймээс аймгийн нийгэм-эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд дотоод нөөц, боломжоо нээн илрүүлж, бүрэн дүүрэн ашиглах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь аймгийн нийгэм-эдийн засгийн гол суурь нөхцөл болж, дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 79.3 хувийг эзэлж байгаа тул цаашид МАА, газар тариалангийн салбарыг орчин үеийн зах зээлийн нөхцөлд зохицуулан эрчимтэй хөгжүүлэх бодлого барих нь зүйтэй юм. Аймгийн төв нь нийслэл Улаанбаатар хотоос 521 км алслагдсан бөгөөд, үүний 430 км замыг хатуу хучилттай, 80 км-ийг нь сайжруулсан шороон зам эзэлдэг. Өөрөөр хэлбэл, нийт замын 82.5 хувийг хатуу хучилттай зам эзэлж байгаа юм. Энэ нь

**-Газрын мэргэжлийн байгууллага – Цогтхангай ХХК –**

аймгийн нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх харьцангуй давуу талыг илэрхийлж байна. Түүнчлэн “Мянганы зам” хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн Өгий нуур, Батцэнгэл, Тариат, Цахир, Хашаат зэрэг сумд мянганы замын хэвтээ болон босоо тэнхлэгт хамрагдаж байгаа нь асар их ач холбогдолтой юм. Үүнээс гадна аймгийн бүх сумд эрчим хүчний системд холбогдож, улмаар “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөрт заагдсан Улаанбаатар-Улиастайн чиглэлийн өндөр хүчин чадалтай цахилгаан шугам сүлжээний систем аймгийн нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх хэтийн төлөв байгааг анхаарч үзэх нь зүйтэй. Аймгийн нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдалд дүгнэлт хийхийн тулд дараах нөлөө бүхий хүчин зүйлүүдийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

**1.3.2.Хүн ам.**

Архангай аймгийн суурин хүн амын тооны бууралт нь хот, хөдөөгийн хүн амын шилжилт хөдөлгөөнтэй шууд холбоотой юм. 2001 онд суурин хүн амын тоо 98.3 мянга байсан бол 2004 онд 94.9 мянга болж 3, 4 мянгаар буурчээ. Мөн үүнтэй холбоотойгоор нийт өрхийн тоо 2001 онд 25.6 мянга байсан бол 2004 онд 24.3 мянга болж 1.3 мянган өрхөөр багасжээ. Дээр дурьдсан болон бусад үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

**Аймгийн хүн амын зарим статистик үзүүлэлтүүд\***

№	Статистик үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Онууд			
			2001	2002	2003	2004
1	Суурин хүн амын тоо	Мян.хүн	98.3	97.4	96.1	94.9
2	Суурин хүн амын хот, хө-дөөгийн харьцаа хот/хөдөө	%	18.4	18.6	18.8	19.2
			81.6	81.4	81.2	80.8
3	Өрхийн тоо	Мян.өрх	25.6	25.0	24.7	24.3
4	Өрхийн тоо /хот/хөдөө/	Мян.өрх	4.2	4.1	4.2	4.2
			21.4	20.9	20.5	20.1
5	1000 хүнд ногдох хүн амын төрөлт	Хүн	24.5	22.6	19.6	18.2
6	1000 хүнд ногдох нас баралт	Хүн	6.5	6.5	6.7	6.1
7	Эдийн засгийн идэвхтэй хүн ам	Мян.хүн	41.0	41.1	40.4	39.4
8	Ажиллагчдын тоо	Мян.хүн	39.2	39.6	38.7	37.9
9	Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	Хүн	1805	1546	1715	1521
10	Ажилгүйдлийн түвшин	Хувь	4.4	3.8	4.2	3.8
11	Хүн амын цэвэр өсөлт	Хувь	1.8	1.6	1.3	1.1

\*- “Монгол Улсын статистикийн эмхтгэл –2004” УБ.2005 оны номоос авлаа

2001-2004 оны статистик үзүүлэлтүүдээс харахад сүүлийн 4 жилийн дунджаар суурин хүн амын 18.7 хувь нь хотод, 81.3 хувь нь хөдөөд амьдарч байна.

2004 оны байдлаар 24.3 мянган өрхийн 17.3 хувь нь хотод 82.7 хувь нь хөдөөд амьдарч байна. Хотын хүн амд аймгийн төв, тосгоны хүн амыг оролцуулан тооцсон бол хөдөөгийн хүн амд сумын төв, хөдөөгийн /баг/ хүн амыг хамруулав.

Хүн амын цэвэр өсөлт буурч байгаа нь хүн амын өсөлтийн хурдац буурахад гол нөлөө үзүүлжээ. Тухайлбал: 1000 хүн амд ногдох төрөлт 2001 онд 24.5 байсан бол 2004 онд 18.2 болж, 2001 оны түвшингээс буурчээ.

Үүнтэй уялдан хүн амын цэвэр өсөлт 2001 оныхоос 0.7 хувиар буурч 1.1 хувь болсон байна. Олон улсын хүн ам зүйн үзүүлэлтээр цэвэр өсөлтийн хувь 0.1-0.5 хувь байвал өсөлт удааширсан, 0.6-1.0 хувь байвал хүн ам дунд зэрэг өсөж байгаа, 1.1-2.0 хувь байвал хүн ам хурдан өсөж байна гэж үздэг ажээ. Үүнээс үзвэл аймгийн хүн амын цэвэр өсөлт хэдийгээр буурсан ч 1.1 хувь байгаа тохиолдолд хүн ам хурдан өсөх магадлал байна гэсэн үг юм. Гэхдээ шилжилт хөдөлгөөн, төрөлт, нас баралт зэргийг харгалзан үзэхээс гадна эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, ажиллагчдын тоо, ажилгүйдлийн түвшинг мөн харгалзан үзэх шаардлагатай. Статистик мэдээллээс үзэхэд эдийн засгийн идэвхтэй хүн ам 2001 онд 41.0 мянга байсан бол 2004 онд 39.4 мянга болж 1.6 мянган хүнээр, ажиллагчдын тоо 1.3 мянган хүнээр тус тус буурч байхад бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2001 онд 1805 байсан бол 2004 онд 1521 болж 284 хүн ажлын байртай болсон мэт сэтгэгдэл төрүүлж байна. Ажилгүйчүүдийн түвшин мөн л 0.6 хувиар буурч, олон ажлын байр шинээр бий болсон юм шиг харагдана. Гэтэл хамгийн гол нь аймгийн суурин хүн амын тоо жилээс жилд буурч байгаа нь хүн амын механик шилжилт хөдөлгөөн болон ажлын байрны олдоцтой шууд холбоотой гэсэн дүгнэлт гарч байна.

Аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжил нь жижиг дунд үйлдвэрлэлийн өсөлт, дэд бүтцийн хөгжил, амьдрах орчин нөхцөл, зах зээлийн алслалт, хүн амын нөөцөөс шууд хамаарна гэдгийг бид анхаарах ёстой.

### **1.3.3. Мал аж ахуй**

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2004 онд 33.4 тэрбум /оны дүнгээр/ болж, 2001 оныхоос 4.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна. Үүний дотор ХАА-н бүтээгдэхүүний борлуулалт 79.3 хувийг эзэлж байгаагаас МАА-н бүтээгдэхүүн голложээ. Энэ нь аймгийн нийгэм-эдийн засагт МАА тэргүүлэх байр суурь эзэлдгийг харуулж байгаа юм. Аймаг 2001 онд 1836.1 мянган толгой малтай байсан бол 2004 онд 1948.2 мянга, 2005 онд 2194.9 мянган толгой малтай болж, 2002 оныг эс тооцвол малын тоо толгой байнга өсжээ. Энэ нь байгаль-цаг уурын нөхцөл, хүний хүчин зүйлтэй холбоотой нь мэдээжийн хэрэг.

Тус аймаг нь нийт малынхаа тоогоор /2004 оны байдлаар/ Хөвсгөл, Өвөрхангай, Увс аймгийн дараа ордог. Үүнээс улсад адуугаараа I, үхрээр II, хониор V байранд тус тус ордог ажээ.



**-Газрын мэргэжлийн байгууллага – Цогтхангай ХХК –**

Аймгийн ИТХ, ЗДТГ, Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслөөс сүүлийн 70 жилийн хугацаанд байсан малын тоо, бэлчээрийн багтаамжид судалгаа хийж үзжээ. Судалгаанаас үзэхэд 1936-1938 онд аймгийн түүхэнд хамгийн олон буюу 3352.3-3658.9 мянган мал, 1986 онд хамгийн цөөн буюу 1211.0 мянган толгой мал тоологдож байсан байна.

**Аймгийн МАА-н зарим статистик үзүүлэлтүүд**

№	Статистик үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Онууд			
			2001	2002	2003	2004
1	Малын тоо /бүгд	Мян.тол	1836.1	1748.8	1837.8	1948.2
	Үүнээс: -Тэмээ	-"	0.6	0.7	0.7	0.7
	- адуу	-"	216.7	197.7	192.6	191.2
	- үхэр	-"	277.3	253.4	230.9	231.7
	- хонь	-"	831.6	769.9	806.6	861.1
	- ямаа	-"	509.9	527.1	606.7	663.6
2	Хээлтэгч малын тоо бүгд:	-"	-	721.5	772.5	804.3
	Үүнээс: - Ингэ	-"	-	0.2	0.2	0.2
	- Гүү	-"	-	59.1	56.7	55.3
	- үнээ	-"	-	97.7	87.7	88.2
	- хонь	-"	-	338.1	366.0	379.7
	- ямаа	-"	-	226.4	261.8	280.9
3	Малчин өрхийн тоо	Өрхийн тоогоор	18006	17040	17077	16065
4	Малчдын тоо	Тоогоор	35880	34053	33983	31648

1990 оноос хойш малын тоо тасралтгүй өсөж, 1999 онд 2335.5 мянган толгойд хүрсэн нь сүүлийн 57 жилд тоологдсон хамгийн олон мал байжээ. Энэ тоо нь 2005 оны эцсийн мал тооллогын дүнтэй харьцуулахад тун ойролцоо тоо юм. Гэвч МАА-г хэвийн байлгахын тулд хамгийн наад зах нь бэлчээр, тэжээлийн нөөц, бэлчээр усжуулалт, хашаа саравчны хангамжийг зайлшгүй тооцох ёстой.

Судалгаанаас үзэхэд Архангай аймгийн бэлчээрийн ердийн даац /2003 оны байдлаар/ хонин толгойд шилжүүлснээр 3710.0 мянган мал агуулах чадалтай юмсанж. 2005 оны эцсийн мал тооллогоор тус аймаг нь хонин толгойд шилжүүлснээр 4476.8 мянган толгой малтай болжээ. Тэгвэл бэлчээрийн даац /ердийнх/ 766.8 мянган толгой малаар хэтэрч байгаа нь бараг нийт ямаан сүргийн тоотой тэнцэж байгаа юм. Гэтэл эрдэмтдийн судалгаагаар аймгийн нийт бэлчээрийн 23 хүртэл хувь нь /хамгийн багаар тооцоход/ ямар нэг хэмжээгээр талхагдалд орсныг тогтоожээ.

Үүний гол шалтгаан нь бэлчээрийг улирлын хуваарьтайгаар сэлгэн ашигладаггүй, нэг нутаг бэлчээртэй жилийн 4 улирлын турш малаа бэлчээдгээс үүдэлтэй юм. Тухайлбал, малчдад хамгийн бэлчээр шаардлагатай амин чухал

үе нь өвөл-хаврын улирал гэдэг. Энэ улиралд л зун-намар ашиглаагүй соргог сормуун бэлчээр малд нь өндөр ач холбогдолтой байдаг.

Гэтэл тус аймагт зун-намрын алслагдсан отрын бэлчээр нутаг ашиглалт бараг байхгүй байгаа учраас өвөл-хаврын бэлчээрээ зун-намар нь давтан ашигласнаар бэлчээр ашиглалтын хувь нь тухайн бэлчээр нутагт бараг 110.0-280.9 хувьтай байгааг судлаачид тогтоосон байна. Үүнд л бид дүгнэлт хийх ёстой болж байна. Иймээс цаашид малын тоо толгойг уралдан өсгөх /экстенсив арга/ биш бэлчээрийн нэгж талбайд цөөхөн мал агуулж /интенсив арга/ өндөр ашиг шим хүртэх мал аж ахуйг эрхлэх нь зах зээлийн эдийн засагт тохирох юм.

Үүнээс гадна тус аймгийн тэргүүлэх салбар МAA-г хөгжүүлэхэд орон нутгийн торгон сүрэг, сүргийн бүтэц, үүлдэр угсаа, нэгжийн ашиг шимийн өгөөж, зоо-мал эмнэлгийн үйлчилгээ зэргийг харгалзан үзэх нь чухал.

Статистик мэдээллээс харахад тус аймагт 2001 онд 18006 малчин өрх байсан бол 2004 онд 16065 болж 1941-ээр буурсан нь хөдөөгийн ядууралд гүнзгий нөлөөлж байгааг анхаарахгүй байж болохгүй. Малчдын тоо ч мөн үед 4232-оор багассан байна. Малын тоо толгой жилээс жилд өссөөр байхад дээр дурдсан үзүүлэлтүүд буураад байдагт хамгийн гол хэргийн учир байгаа юм.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засгийн өгөөжийн талаар мөн бодолцох хэрэгтэй юм.

1996 оны байдлаар /тэр үед 1725.1 мянган толгой малтай байж/ мах, сүүнээс гадна жилд дунджаар 900 тн уртын ноос, 56.5 тн ноолуур, 100 тн бодын хөөвөр, 21000 ширхэг үхрийн шир, 120000 ширхэг хонины арьс, 28000 ширхэг ямааны арьс зэрэг түүхий эд үйлдвэрлэдэг байсныг одоогийн зах зээлийн үнээр тооцвол нэлээд өндөр тоо гарах нь дамжиггүй. Үүнээс хойш малын тоо /2005 оны эцсийн тооллогоор/ 2194.9 мянган толгой болсон нь тэр үеийнхээс даруй 469.8 мянган толгой малаар нэмэгдсэн бөгөөд тэр хэмжээгээр аймгийн нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь дээшилнэ гэсэн үг.

Иймээс цаашид МAA-г эрчимжсэн технологиор эрхэлж, бэлчээрийн даац, усан хангамж болон бусад үйлчилгээг зах зээлийн нөхцөлд зохицуулан өөрчлөх нь ХAA-н салбарын бодлогын менежментийн нэг хэсэг болох учиртай. Ялангуяа бэлчээрийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийг зөв хийх нь онцгой чухал юм. МAA болон бусад үйлдвэрлэлээр дамжин бэлчээрийн газрын үнэ цэнэ тодорхойлогдоно гэдэгт бид онцгой анхаарах ёстой.

#### **1.3.4.Газар тариалан**

Тус аймаг нь нийт 57.2 мянган га эргэлтийн талбайтай бөгөөд талбайн ихэнх нь Хайрхан, Төвшрүүлэх, Хотонт, Өгийнуур сумын нутаг дэвсгэрт оршдог

ажээ. Өнөөгийн байдлаар нийт эргэлтийн талбайн 90.7 хувь нь атаршиж, 9.3 хувь нь үр тариа, төмс-хүнсний ногоо тариалахад ашиглагдаж байна.

Ялангуяа дулааны нийлбэр нь 1950 градусаас доош байдаг ХАА-н уур амьсгалын чийглэг хүйтэн, чийглэг хүйтэвтэр, чийглэгдүү сэрүүн мужуудад оршдог сумдын тариалангийн талбайнууд атаршаад 10-20 жил болж байгаа аж. Атаршсан талбайнуудын дийлэнхи нь Хангай нурууны өндөр уулс ба түүний салбар уулсын бүс нутагт хамрагдах бөгөөд хамгийн гол нь хөрсний үржил шим, дулааны хангамж төдийлөн сайнгүй зэрэг байгаль-цаг агаарын онцлогтой шууд холбоотой. Гэхдээ урьд өмнө нь эдгээр талбайнуудыг боломжоороо ашиглан тодорхой хэмжээнд ургац авч байсан түүх бий. Тухайлбал, 1989 онд тус аймаг нь түүхэндээ хамгийн өндөр ургац буюу 46.7 мянган тн үр тариа, үүний дотор 31.4 мянган тн улаан буудай, 5.8 мянган тн төмс-хүнсний ногоо, 1995 онд үр тариа 10582 тн, төмс-хүнсний ногоо 1558 тн-ыг тус тус хураан авч байжээ.

Сүүлийн жилүүдийн /2001-2004 он/ дунджаар 3062.1 га-д газар тариалан эрхэлж 2677.5 га-д үр тариа, 100.2 га-д хүнсний ногоо, 268.1 га-д төмс, 32.5 га-д малын тэжээл тариалж, аймгийн дүнгээр 3710.9 тн ургац авсан байна. Нэгэн үед тус аймгийн газар тариалан нь МАА-н үйлдвэрлэлийн дараа орох гол үйлдвэрлэл болон хөгжиж, аймгийн нийгэм-эдийн засгийг бэхжүүлэх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, МАА-г тэжээлийн нөөцөөр хангахад чухал ач холбогдолтой байв.

Гэвч тариалангийн талбайн ашиглалт 1990 оны үеэс эхлэн эрс уналтад орж, ялангуяа өндөр уулын бүсийн талбайнууд хаягдахад хүрснээс олон зуун сая төгрөгийн эдийн засгийн нөөцөө алдаж байгаа юм. Мөн хэд хэдэн газар энгийн болон инженерийн хийцтэй услалтын систем байгуулан ашиглаж байсан байна. Тухайлбал, энгийн хийцтэй услалтын системтэй Хашаат сумын Цайдам /130 га/, Цэнхэр сумын Хонгорын ам /1341 га/, Булган сумын Ар бэлийн өрөмдмөл худаг /16 га/ зэрэг тариалангийн газраас гадна хуучин инженерийн хийцтэй услалтын системтэй Цэнхэр сумын Ширгүү /408 га/, Батцэнгэл сумын Сүүл толгой /255 га/, Булган сумын Ар бэл /258 га/ зэрэг усалгаатай тариалангийн талбай ашиглагдаж байжээ. Эдгээрээс гадна урьд нь ТЭҮ нь хийгдсэн боловч ашиглалтад ороогүй Хонгоржийн тал, Хотонт сумын Талын балгас дахь услалтын систем ч байгаа.

Дээрх услалтын системүүдийг сэргээн ашиглах талаар багагүй яригдаж байгаа ч ашиглагдах хамгийн өндөр магадлалтай нь Батцэнгэл сумын Сүүл толгойн услалтын систем юм.

Үүнээс үзэхэд Архангай аймагт үр тариа, малын тэжээл, төмс-хүнсний ногоо тариалж, аймгийнхаа нийгэм-эдийн засгаа тэтгэн хөгжүүлэх өргөн боломж

байгаа бөгөөд гагцхүү тариалангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийг боловсронгуй болгох асуудал хурцаар тавигдаж байна.

### **1.3.5. Аялал жуулчлал, амралт, рашаан сувилал болон бусад үйлдвэрлэл үйлчилгээ**

Аймгийн нийгэм-эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд байгаль бүс нутгийн давуу талууд буюу бүхэлдээ онгон төрхөөрөө хадгалагдаж үлдсэн байгалийн өвөрмөц тогтолцоо, эртний түүхийн дурсгалт газрууд, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглүүлэн тус аймагт аялал жуулчлал, амралт, рашаан сувилал хөгжүүлэх өргөн боломжтой юм. Өнөөдрийн байдлаар тус аймагт албан ёсны зөвшөөрөлтэй аялал жуулчлалын 560 орчим хүчин чадал бүхий 13 жуулчны түр бааз улирлын чанартай ажиллаж 7500 гаруй жуулчид, аялагчдыг авч үйлчилж байна. Эдгээрийн 15 орчим хувь нь гадаадынх бөгөөд тодорхой график маршрутаар үйлчлүүлдэг. Тус аймаг ИХТ-ын Тэргүүлэгчдийн хурлаараа “Архангай аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж жил бүр хэрэгжилтийг нь зохион байгуулж байна.

Энэ хөтөлбөртөө аялал жуулчлалыг хөгжүүлэх 4 үндсэн сүлжээ байхаар тодорхойлж, тэдгээр нь тус тусдаа аялал жуулчлалын өвөрмөц бүтээгдэхүүн нийлүүлэх, тус тусын гарцтай байхаар тодорхойлжээ. Тухайлбал:

- а/ Хөшөө Цайдам, Өгийнуурын бүс
- б/ Цэцэрлэг хот, Тайхарын бүс
- в/ Тэрх, Цагааннуур, Чулуут голын бүс
- г/ Хануй, Хүрэм, Мухар Хужиртын бүс

гэсэн 4 бүстэй байхаар тусгасан байна.

Архангай аймгийн аялал жуулчлал голлон хөгжиж байгаа газар нутаг нь Өвөрхангай аймгийн Хархорин сумаас цааших төв замын дагуух хил залгаа нутаг, Хорго-Тэрх болон Ноёнхангайг багтаасан Хангай нурууны байгалийн цогцолборт газрууд юм.

Улсын ТХГН-т хамрагдсан газраас 1860.8 га нь Булган уулын дурсгалт газар бусад нь Хорго-Тэрхийн цагаан нуур, Ноёнхангайн БЦГ-т багтана.

Хөшөө Цайдам-Өгийнуурын аялал жуулчлалын бүс нутагт Хотонт сумын Хар балгас, Дойтын толгойн туурь, Хөшөө Цайдам, Цэнхэр, Цагаан сүмийн халуун рашаан, Өгийнуур зэрэг түүх дурсгалын болон болон рашаан сувиллын эх үүсвэрүүд орно.

Цэцэрлэг хот-Тайхарын бүс нутагт Булган уул, Тайхарын чулуу, хойд, урд Тамир, Чулуут, Хануй, Суман гол, Хөх нуур зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд хамаарагдана. Тэрх, Цагааннуур, Чулуут голын бүсэд Хорго, Тэрхийн Цагаан

нуур, Чойдогийн боргио, Шар нохойн там, Мөсөн хонгил, Ноёнхангайн рашаан зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд багтана. Хануй, Хүрэн, Мухар хужиртын бүс нутагт Эрдэнэмандал сумын Хар хул хааны балгас, Их Ханангийн нуурын бичээс, Хануйн рашаан Шивэртийн халуун рашаан, Гал мод, Цацын дэнж зэрэг түүхийн дурсгалт газрууд багтдаг байна.

Сүүлийн үед Хануйн рашаан, Цагаан сүм, Улаан эрэг, Цэнхэр, Чулуут, Шивэртийн халуун рашаануудад дотоодын амрагчид олноороо очиж, 7-14 хоног хувиараа амарч биеэ сувилах болсон нь тэнд албан ёсны рашаан-сувиллын тав тухтай орчинг бүрдүүлэх шаардлагатайг харуулж байна. Иймээс аялал жуулчлалын чиглэлээрх асуудлуудыг хот, тосгон бусад суурин газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментэд тодорхой тусгаж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Аялал жуулчлал, рашаан сувиллаас гадна аймгийн нийгэм-эдийн засгийг хөгжүүлэхэд онц чухал нөлөө үзүүлэх нэг салбар нь геологи-уул уурхайн салбар юм. Тус аймгийн нутаг дэвсгэрт металл ба металл бус ашигт малтмалын орд, илэрцүүд нэлээд хэмжээгээр байгаа нь дунд масштабын геологийн эрэл зураглал, эрэл хайгуул болон сэдэвчилсэн хайгуулын судалгаагаар тогтоогдсон боловч түүний дагуу нарийвчилсан эрэл хайгуул шаардлагын түвшинд хийгдээгүй байгаа нь ажиглагдаж байна.

Тус аймгийн хэмжээнд 2004 оны байдлаар хайгуулын болон ашиглалтын 124 лиценз ААН, иргэдэд олгогдож, нийт 1678.3 мянган га газрыг хамруулсан баримт бий. Гэтэл Цэнхэр сумын нутаг дахь алтны уурхайн олборлолтыг эс тооцвол ашигт малтмалын эрэл хайгуул, ашиглалт хангалтгүй байгаа юм.

Сүүлийн үед геологийн эрэл хайгуулын явцад Хотонт сумын нутаг Цагаан сүмийн гол орчмын цагаан тугалганы  $78.4 \text{ г/м}^3$  агуулгатай шороон орд, Хангайн Хэц уулын гянт, төмрийн орд /нөөц нь  $\text{C}_2$  зэргээр 57-60 сая тн/ зэргийг илрүүлснээс гадна Жаргалант, Өлзийт, Чулуут сумын нутагт хийгдсэн 1:50000-ын масштабын геологийн эрэл-зураглалын ажлын явцад Жаргалантын Их-Элэгдэйн шороон ордод  $\text{P}_2$  зэрэглэлээр алтны нөөцийг нь 60 кг гэж тогтоожээ. Түүнчлэн Тариат сумын өнгөлгөөний болон гоёл чимэглэлийн чулууны ордын анар  $\text{C}_2$  зэрэглэлээр 144.7 мянган тн, саран чулуу /Хризолит/  $\text{C}_2$  зэрэглэлээр 24.0 мянган тн, Их Тамир сумын Мөнгөтийн мөнгөний заараг ордын нөөц  $\text{P}_2$  зэрэглэлээр 800 кг-аар тус тус тогтоогдсон байна.

Өгийнуур сумын нутагт нүүрс, каолины батлагдсан нөөцтэй ордууд нээгдсэн бөгөөд элс, шохойн чулуу, хайрга, галт уулын шаарга зэргийг барилга, замын байгууллагууд ашигласаар байгааг дурдах нь зүйтэй. Нөөц нь тогтоогдсон дээрх ордуудаас гадна Цахир сумын нутаг дахь хойд Тэрх голын дагуу байгаа скарны гаралтай зэс, Хануй, Хүнүй, Чулуут голын дагуух гидротермасль гаралтай зэс, зэс-анзан, Өгийнуур, Өлзийт, Өндөр-Улаан, Чулуут, Хангай, Тариат сумын нутагт байгаа скарны, тунамал, маагмын гарал үүсэлтэй төмрийн илэрлүүдийг нарийвчлан судалж, нөөцийг нь тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн Архангай аймгийн нутаг дэвсгэрт Монголын газрын гүний дулааны нөөцийн тодорхой хэсэг оршдог нь судалгаагаар тогтоогдсон байгаа. Энэ нь геотермийн станц байгуулах замаар эрчим хүчний нэмэлт эх үүсвэрүүдийг бий болгох сайхан боломж олгож байгаа юм. Ялангуяа Шивэртийн халуун рашааны орчимд ийм боломж, магадлал өндөр байгааг анхаарах хэрэгтэй. Тус аймгийн хувьд хүйтний улиралд зайлшгүй шаардлагатай нүүрсний асуудал одоо хүртэл бүрэн төгс шийдвэрлэгдээгүй байгаа бөгөөд гол төлөв Өвөрхангайн Баянтээгийн нүүрсний уурхайгаас нүүрсээ татдагаас 1 тн нүүрсний өөрийн өртөг 50.0 гаруй мянган төгрөг болдог аж. Иймээс ашиглах явцдаа түр зогссон Баянцагааны уурхай, Баяндүүрэхийн судлагдаж байгаа ордыг ашиглалтад бүрэн оруулах нь аймгийн нийгэм-эдийн засгийн бодлогын анхааралд байх ёстой гэж үзэж байна. Цаашдаа ч Өгийнуур, Хотонт, Хайрхан сумын нутагт энэ чиглэлээрх эрэл хайгуулыг эрчимжүүлэх шаардлагатай.

**Нэгдүгээр бүлгийн дүгнэлт:** Аймгийн нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдлыг судалж үзсэний үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн нийгэм-эдийн засгийг зохих түвшинд хөгжүүлэхэд хүний нөөцийн үүрэг, нөлөө чухал ач холбогдолтой байдаг. Иймээс суурин хүн амын цэвэр өсөлтийг хэвийн хэмжээнд барьж иргэдийн амьдрах орчинг шаардлагын хэмжээнд бий болгон, ажилгүйдэл, ядуурлыг эрс бууруулах, нийгэм хангамжийн үйлчилгээг сайжруулах тэднийг зах зээлтэй холбох, дэд бүтцийг хөгжүүлэх, өөрөө өөрийгөө тэтгэх өрхийн аж ахуйг дэмжих зэрэгт орон нутгийн төр, захиргааны байгууллагуудын ажлыг чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Түүнчлэн өрх гэрийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг дээд зэргээр дэмжих нь хүн амын тогтвор суурьшил, эдийн засгийн идэвхтэй хүн амыг нэмэгдүүлэх арга хэмжээ болох юм.

2. Тус аймгийн нийгэм-эдийн засгийн тэргүүлэх салбар нь ХАА юм. Иймээс МАА, газар тариаланг орчин үеийн эрчимжсэн технологиор эрхлэн хөтлөх цогцолбор бодлого боловсруулан мөрдөх шаардлагатай. МАА-г эрчимжсэн технологиор эрхлэн хөтлөхийн тулд бэлчээрийн газрын даац, өгөөжийг нэмэгдүүлэх, малын тэжээлийн баазыг бэхжүүлэх, бэлчээр усжуулалт, улирлын сэлгээ, бэлчээр талхагдал, малын үүлдэр, угсаа, малчин өрхийн амьдрал ахуй зэрэгт онцгой анхаарах нь чухал юм.

МАА-г эрхлэн хөтлөх систем боловсруулан мөрдөхийн хамт малын сүргийн бүтцийг зөв хадгалах, бэлчээр зохион байгуулалтын наад захын зарчмуудыг мөрдөх, орон нутгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан мал-бэлчээр-малчин гурвын нутагшил, суурьшлын асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр байгаль цаг агаар, экологийн нөхцөлд нь зохицуулан шийдвэрлэх нь ихээхэн үр дүнтэй гэж үзэж байна.

3. Аймгийн нутаг дэвсгэрт газар тариаланг хөгжүүлэхдээ байгалийн бүс, бүслүүрийн онцлогийг харгалзан хаана нь малын тэжээл, хаана нь үр тариа, төмс-хүнсний ногоо тариалах вэ? гэдэгт анхаарахын хамт төмс-хүнсний ногооны өрхийн үйлдвэрлэлийг аймгаас тодорхой бодлогоор хөхиүлэн дэмжиж, ногоо тарих, боловсруулах, хадгалах технологийг зааж сургах, ялангуяа хөрс, усны давуу талыг ашиглан хүлэмжийн аж ахуй, усалгаатай газар тариаланг эрчимжсэн технологиор эрхлэх нь 1 га газрын өгөөж, амьжиргааны эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болно. Тухайлбал, Хангайн нурууны өндөр уулын бүс, түүний салбар уулсын өндөрлөг газруудад түргэн болцтой

малын тэжээлийн ургамал тариалж, хүнсний ногоонд дулааны нийлбэрийг нэмэгдүүлэх үүднээс хүлэмжийн аж ахуйг түлхүү хөгжүүлэх нь зөв байх.

Ер нь байгаль-цаг уурын нөхцөл нь газар тариалан, хадланд тааламжгүй нөлөөтэй зарим сумдын 20 гаруй жил ашиглагдаагүй хаягдаж, эргээд бэлчээрийнхээ хэв шинжийг олсон атаржсан болон хадлангийн талбайнуудыг бэлчээрт эгүүлэн шилжүүлэх алхмыг зоригтой хийх хэрэгтэй юм.

4. Аялал жуулчлал Архангай аймгийн хувьд тэргүүлэх салбарын нэг болж хөгжих нь дамжиггүй. Гэхдээ дэд бүтцийн асуудалд онцгой анхаарах, гадаад, дотоодын аялал жуулчлалын стандарт нөхцөлүүдийг бүрдүүлэх, үүний тулд аялал жуулчлалын менежментийн асуудлыг цогцолбор байдлаар иж бүрэн шийдвэрлэх нь зүйтэй юм. Хамгийн гол нь экологийн цэвэр орчинг бий болгох, байгалийн үзэсгэлэнт газруудын унаган төрхийг алдагдуулахгүй байх, аялал жуулчлал хөгжүүлж байгаа 1 га газрын өгөөжийг зөв тооцон гаргах, жуулчдын очих цэг хүртэлх замыг унадаг дугуй, суудлын жижиг тэрэг чөлөөтэй явж байхаар сэргээн засварлах, тухайн цэг дээр автомашины зогсоол, жуулчдын амрах талбайг байнгын үйлчилгээтэй болгож тохижуулахад анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Үүнээс гадна жуулчдын замын дагуух малчин өрхүүдийн ахуй нөхцөлийг сайжруулж, монгол зан заншил, ахуйг сурталчлахад нь дэмжлэг үзүүлэх, замын үйлчилгээг боловсронгуй болгох арга хэмжээ авах шаардлагатай.

5. Аймгийн нутаг дэвсгэрт орших эмчилгээ-сувилгааны өндөр чанартай халуун, хүйтэн рашаан усны орчинг боловсронгуй болгож, амрагчдын ая тухтай нөхцөлийг хангахад түлхүү анхаарах хэрэгтэй байна. Ялангуяа хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, ариун цэвэр, эрүүл ахуйн наад захын шаардлага хангах боловсронгуй нөхцөлийг бүрдүүлэх нь чухал. Түүнээс гадна халуун рашаан, газрын гүний дулааныг ашиглан геотермийн аргаар эрчим хүчний эх үүсвэр гарган авах, түүнийг түшиглүүлэн хүлэмжийн аж ахуй байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд анхаарах ёстой болов уу.



## **Хоёрдугаар бүлэг:**

**Архангай аймгийн газрын нэгдмэл сангийн  
бүтэц, түүний ашиглалт, хамгаалалтын  
өнөөгийн байдал**

## **2.1.Аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц**

Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 5531.4 мянган га бөгөөд ХАА-н газар 3861.0 мянган га буюу 69.8 хувийг, хот, тосгон бусад суурины газар 9.5 мянган га буюу 0.16 хувийг, зам, шугам сүлжээний газар 6.2 мянган га буюу 0.10 хувийг, ойн сан бүхий газар 1082.6 мянган га буюу 19.6 хувийг, усны сан бүхий газар 25.2 мянган га буюу 0.45 хувийг, улсын тусгай хэрэгцээний газар 546.9 мянган га буюу 9.9 хувийг тус тус эзэлж байна.

Дээрх бүтцээс харвал аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 79.3 хувийг 3861.0 мянган га ХАА-н газраас, 1.6 хувийг хот, тосгон бусад суурины 9.5 мянган га газраас бусдыг нь үлдсэн ангиллын газраас тус тус үйлдвэрлэж байна гэхэд хилсдэхгүй. Өөрөөр хэлбэл аливаа үйлдвэрлэлийн үндэс суурь, тулгуур объект нь газар бөгөөд газрын үнэ цэнэ эцсийн бүтээгдэхүүнээр дамжин илэрхийлэгдэж байдаг юм. Иймээс аймгийн газрын нэгдмэл сангийн бүтцийг задалж ангилал бүрээр нь авч үзье.

## **2.2.ХАА-н газрын ангилал, түүний ашиглалт, хамгаалалт**

Аймгийн нийгэм-эдийн засгийн тэргүүлэх салбар бөгөөд хамгийн их дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг салбар нь ХАА-н салбар юм. Үүний дотор МАА-н үйлдвэрлэл нь үндсэн үйлдвэрлэл болж байна. МАА нь бэлчээр, ус, тэжээлийн хангамж, хүний нөөц, мал маллагааны ур чадвар зэрэг оюуны болон материаллаг хүчин зүйлүүдээс хамаардаг.

ХАА-н газар нь тариалан, бэлчээр, хадлан, ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газруудаас тус тус бүрдэнэ.

### **2.2.1.Тариалангийн газар**

Тус аймаг нь 57171.0 га эргэлтийн талбайтай /2004 оны байдлаар/ бөгөөд үүний 90.8 хувийг атаршуулж, 5239.1 га-д үр тариа, малын тэжээл, төмс-хүнсний ногоо тариалдаг ажээ. Тэгэхлээр нийт эргэлтийн талбайнхаа дөнгөж 9.2 хувийг л ашиглаж байна гэсэн үг. Сүүлийн 4 жилд дунджаар 3062.1 га-д тариалалт явуулж 3710.9 тн ургац хураан авсан мэдээтэй байна. Үүнээс үр тариа жилд дунджаар 5.6 цн, төмс 75.9 цн-ийг 1 га талбайгаас хураан авчээ.

Өнөөгийн байдлаар Төвшрүүлэх сум 3932.0 га-д үр тариа, 46.5 га-д төмс-хүнсний ногоо, Батцэнгэл 100.0 га-д үр тариа, 105.5 га-д төмс-хүнсний ногоо, 200.0 га-д тэжээлийн ургамал, Их Тамир 24.0 га-д төмс-хүнсний ногоо, Өлзийт, Эрдэнэмандал, Хотонт, Цэнхэр, Булган сумд 89.3 га-д төмс-хүнсний ногоо тус тус тариалж байна. Дээрх үзүүлэлт нь хангалтгүй бөгөөд усалгаатай

тариалангийн талбайг бараг ашиглахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Иймээс цаашид тариалангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлтөд энэ асуудлыг анхаарч тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Сумдаас авсан судалгаагаар сумдын удирдлага, холбогдох хүмүүс тариалангийн газрын ашиглалтын талаар дараах шалтгаануудыг дурджээ.

1. Санхүү-эдийн засгийн эх үүсвэр хүрэлцдэггүй
2. Ямар ч ургамал тариалаад нэмэргүй, ургац алддаг
3. Байгаль-цаг агаарын нөхцөл тааламжгүй
4. Газар тариалан эрхлэхэд зардал их гарч алдагдалд ордог, эрсдэл ихтэй
5. Газар тариалангийн техник-тоног төхөөрөмж хангалтгүй
6. Мэргэжлийн ажиллах хүчний нөөцгүй

зэрэг шалтгаануудаас болж нийт тариалангийн талбайн 90 орчим хувь нь сүүлийн 20-иод жил атаршиж байгаа тухай ярьж байна.

Цаашид нийт эргэлтийн талбайн дор хаяж 50 орчим хувийг ашиглаж чадвал аймгийн нийгэм-эдийн засагт яаж нөлөөлөх нь ойлгомжтой. Үүний тулд ядахдаа малын тэжээлийн баазыг нэмэгдүүлэх үүднээс нэг ба олон наст ургамал тариалах, өрхийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зайлшгүй шаардлага бий. Иймээс баталгаатай ургац авах нөхцөлийг бүрдүүлэх, эрчимжсэн технологи, усалгааны орчин үеийн бага оврын тоног төхөөрөмж нэвтрүүлэх ажлыг шуурхай хийж, тариалангийн газрын нөөцийг аль болох бүрэн дүүрэн ашиглаж, үр шимийг нь хүртэх боломжийг хайх нь зүйтэй болов уу.

Атаршсан газрынхаа ядаж 50%-ийг ашиглаж чадах юм бол хэдэн тэрбум төгрөгийн орлого олох нөөц байгаа нь ойлгомжтой юм. Усалгаатай энгийн болон инженерийн системтэй тариалангийн газрын талаар урьд нь дурдсан учраас энэ бүлэгт давхардуулах шаардлагагүй гэж үзэв.

### **2.2.2.Бэлчээрийн газар**

Тус аймгийн нийт бэлчээр 3749132.4 га талбайтай бөгөөд үүний 60 хувь буюу 2249479.0 га нь өвөл-хаврын, 40 хувь буюу 1438668.1 га нь зун-намрын бэлчээр эзэлж байна. Нийт бэлчээрийн эзлэх талбай нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн 67.8 хувь болж байгаа юм.

Архангай аймгийн нийт бэлчээр хонин толгойд шилжүүлснээр 3710.0 мянган толгой мал агуулах чадалтай гэж судлаачид тогтоожээ. Энэ бол зөвхөн малын бэлчээрийн даац юм. Хэрэв экологийн даацыг нь тодорхойлбол үүнээс 5-8 хувиар багасах магадлалтай. Тэгвэл одоо байгаа малыг хонин толгойд шилжүүлбэл 4469.1 мянган толгой байгаа бөгөөд бэлчээрийн даац хэтэрч байгаа нь эндээс харагдана. Гэтэл өнөөгийн байдлаар нийт бэлчээрийн 23 хүртэл хувь нь ямар нэгэн хэмжээгээр талхлагдсан мэдээ бий. Үүнийг хамгийн их ач холбогдол бүхий өвөл-хаврын бэлчээртэй харьцуулбал асуудал маш тодорхой болно. Эцсийн дүнд аймгийн нийт бэлчээрийн даац байвал зохих хэмжээнээсээ 766.8 мянган толгой малаар хэтэрч байгаа нь МАА-г өөрийнх нь аясаар эрхлэн хөтлөх систем энэ аймагт бүрэн ноёрхож байна гэдэг дүгнэлтэд хүрнэ.

Үүнээс үзэхэд малынхаа тоогоор уралддаг улирсан арга барилаасаа салж, бэлчээрийн оновчтой ашиглалт, 1 малаас авах ашиг шим, бүтээгдэхүүнээрээ уралддаг аргад шилжихийг байгаль-экологи биднээс шаардсаар байгаа юм.

Ер нь бэлчээрийг хэрхэн зөв хуваарьтай ашиглаж ачааллыг нь тохируулснаас бэлчээрийн газар нөхөн сэргэх, МАА-г эрсдэлээс хамгаалах, малчдын амьжиргааны түвшин хамаардаг.

Аймгийн ИТХ, ЗДТГ, Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслөөс хамтран дээрх байдалд дүгнэлт хийж, аймгийнхаа бүх сум, баг, хот айл, малчин өрхийн бэлчээр ашиглалтын өнөөгийн байдалд ШУА-ийн газар зүйн хүрээлэнгийн НМС-ны төвтэй хамтран 5760 хот айлын хүн, малын тоо, бэлчээр, хадлан, уст цэг, өвөлжөө, хаваржааны байршлыг тодорхойлж, хөрс ургамлын 468 дээж авч шинжилжээ. Үүний үр дүнд бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал, улирлын хуваарийг харуулсан 1:100000 масштабтай зураглал үйлдэж, бэлчээрийн даац, тэжээлийн нөөцийг тодорхойлсон байна. Түүнчлэн “Бэлчээр ашиглалтын тогтвортой менежмент- зөвлөмжийг боловсруулж ИТХ-ын ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн тогтоол гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа аж.

Иймээс бэлчээрийн одоогийн байдал, ашиглалтын хэтийн төлөвлөлт дээрх бичиг баримтад тодорхой тусгагдсан учраас цаашид ч аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнд дэлгэрэнгүй төлөвлөлт хийх нь илүүц юм гэж үзэж байна.

### **2.2.3.Хадлангийн газар**

Архангай аймаг нь нийтдээ 53.9 мянган га хадлангийн газартай ба бүсчилэлээсээ хамааран 5.3-7.9 цн/га ургацтай гэж үздэг.

**Архангай аймгийн хадлангийн нөөц**

№	Тойргийн индекс, дугаар	Хадлангийн талбай мян.га	1 га-ын ургац цн	Нийт ургац мян.тн	Нийт ургац тэжээлийн нэгжээр /мян.тн/	Хамрагдах зарим сум
1	ХУ-2	40.3	7.9	31.8	13.4	Архангайн хойт болон төв, зүүн урд сумд
2	ХУ-3	4.7	7.0	3.3	1.4	Тариат, Чулуут, Цахир, Булган гэх мэт
3	ХУ-4	0.4	5.3	0.2	0.1	Хангай, Цахир гэх мэт
4	ХУ-7	8.5	7.7	6.5	2.7	Өгийнуур, Хашаат, Батцэнгэл, Өлзийт гэх мэт
	<b>Дүн</b>	<b>53.9</b>	<b>-</b>	<b>41.8</b>	<b>17.6</b>	

1980-аад оны сүүлчээр Газар зохион байгуулалт, хайгуул зураг төслийн институтын судлаачид байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн 20 тойргийг тогтоож, тойрог тус бүрийн хадлан, бэлчээрийн ургац, үнэлгээг авч үзсэн байдаг. Үүний нэг хэсэг болох ХУ-2, ХУ-3, ХУ-4, ХУ-7 гэсэн тойргуудад Архангай аймгийн нутаг дэвсгэр хуваагддаг билээ. Тухайлбал:

- ХУ-2 - Хангайн ойт бэсрэг уул, уулын ам хөндийн нугат хээр
- ХУ-3 - Хангайн төв хэсгийн хөвч ойн өндөр уулуудын ам хоолойн нугархаг хээр
- ХУ-4 - Хангайн баруун хэсгийн өндөр уул-уулын ам хоолойн нугархаг хээр
- ХУ-7 - Хангайн зүүн, зүүн өмнөд хэсгийн бэсрэг уул-өргөн хөндийн гүвээт талын нугархаг хээр

Эдгээр ангилал, тойрог нь хадлан бэлчээрийн ижил төстэй байдлыг тал бүрээс нь илэрхийлж чаддаг тул үүнийг түшиглэн хадлангийн нөөцийн тооцоог хийлээ.

Дээрх хүснэгтээс харахад аймгийн хадлангийн талбайн дийлэнх нь буюу 74.8 хувь нь ХУ-2 тойрогт багтаж байна.

Энэ тойрогт уулын хар шороон, уулын хар хүрэн, аллювийн нугын хөрс зонхилдог бөгөөд ритидиум хөвд-элдэв өвст ойн болон элдэв өвст-улалж-үетэн, цахилдаг-элдэв өвст ойн бэлчээр голлоно. Хадлангийн талбайд ч мөн ялгаа байхгүй гэж ойлгож болно.

Хадлангийн эдгээр талбайнуудыг ашиглаж МАА-н үйлдвэрлэлийн тэжээлийн нөөцөөр дэмжих нь чухал боловч түүнийг тодорхой хэсгүүдийг хашиж хамгаалан хямд төсөр аргаар усалгаажуулвал үр дүнгээ өгөх нь тодорхой. Эс тэгвээс зүгээр л бэлчээр хэлбэрээр ашиглагдаж, талхлагдаж байгаад дүгнэлт хийвэл зохино.

#### **2.2.4.ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар**

ХАА-н зориулалтын газраас 759.7 га нь ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газарт хамрагдаж байна. Үүний 74.9 хувийг 1.7 сая толгой малын багтаамжтай 9.6 мянган өвөлжөө-хаваржааны доорх газар эзэлдэг. Үлдэх хувийг ХАА-н үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулагдсан тариалангийн талбайн ойн зурвас, эрдэм шинжилгээ-судалгааны зориулалттай ААН, байгууллагын газар эзэлж байна. Тус аймагт нэг өвөлжөө-хаваржааны доорх газарт 0.05 га газар ногдож байна.

#### **2.3.Хот, тосгон бусад суурины газрын ангилал, түүний ашиглалт хамгаалалт**

Архангай аймгийн хот, тосгон бусад суурины газар нь нийт 9486.7 га бөгөөд 2882.2 га буюу 30.4 хувь нь нийтийн эдэлбэрийн газар, 44.2 га буюу 0.46 хувь нь үйлдвэрийн газар, 4915.0 га буюу 51.8 хувь нь уурхайн дэвсгэр газар, 810.7 га буюу 8.5 хувь нь гэр хорооллын газарт тус тус хамаарагддаг ажээ.

Үүнээс гадна барилга байгууламжийн дэвсгэр газар 836.6 га буюу 8.9 хувийг эзэлдэг.

##### **2.3.1.Барилга байгууламжийн дэвсгэр газар**

Тус аймгийн барилга байгууламжийн дэвсгэр газар нийт 836.6 га гэх бөгөөд иргэн, ААН, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа барилга байгууламжийн доорх газар 789.9 га буюу 94.4 хувийг эзэлж байна. Бидний судалгаагаар аймгийн төв болох Цэцэрлэг хот буюу Эрдэнэбулган сумын барилга байгууламжийн дэвсгэр газар 93.3 га гэж 2004 оны газрын балансад тусгагдсан нь Их Тамир сумынхаас 1.7 дахин, Төвшрүүлэх сумынхаас 1.8 дахин бага байгаа нь сонирхол татаж байгаа юм. Ямар ч аймгийн төв, сумын төвөөс бага барилга, байгууламжтай байна гэдэг үнэмшимгүй асуудал болно. Гэсэн хирнээ нийтийн эдэлбэрийн газар нь Их Тамирынхаас 14.9 дахин, Төвшрүүлэхээс 5.6 дахин их байгаа нь Цэцэрлэг хот буюу Эрдэнэбулган сум нь барилгажаагүй талбайн асар их нөөцтэй мэт ойлголт өгч байна. Түүнчлэн Цэцэрлэг хот Булган сумаас барилга хот байгуулалтын хөгжлөөрөө хоцрогдож яваа юм шиг ташаа ойлголтыг 2004 оны газрын нэгдмэл сангийн ангиллын тоо баримтууд өгч байгааг анхаарахгүй байж болохгүй.

Үүнээс гадна Цэцэрлэг хот нь 1980-аад онд боловсруулсан хот байгуулалтын төлөвлөгөөгөөр хөгжиж ирсэн бөгөөд даруй шинэчлэх шаардлагатай зураг төслийн баримт бичиг гэдгийг анхаарах ёстой. Учир нь, аймгийн төв Цэцэрлэг хотын нутаг дэвсгэр дээр Эрдэнэбулган сум орших ба

түүний нутаг дэвсгэрийг тодорхой хэмжээгээр тэлж суурьшлын болон бусад хөгжлийн бүсүүдийг байгуулах шаардлагатай.

Барилга байгууламжийн газарт багтдаг амралт, рашаан сувиллын газраас хамгийн их нь Өгийнуур /8.5 га/, Их Тамир /8.5 га/, Цэнгэл /6.4 га/ сумын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд эдгээр нь гол төлөв орон нутгийн чанартай амралт, рашаан сувиллын газар байгаа юм. Аялал жуулчлалын зориулалттайгаар иргэн, ААН, байгууллагад эзэмшүүлсэн газрыг эзэмшил, ашиглалтад байгаа барилга, байгууламжийн доорх газарт багтаасан байна. Дээрх газрын эзэмшил, ашиглалтын талаар төлөвлөлтийн хэсэгт тодорхой дурдах болно.

### ***2.3.2.Нийтийн эдэлбэрийн газар***

Аймгийн хэмжээнд бүгд 2882.2 га нийтийн эдэлбэрийн газартай бөгөөд үүний 10.0 хувь нь зам, гудамжны талбай, 83.3 хувь нь иргэд, ААН, байгууллагад олгогдоогүй сул чөлөөтэй газар, үлдэх 6.7 хувь нь оршуулгын газар, цэвэрлэх байгууламж зэрэг бусад газарт хамаарагддаг.

Нийтийн эдэлбэрийн газрын дотроос талбайг нь бага байлгах, эмх журамтай байлгах талаас нь хамгийн их анхаарах ёстой газар нь хог хаягдлын газар юм. Төвшрүүлэх суманд хог хаягдлын газар 10 га талбай эзэлж байгаа нь Цэцэрлэг хот нутаг дэвсгэрт нь оршиж байгаа Булган сумынхаас бараг 3 дахин их талбай эзэлж байгааг анхаарах ёстой.

### ***2.3.3.Үйлдвэр, уурхайн газар***

Тус аймгийн хот, тосгон бусад суурины газрын дотор уурхайн дэвсгэр газар 4913.0 га буюу 51.8 хувийг, үйлдвэрийн газар 44.2 га буюу 0.46 хувийг тус тус эзэлж байна. Уурхайн газрын гол цөм нь одоо ашиглаж байгаа Цэнхэр сумын нутаг дахь Оросын талаас Алтан-Дорнод, Монголын талаас Монгол газар ХХК-ийн алтны уурхай юм. Бусад сумдын нутаг дэвсгэрээс үйлдвэр, уурхайд маш бага хэмжээний газар хамрагддаг. Энэ нь геологи уул уурхайн ашигт малтмалын нөөц газруудад хээрийн болон нарийвчилсан судалгаа бүрэн хийгдэж амжаагүй байгаатай холбоотой.

### ***2.3.4.Гэр хорооллын газар***

Тус аймгийн нутаг дэвсгэрт гэр хорооллын газар 810.7 га байгаагаас 616.4 га буюу 76.0 хувь нь гэр, орон сууцны газарт, 194.3 га буюу 24.0 хувь нь иргэдийн гэр бүлийн хэрэгцээнд зориулагдсан төмс-хүнсний ногооны талбайд хамрагддаг байна. Хотонт, Батцэнгэл, Их Тамир, Булган, Эрдэнэбулган сумдын өрхүүд төмс-хүнсний ногооны талбайн дийлэнх хувийг эзэлдэг аж.

2004 онд Архангай аймгийн бүх сумдыг хот, тосгон бусад суурины газарт кадастрын зураглал хийгдсэн тул хашаа, байшингийн газрын одоогийн байршил тодорхойлогджээ.

Судалгаанаас үзэхэд Эрдэнэбулган, Жаргалант зэрэг сумдын төвийн гэр хорооллыг үерийн уснаас хамгаалах арга хэмжээг цаашид авах шаардлагатай. Түүнчлэн Эрдэнэбулган сумын төвийн гэр хорооллыг тэлэх газрын судалж тогтоох нь чухал юм.

#### **2.4. Зам, шугам сүлжээний газрын ангилал, түүний ашиглалт, хамгаалалт**

Архангай аймгийн зам, шугам сүлжээний ангиллын газар нь 6146.4 га газар эзэлдэг бөгөөд автозамд 3747.2 га, шугам сүлжээний газарт 2305.1 га бусад газарт 94.1 га тус тус хамаарагддаг байна. Зам, шугам сүлжээний газарт сүүлийн 4 жилд /2000-2004 он/ өөрчлөлт ороогүй бөгөөд цаашид газрын нөөцийн төлөвлөлтийн явцад “Мянганы зам”, “Эрчим хүчний нэгдсэн хөтөлбөр” зэргийг хэрэгжүүлэх Монгол Улсын нийгэм-эдийн засгийн бодлоготой уялдан тодорхой хэмжээний өөрчлөлт орох юм.

##### **2.4.1.Авто замын газар**

Авто замын газарт улсын чанартай авто зам бүртгэгдээгүйгээс зөвхөн орон нутгийн чанартай авто зам хамрагддаг. Хэдийгээр баруун аймгууд руу чиглэсэн авто зам Өгийнуурын гүүр, Батцэнгэл, Тариат, Цахир сумаар дайран өнгөрдөг боловч замын ерөнхий нөхцөлөөс хамааран гол төлөв Хөвсгөл, Өвөрхангайн нутгаар дамжин өнгөрч байна. Гэвч ойрын үед “Мянганы зам” хөтөлбөр хэрэгжих явцад зөвхөн дээрх маршрутаар аялах үндсэн нөхцөл бүрдэх юм.

Тус аймаг 1997 оноос хойш Хархорин-Хотонт-Цэнхэр-Цэцэрлэг хот гэсэн чиглэлээр хатуу хучилттай авто зам байгуулах төлөвлөгөөтэй байсан боловч эдийн засаг-санхүүгийн нөхцөлөөс шалтгаалан өнөөг хүртэл хэрэгжүүлж чадаагүй байна.

Харин дээрх маршрутаар зарим хэсэгт нь хайрган хучилттай сайжруулсан зам тавих ажлыг эхлүүлжээ. Үүнээс гадна Эрдэнэбулган-Их Тамир-Тариат гэсэн маршрутын замыг сайжруулах, даваа гүвээг засах, том голууд дээр гүүр байгуулах чиглэлээр нэлээд ажил хийсэн нь тодорхой байна. Өнөөгийн байдлаар “Мянганы зам”-ын гол маршрут болох Өгийнуур-Тариатын чиглэлийн замыг хайрган хучилттай сайжруулсан зам болгон тохижуулах ажил эрчимтэй хийгдэж байгаа нь Тэрх, Цагааннуур, Ноёнхангай, Хорго, Чулуут голын орчмын байгалийн үзэсгэлэнт газруудаар гадаад, дотоодын аялал жуулчлалыг



хөгжүүлэхэд ихээхэн дөхөмтэй болжээ. Гэвч Өндөр-Улаанаас цааш Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг сумд руу явдаг ердийн хөрсөн замуудад тааралддаг өндөр даваа, гүвээнүүдийн эвдэрч гэмтсэн замуудыг ойрын ирээдүйд засаж сайжруулах нь нэн чухал. Ялангуяа өвөл-хавар-намрын цас, бороотой улиралд замын саад бэрхшээл ихсэж нэлээн төвөг учруулдаг нь судалгааны явцад харагдлаа.

#### **2.4.2.Шугам сүлжээний газар**

Аймгийн хэмжээнд шугам сүлжээний газар 2305.1 га талбай эзэлдэг. Үүнд холбоо болон эрчим хүчний шугамын доорх газар үндсэн нь энэ дэд ангиллыг бүрдүүлдэг байна. 2004 оны байдлаар үндсэндээ бүх сум холбоо болон эрчим хүчний шугамд холбогджээ. Төвлөрсөн эрчим хүчний шугамд хамгийн сүүлд Цахир сум холбогдсон гэж үзэж болно. Зам, шугам сүлжээний газрын дэд ангилал болох шугам сүлжээний газарт үерээс хамгаалах далан, сувгийн барилга байгууламж багтдаг бөгөөд Цэцэрлэг хот, Жаргалант, Цэцэрлэг сум, Тариат зэрэг сумдын төв суурин газарт дээрх байгууламжуудыг барьж байгуулах шаардлагатай нь судалгааны явцад харагдлаа. Ялангуяа Цэцэрлэг хот буюу Эрдэнэбулган сумын төвд гэр хороолол, барилга байгууламжийг үерийн уснаас хамгаалах далан, суваг байгуулах зайлшгүй шаардлагатай.

#### **2.5.Ойн сан бүхий газар, түүний ашиглалт, хамгаалалт**

Аймгийн хэмжээгээр нийт газар нутгийн 19.6 хувь буюу 1082621.0 га талбайг ойн сан бүхий газар эзэлдэг /2005 оны байдлаар/. 1995-1996 онд Ой, ан судлалын хүрээлэнгээс эрхлэн Архангай аймгийн ойн сан бүхий газарт иж бүрэн судалгаа явуулсан байна. Энэхүү судалгаанаас үзэхэд, тус аймгийн нутаг дэвсгэрт байгаа байгалийн гаралтай ойн дийлэнх хувийг шинэсэн ой эзэлдэг бөгөөд навчит ой Орхон голын эхээр бага зэрэг байдаг нь тогтоогджээ. Өөрөөр хэлбэл ойн сан бүхий газрыг сөөгт, ботууль, сөөгөнцөр хөвдөт, цармын шинэс, хушин ой /4.5 хувь/, ногоон хөвдөт, сургарт, алирст бадаант, тэрэлжит, хааяа жодоо, гацуур оролцсон хуш, шинэсэн ой /2.2 хувь/, алаг өвс-ритидиум хөвдөт, алирс-ритидиум хөвдөт тундиум хөвдөт тайгажуу шинэсэн ой /6.8 хувь/, алаг өвс-цахилдагт, үетэн-алаг өвст, алаг өвс-улалжит, баврант, сорвост шинэс нарсан ба өргөж ургасан хусан тайгархаг ой /6.1 хувь/ бүрдүүлдэг аж.

Үүнээс гадна Хангайн нурууны тусгай хамгаалалттай газар нутагт Хорго-Тэрхийн цагаан нуур, Ноёнхангай, Хангайн нурууны хойт хэсэгт бүгд 67.9 мянган га ой хамрагддаг байна.

Архангайн хойт чиглэлийн ойн нөөц бүхий 7 сумын ой зохион байгуулалтын судалгааны материалаас үндэслэн аймгийн хэмжээгээр ой модны ашиглалтын тооцоо хийж үзэхэд жилд дунджаар 300 орчим га талбайгаас 8.2 мянган м<sup>3</sup> модыг түүвэрлэн огтлох аргаар бэлтгэх боломж бий. Мөн олон жилийн судалгаанаас үзэхэд арчилгааны огтлолтоор 16.4 мянган га-гаас 796.9 мянган м<sup>3</sup> мод авч ашиглаж болохын зэрэгцээ огтлолтоор 12.9 мянган га-аас 85.0 мянган м<sup>3</sup> хатсан мод, 286.9 мянган м<sup>3</sup> унанги модыг авч ашиглах боломжтой гэж үздэг байна.

Гэвч ойг огтолж ашиглахдаа гол нь биш, экологийн нөхцөлийг нь хангаж, ойг нөхөн төлжүүлэх бүхий л арга хэмжээг авч байх нь чухал. Өнөөгийн байдлаар нийт ойн сангийн газрын ердөө 6.3 хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт багтаж байгаа нь цаашид ойг хамгаалах, зөв зохистой ашиглах арга хэмжээг цаг тухайд нь авч байхыг байгаль-экологи биднээс шаардаж байна. Тус аймгийн газрын тоо бүртгэлд ой модыг нь огтолсон газрын хэмжээ 2.8 мянган га гэж тусгагдсан нь нийт ойн сангийн 0.2 хувийг эзэлж байна.

## **2.6.Усны сан бүхий газар, түүний ашиглалт, хамгаалалт**

Архангай аймаг нь ус зүйн сүлжээ сайтай аймагт тооцогддог бөгөөд Умард мөсөн далайн ай сав газарт харъяалагддаг Орхон, хойт, урд Тамир, Хануй, Хүнүй, Чулуут, урд, хойд Тэрх, Гичгэнэ, Сумангийн гол зэрэг томоохон голуудтайгаас гадна Их нуур, Айраг нуур, Дөрөө цагаан, Тэрхийн цагаан, Өгий, Ноот нуур гэх мэт нэлээд олон нууруудтай билээ. Тэрчлэн азот болон нүүрсхүчлийн хийтэй халуун, хүйтэн рашаанууд, тухайлбал, Шивэрт, Цэнхэр, Цагаан сум, Чулуут, Ноёнхангайн халуун рашаанууд тус аймгийн нутаг дэвсгэрт оршдог.

Эдгээр гол мөрөн, нууруудыг оролцуулаад тус аймгийн усны сан бүхий газрын хэмжээ нийтдээ 25.2 мянган га талбайтай гэж үздэг. Тухайн аймагтаа хамгийн томд тооцогддог Тэрхийн цагаан нуур, Өгийнуурын нийлбэр талбай бүх усны сан бүхий газрын 47.2 хувийг эзэлдэг ажээ. Бэлчээрийн усан хангамжийн хувьд ч гэсэн чамлахааргүй үзүүлэлттэй байдаг. Тухайлбал, 2003 оны улсын усны тооллогоор тус аймаг 965 уст цэгтэй, үүнээс инженерийн хийцтэй ерөмдмөл худаг 861, энгийн уурхайн худаг 104 тоологджээ. Нийт худгийн 80 хувь нь байгалийн бэлчээрт байдаг байна.

**2.7.Улсын тусгай хэрэгцээний газар, түүний ашиглалт, хамгаалалт**

Архангай аймгийн нутаг дэвсгэрийн 9.9 хувь буюу 546.9 мянган га газар УТХГН-т хамаарагддаг. Үүнээс байгалийн дурсгалт газарт Булган уул /1840 га/, Хашаат сумын нутаг дахь Культгени болон бусад их хаадын холбогдолтой түүхийн дурсгалт газар /20.0 га/ хамаарна. Бусад газрууд нь Хангайн нурууны ТХГН-т харъяалагддаг байна.

**Архангай аймгийн улсын тусгай хамгаалалттай газар нутгууд**

№	ТХГН-ийн нэр	Бүгд /га/	Үүнээс		Үндэслэл шийдвэр
			БЦГ	Дурсгалт газар	
1	Хангайн нурууны БЦГ	354067.0	-	-	УИХ-ын 1996 оны 43-р тогтоол
2	Хорго-Тэрхийн цагаан нуур	77267.0	77267.0	-	УИХ-ын 1995 оны 26-р тогтоол
3	Ноёнхангай	59088.0	59088.0	-	УИХ-ын 1998 оны 28-р тогтоол
4	Тарвагатайн нурууны хэсэг	54600.0	54600.0	-	УИХ-ын 2000 оны 29-р тогтоол
5	Булган уул	1840.0	-	1840.0	УИХ-ын 1995 оны 26-р тогтоол
6	Культгений дурсгалт хөшөө	20.8	-	20.8	-
	Дүн	546882.8	545022.0	1860.8	

Тус аймагт Хорго-Тэрхийн цагаан нуур, Чулуут голын чиглэлд байгалийн аялал жуулчлал, Хашаат, Хотонтын чиглэлд соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр аялал жуулчлалыг хөгжүүлж байна. Цаашдаа ч энэ талаар онцгой анхаарч, аймгийн нийгэм-эдийн засагт үзүүлэх аялал жуулчлалын нөлөөг нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

**Хоёрдугаар бүлгийн дүгнэлт:** Аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, түүний ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдлыг судалж үзээд дараах дүгнэлтийг хийж байна

1. ХАА-н газрын ашиглалт, хамгаалалт хангалтгүй, ялангуяа тариалангийн газар, бэлчээрийн ашиглалт өнөөгийн шаардлагын хэмжээнд хүрээгүй байна. Иймээс ХАА-н газрын төлөвлөлтийг боловсронгуй болгож, ашиглалтыг сайжруулах шаардлагатай.
2. Сумын болон аймгийн төвийн хот байгуулалтын иж бүрэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.
3. Ойн нөхөн сэргээлтийг ой мод ашиглалттай нягт уялдуулан гүйцэтгэх. Ойг түймрээс болон хортон шавьжаас хамгаалах арга хэмжээг жил бүр хэрэгжүүлэх.
4. Улсын болон орон нутгийн чанартай төвлөрсөн замуудын маршрутыг байнгын болгон тогтоож, замын саад бэрхшээлүүдийг арилгаж, даваа гүвээнүүдийг засаж янзлах. Ялангуяа Мянганы замын дагуух хайрган хучилттай замыг хатуу хучилттай болгох.
5. Аймгийн газрын нэгдмэл сангийн баланс, тоо бүртгэлийн тайлан маш их алдаатай хийгдэж, тайланд тусгагдсан тоо баримтууд бодит байдалтай нийцэхгүй байгааг онцгой анхаарах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **АРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН НӨӨЦ, НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ МЕНЕЖМЕНТ**

Архангай аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийг боловсруулахдаа 1998 оны 12 дугаар сард аймгийн ИТХ-аас баталсан “Сумдыг эдийн засгийн талаар бүсчилэн хөгжүүлэх чиглэл”-ийг гол үзэл баримтлалаа болголоо. Гэхдээ дээрх батлагдсан чиглэлд газрын нэгдмэл сангийн ангиллын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийн талаар тусгагдаагүй бөгөөд зөвхөн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд болон физик-газарзүйн орон зайн нөхцөлүүд, түүний эерэг, сөрөг нөлөөллийн талаар дэлгэрэнгүй тусгасан байв.

Иймээс аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийг боловсруулахдаа дээрх бичиг баримтаас гадна 1997 онд аймгийн ИТХ-аар батлагдсан “Архангай аймгийн ХХ1 зууны хөгжлийн хөтөлбөр”, 2003 онд батлагдсан Монгол Улсын “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” зэргийг иш үндэс болгохын хамт тус аймгийн газрын нөөцийн эзэмшил, ашиглалтын хэтийн төлөв, ялангуяа аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжилд нөлөө бүхий ХАА-н ангиллын болон хот, тосгон бусад суурин газарт гол анхаарлаа төвлөрүүлээ.

Ер нь аймгийн газрын нэгдмэл сангийн ангилалд дүгнэлт хийж үзэхэд ХАА-н ангиллын газрын асар их нөөц бүрэн гүйцэд ашиглагдахгүй байгаагаас хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн онц чухал тулгуур үндэс болсон газрын үнэ цэнэ алдагдахад хүргэж байна. Газар бол нийгэм-эдийн засгийн хөгжлийн үндсийн үндэс учраас байгаль-цаг уурын олон янзын нөхцөл, бүс, бүслүүрийн төрөл зэргийг судалж үзсэний үндсэн дээр газрын нэгдмэл сангийн ангиллын оновчтой төлөвлөлтийг хийж, аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжилд “газар” гэдэг ямар их үүрэгтэйг мөнгөн дүнгээр болон түүнд тулгуурлан бий болдог хоёрдогч бүтээгдэхүүний /МАА, газар тариалан, хадлан гэх мэт/ үйлдвэрлэлтээр харуулахыг зорив.

### **3.1.ХАА-н газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент**

ХАА-н газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийг боловсруулахдаа дараах үзүүлэлтүүд болон хүчин зүйлүүдийг харгалзан үзлээ.

Үүнд:

1. ХАА-н уур амьсгалын мужлал
2. Байгалийн бүс, бүслүүрийн ерөнхий шинж

3. ХАА-н газрын орон зайн багтаамж, нөөц
4. Бүс нутгийн хүн ам, малын тоо
5. МАА-н болон газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэрэгцээ шаардлага
6. МАА-н материаллаг бааз, тэжээлийн хангамж зэрэг болно.

ХАА-н газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийн хамгийн гол зорилго нь аймгийн нийгэм-эдийн засгийн бодлогын үндэс суурь болсон МАА-н үйлдвэрлэлийн тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх болон хүн амын тодорхой хэсгийг газар тариалангийн бүтээгдэхүүнээр хангах нөөц бололцоог бий болгох, ХАА-н ангилалд багтдаг газрын эдийн засгийн боломжийг тооцон гаргахад оршино. Түүнчлэн сүүлийн 20-иод жил ашиглагдахгүй байгаа тариалангийн болон хадлангийн газрын шалтгааныг тодруулж, зарим гарын өөр дэд ангилалд шилжүүлэх асуудлыг ч авч үзлээ.

### ***3.1.1. Газар тариалан, атаршсан газар болон хадлангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент***

Аймгийн газар тариалан атаршсан газар болон хадлангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийг боловсруулахдаа тус аймгийн эдийн засгийн дотоод бүсчилэлийг харгалзан үзлээ. Үүнд:

#### **1. Хоргын бүс**

Энэ бүсэд Өндөр-Улаан, Чулуут, Хангай, Цахир, Тариат сум зэрэг Хангайн нурууны баруун хойт талын өндөр уулын бүсийн сумд харьяалагддаг.

Нийт 1958147 га нутаг дэвсгэртэй бөгөөд аймгийн нийт нутаг дэвсгэрийн 35.4 хувийг эзэлнэ.

Бүсийн төв нь Тариат. Нутаг дэвсгэрийн 9.2 хувийг атаршсан газар болон хадлангийн газар эзэлдэг тоо баримт байгаа боловч сүүлийн 20-иод жил ашиглагдаагүй байна.

Монгол орны ХАА-н уур амьсгалын мужлалаар авч үзвэл Өндөр-Улаан, Тариат, Цахир сумд бүхэлдээ хангайн сумын хойт хэсэг 1<sup>б</sup> буюу чийглэг хүйтэвтэр бүсэд, Чулуут сум бүхэлдээ 1<sup>а</sup> буюу чийглэг хүйтэн мужид харьяалагддаг. Өөрөөр хэлбэл чийгшил ихтэй ( $K_3 < 2.0$ ) боловч жилийн дундаж дулааны нийлбэр  $+10^{\circ}\text{C}$ -аас дээш/  $1200^{\circ}\text{C}$  бага байгаа нь газар тариалан эрхлэх боломж, нөхцөл хязгаарлагдмал юм.

Агро-уур амьсгалын нөхцөлөөр авч үзэхийн бол **Нэгдүгээрт**: эрт боловсордог зусах таримлуудаас /буудай, хошуу будаа, арвай, вандуй гэх мэт/ 7 цн-ээс 10 цн/га ургац авч болох боломж бий.

Гэхдээ дээрх ургамлуудын ургалтын үе шатыг /соёололт, бутлалт, голлолт, цэцэглэлт,% түрүүлэлт, аарцан бололт гэх мэт/ харгалзвал эрсдэл ихтэй нь ойлгомжтой болно.

**Хоёрдугаарт**: Хэдийгээр арвайг далайн түвшнээс дээш 2000-2500 м-ийн өндөр газар тариалж болох боловч 1<sup>а</sup> мужид ногоон тэжээлээр хураан авахаас өөр боломжгүй. **Гуравдугаарт**: Вандуй өсөлт хөгжилтийн шатаасаа хамааран янз бүрийн нийлбэр дулаан шаардах бөгөөд түргэн боловсордог сорт нь 1230<sup>о</sup>С-1500<sup>о</sup>С идэвхтэй температурыг шаардана.

Хамгийн хүйтэн 1<sup>а</sup> мужид вандуйг 10 жил тариалахад үүнээс 7 жилд нь л үр нь боловсордог нь судалгаагаар тогтоогдсон.

Иймээс үр тарианы төрлийн ургамлуудыг тариалж, атаршсан газрынхаа нөөцийг ашиглах нь эрсдэл ихтэй учраас одоо нэгэнт бэлчээрт шилжсэн нөхцөлийг нь хэвээр үлдээх нь газар ашиглалтын менежментийн хувьд энэ бүсэд оновчтой шийдвэр болно гэж үзэж байна.

Харин Хоргын бүсэд ААН, байгууллага, өрхийн аж ахуйн нөхцөлд хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх боломж бий. Үүний тулд Тариатаас бусад сумын ААН, байгууллага, иргэдээс гаргах саналын дагуу далд хөрсний аж ахуй эрхлэх боломж нөхцөлийг нь дэмжихийн хамт Тариат сумын олон улсын болон дотоодын аялал, жуулчлалыг харгалзан үзэж тэнд томоохон хэмжээний хүлэмжийн аж ахуй байгуулах нь ашигтай бөгөөд бүсийн хөгжлийг нийгэм-эдийн засгийн бодлогоор дэмжих үндэслэл болох юм.

Ийм учраас Хоргын бүсэд зөвхөн бэлчээрийн МАА-г голлож, 2827.5 га атаршсан нэртэй бөгөөд 20 гаруй жил ашиглагдаагүй газрыг бэлчээрт ээлж дараатайгаар шилжүүлэх нь зөв гэж үзэж байна.

Түүнчлэн энэ бүсэд 2062.0 га хадлангийн газар байгаа боловч эдгээр нь сүүлийн 20 гаруй жил зөвхөн малын бэлчээрт ашиглагдсаар ирсэн байна.

Дээрх дэд ангиллын талбайнууд нь далайн түвшнээс дээш 2000-2500 м-т оршдог бөгөөд хэдийгээр чийгшлийн хуурайн зэрэглэл нь  $K_s < 2.0$  боловч +10<sup>о</sup>С-аас дээших дулааны нийлбэр нь 1200<sup>о</sup>С-аас бага тул ашиглахад эрсдэл ихтэй. Иймээс тэдгээрийг ээлж дараатайгаар бэлчээрт шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.



**Хоргын бүсээс бэлчээрт шилжүүлэх талбай /га/**

Бүсийн нэр	Сумдын нэр	Бэлчээрт шилжүүлэх		Үүнээс		Бэлчээрт шилжүүлэх болсон шалтгаан
		Он	Нийт талбай	Атаршсан газар	Хадлан	
Хорго	Өндөр-Улаан	2013-2021	1922.0	810.0	1112.0	<ul style="list-style-type: none"> <li>• Сүүлийн 20 гаруй жил ашиглагдаагүй</li> <li>• ДТД – 2000-2500 м</li> <li>• Жилийн дундаж дулааны нийлбэр 1200<sup>о</sup>-аас бага</li> <li>• Нутгийн дийлэнх хэсэг чийглэг хүйтэн мужид хамаарна</li> <li>• Усалгаатай тариалан эрхлэх боломж, нөхцөл хязгаарлагдмал</li> <li>• Дахин ашиглах, хашиж хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө, техник тоног төхөөрөмжийн боломж муу</li> </ul>
	Чулуут	2006-2013	503	236.0	267.0	
	Хангай	2006-2013	1213.0	927.0	286.0	
	Цахир	2006-2013	785.0	505.0	280.0	
	Тариат	2013-2021	466.5	349.5	117.0	
	Дүн			4889.5	2827.5	

Ийнхүү эдгээрийг үе шаттайгаар бэлчээрт шилжүүлснээр 2021 он гэхэд Хоргын бүсийн бэлчээр 4.9 мянган га-аар нэмэгдэх юм. Атаршсан газар, хадлангийн талбай хасагдаж байгаатай холбогдуулан зун-намрын ургац сайтай бэлчээрийг хашиж хамгаалах, малын хөлөөс түр хугацаагаар чөлөөлөх замаар нөөцөлж, хадлан авах арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт иргэн, ААН, байгууллагын хүлэмжийн аж ахуй эрхлэх боломжийг хангаж өгөх нь чухал юм.

МАН-н үйлдвэрлэлд дутагдах таримал тэжээлийг Өгийнуурын бүсээс, хадлангийн өвсийг Булган уулын бусаас тус тус хангах нөхцөлийг бүрдүүлэх боломж бий. Хүн амын хүнсний ногооны дутагдах хэрэгцээг Өгийнуур, Булган уулын бүсийн зарим сумдаас болон төвлөрсөн бөөний худалдаанаас хангах нь зүйтэй. Ийнхүү Хоргын бүсэд МАН-н үйлдвэрлэлийг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх нь оновчтой гэж үзэж байна.

Хоргын бүс 448.4 мянган малтай үүнийг хонин толгойд шилжүүлбэл 1 сая 270 мянган толгой болно. Эрдэмтдийн судалгаагаар ийм хэмжээний малд 2048.4 мянган га байгалийн бэлчээр шаардлагатай.

Гэтэл Хоргын бүсийн бэлчээр 1 сая 315 мянган га. Үүнээс үзвэл энэ бүсэд одоо байгаа бэлчээрийн даац байвал зохих хэмжээнээсээ 1.6 дахин хэтэрч байна. Хоргын бүсэд 129.2 мянган ямаа, 37.6 мянган адуу байгаа нь тухайн бүсийн нийт малын 37.2 хувийг эзэлдэг бөгөөд эдгээр нь бэлчээр талхлагдахад

хамгийн их нөлөөлдөг малын төрөл юм. Иймээс дээрх малын төрлийн тоог бэлчээрийн даацад зохицуулан бууруулах шаардлагатай. Бүсийн давуу тал нь үхэр сүргийн тоогоор бусад бүсээс илүү. Сарлаг үхрийн 70 гаруй хувь нь энэ бүсэд байдаг.

## **2. Хануй голын бүс**

Энэ бүсийн Хайрхан, Цэцэрлэг, Жаргалант, Эрдэнэмандал сумд нь нийтдээ байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор тойргийн ХУ-2 хэсэгт хамрагддаг, жилдээ 200 мм орчим хур тунадас унадаг, уулын хар шороон, хар хүрэн хөрс голлосон жилийн дулааны +10<sup>0</sup>С-аас дээших дундаж нийлбэр 1200<sup>0</sup>С-1750<sup>0</sup>С бөгөөд агро уур амьсгалын чийглэг хүйтэвтэр мужид багтана. Чийгшлийн Кз – 2.0.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ нь аймгийнхаа нутаг дэвсгэрийн 20.4 хувийг эзэлдэг бөгөөд 7321.4 мянган га бэлчээр, 15.0 мянга орчим га атаршсан газар, 10.6 мянган га хадлангийн газартай. Хануйн голын бүс нь нийт 18.0 мянган хүн, 598.5 мянган малтай.

Энэ бүсийн атаршсан талбай бүхэлдээ, хадлангийн талбайн дийлэнх нь сүүлийн 20 гаруй жил ашиглагдаагүй байна.

Хануйн голын бүсийн сумдаас Хайрхан, Эрдэнэмандал сум хамгийн их тариалангийн талбайтай нь юм. Тухайлбал: Хайрхан сум – 12498 га, Эрдэнэмандал – 1510.5 га, Цэцэрлэг – 967 га, Жаргалант – 75.0 га газрыг тус тус атаршуулсан мэдээтэй байна.

Эдгээрээс Эрдэнэмандал сум 12.5 га-д төмс-хүнсний ногоо тариалдаг аж. Энэ бүсийн үр тарианы талбайн гол нөөц нь Хайрхан, Эрдэнэмандал сумдад байгааг харгалзан үзэж атаршсан нийт газрын тодорхой хувийг дахин эргэлтэд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Харин Жаргалант, Цэцэрлэг сумд нь байгалийн бүс бүслүүрийн хувьд өндөр уулын болон уулархаг нөхцөлд оршдог тул хэдийгээр чийгийн хангамж сайн ч гэсэн жилийн дулааны нийлбэр 1200<sup>0</sup>С-1300<sup>0</sup>С-аас давдаггүй, нөгөө талаар агро-цаг уурын нөхцөл нь хүйтэвтэр учраас цаашид атаршсан газрыг тариаланд ашиглаад байх боломж муутай юм.

Иймээс дээрх 2 сумын нутагт орших атаршсан талбайг бэлчээрт шилжүүлэх нь оновчтой гэж үзэж байна. Ер нь 20 гаруй жил ашиглаагүй тариалангийн талбай байгалийнхаа аясаар бэлчээрийн ургамлын ргамлын төрөл, зүйл нь сэргэж бэлчээр болон хувирсан байдаг. Нөгөө талаар, агро-уур амьсгалын эрсдэлтэй нөхцөлд усалгаатай эрчимжүүлсэн газар тариаланг бага талбайд эрхэлж, богино хугацаанд түргэн боловсрох эрт сортын үр тарианы ургамал таримал тарих нь илүү үр дүнд хүрнэ. Тариалангийн атаршсан талбайг

бэлчээрт шилжүүлэх өөр нэг шалтгаан нь Хануйн голын бүсийн малын тоо сүүлийн жилүүдэд эрс өсөж, 598.5 мянган толгойд хүрч бэлчээрийн даац хүрэлцэхгүй болсон явдал юм.

**Хануйн голын бүсийн зарим ХАА-н зориулалтын газрын төлөвлөлт  
/га-гаар/**

	Сумдын нэр	2006-2013 онд ашиглах		2013-2021 онд ашиглах		Бэлчээрт шилжүүлэх	
		Тариалан	Хадлан	Тариалан	Хадлан	Атаршсан газар	Хадлан
Хануй голын бүс	Хайрхан	1874.7	1500.0	4125.3	500.0	6498.0	204.0
	Цэцэрлэг	-	860.4	-	1000.0	967.0	1007.6
	Жаргалант	-	500.0	-	-	75.0	683.0
	Эрдэнэмандал	453.2	2000.0	346.8	2351.0	710.5	-
	Дүн	2327.9	4860.4	4472.1	3851.0	8250.5	1894.6

Дээрх хүснэгтээс үзэхэд Хайрхан суманд богино болцын үр тарианы ургамлыг түлхүү тариалж, харин Эрдэнэмандал суманд малын ногоон тэжээл тариалах нь зүйтэй. Ингэхдээ үр тарианы эрчимжүүлсэн агротехникийн үйл ажиллагааг чухалчилж, хүн амын гурилын хэрэгцээг бага ч гэсэн хангах хэрэгтэй болно. Үүнээс гадна хүн амын хүнсний ногооны хэрэгцээг хангахын тулд хүлэмжийн аж ахуйнуудыг олноор бий болгох шаардлагатай.

**3.Өгийнуурын бүс**

Өгийнуурын бүсэд Хотонт, Хашаат, Өлзийт, Өгийнуур сумд багтдаг. Нийт 840.9 мянган га нутаг дэвсгэртэйгээс 751.0 мянган га бэлчээр, 16.2 мянган га атаршсан газар, 17.6 мянган га хадлантай. Хүн ам нь 14.5 мянга, малын тоо нь 501.4 мянга. Бүсийн төв нь Өгийнуур юм. Хашаат, Өгийнуур, Өлзийт сумын нутаг дэвсгэр бүхэлдээ, Хотонт сумын нутаг дэвсгэрийн тал хувь нь байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор тойргийн Х<sub>у</sub>-7-д хамаарагдана. Жилд дунджаар 90-140 мм хур тунадас ордог. Чийгшлийн К<sub>з</sub>= 3.0-5.0. Жилийн дулааны дундаж нийлбэр /+10<sup>0</sup>С-аас дээших/ 1950<sup>0</sup>С-2250<sup>0</sup>С. Далайн түвшнээс дээш дунджаар 1300-2000 м-т оршдог бүс нутаг юм.

Энэ бүс нутгийн жилийн дундаж дулааны нийлбэр бусад бүсүүдээс харьцангуй өндөр боловч хуурайшилт ихтэй, агро-цаг уурын нөхцөлөөр хуурайвтар сэрүүвтэр мужид багтдаг. Уулын хар хүрэн, хүрэн, нугын хүрэн хөрс зонхилно. Орхон болон Хойт Тамирын голууд энэ бүс нутгаар дайран өнгөрдөг.

Тариалангийн талбайнууд нь Орхон голын хөндийн нам дор газруудад голдуу байрласан байдаг. Иймээс энэ бүс нутгийг усалгаатай эрчимжүүлсэн тариалангийн гол бүс нутаг болгоход тохиромжтой. Одоогоор зөвхөн 22 га-д

төмс-хүнсний ногоо эрхэлж, 16.2 мянган га тариалангийн талбайг атаршуулаад байгаа нь сүүлийн жилүүдэд хур тунадас бага, хуурайшилт ихтэй байсантай холбоотой.

Иймээс цаашид атаршсан газруудыг ээлж дараатайгаар тариалангийн талбайн эргэлтэд оруулж, зарим бололцоотой тариалангийн талбайг усалгаатай болгож агротехникийн эрчимжүүлсэн технологиор үр тариа, ногоон тэжээлийн ургамал тариалах нь зүйтэй гэж үзэж байна. Ялангуяа Орхон гол, Хойт Тамирын голын дагуух нугын хүрэн хөрстэй газар усалгаатай төмс-хүнсний ногооны аж ахуй эрхлэх агроцаг уурын нөхцөл, боломж бий.

**Өгийнуур бүсийн тариалангийн болон хадлангийн газрын төлөвлөлт /га-аар/**

Бүс	Сумын нэр	Атаршсан газраас тариаланд ашиглах		Ашиглагдах хадлангийн газар		Бэлчээрт шилжүүлэх хадлангийн газар	
		2006-2013 он	2013-2021 он	2006-2013 он	2013-2021 он	2006-2013 он	2013-2021 он
Өгийнуур	Хотонт	3000.0	3386.0	3162.0	4216.0	3162.0	-
	Хашаат	1000.0	2046.0	1042.8	1390.4	1042.8	-
	Өлзийт	1000.0	2451.0	1064.0	-	-	-
	Өгийнуур	1200.0	2000.6	760.8	1014.4	760.8	-
	Дүн	6200.0	9883.6	6029.6	6620.8	4965.6	-

**4.Булган уулын бүс**

Булган уулын бүсэд Цэцэрлэг хот /Эрдэнэбулган/, Ихтамир, Булган, Цэнхэр, Төвшрүүлэх, Батцэнгэл зэрэг 6 сумын нутаг дэвсгэр нийт 1.6 сая га нутаг дэвсгэр хамаарна. Үүнээс бэлчээр 951.4 мянган га, тариалан 5.2 мянган га, атаршсан газар 18.0 мянган га, хадлан 23.6 мянган га байна. Энэ бүс нийт 38.6 мянган хүн амтай, 646.6 мянган малтай.

Нутаг дэвсгэр нь байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор тойргийн ХУ-2, Ху-3, Ху-7 гэсэн тойрогт хуваагддаг. Агро уур амьсгалын чийглэгдүү сэрүүн мужид хамаарагдана. Далайн түвшнээс дээш дунджаар 1500-2000 м-т өргөгдсөн. Хангайн нурууны хойт, зүүн хойт хэсэгт оршдог. Жилийн +10<sup>0</sup>С-аас дээш дулааны дундаж нийлбэр нь 1750<sup>0</sup>С-1950<sup>0</sup>С. Жилд 140-200 мм хур тунадас унадаг.

Чийгшлийн хуурайн зэрэг Кз = 2.0-3.0. Уулын хар шороон, хар хүрэн, аллювийн нугын хөрс зонхилно. Тариалангийн болон атаршсан газар, хадлангийн талбайн нөөц нь бусад бүсүүдээс харьцангуй их. Хойт, Урд Тамир, Цэнхэрийн гол нутаг дэвсгэр дээгүүр нь урсдаг.

1980-аад оны дунд үеэс төлөвлөлт хийгдсэн энгийн болон инженерийн хийцтэй услалтын системүүд Цэнхэр, Булган, Батцэнгэл сумын нутаг дэвсгэрт байрладаг.

**-Газрын мэргэжлийн байгууллага – Цогтхангай ХХК –**

Булган уулын бүсэд одоогоор ашиглагдаж байгаа 5204.6 га тариалангийн газраас гадна 17992.3 га атаршсан газар, 23626.0 га хадлангийн талбайг бүрэн ашиглахаар төлөвлөлтөд тусгаж байна. Үүнээс гадна Булган сумын Ар бэл дэх энгийн хийцтэй 274 га услалтын систем, Цэнхэр сумын Ширгүүгийн 408 га, Хонгорын амны 1341.0 га, Батцэнгэл сумын Сүүл толгойн 255 га зэрэг инженерийн хийцтэй хуучин төлөвлөгдсөн болон ашиглагдаж байсан услалтын системүүдийг цаашид ашиглахаар төлөвлөж байна. Түүнчлэн Цэнхэрийн халуун рашааныг түшиглүүлэн хүлэмжийн аж ахуй байгуулах асуудлыг төлөвлөлтөд тусгалаа. Булган уулын бүс нь хамгийн их хүн ам төвлөрсөн бүс бөгөөд ялангуяа Эрдэнэбулган сум буюу Цэцэрлэг хотод хүн амын дийлэнх нь амьдардаг. Иймээс Цэцэрлэг, хотын хүн амыг МАА-н болон газар тариалангийн бүтээгдэхүүнээр хангах асуудал түүнтэй хил залгаа сумдын анхааралд байх ёстой.

**Булган уулын бүсэд ашиглагдах тариалангийн болон хадлангийн талбайн төлөвлөлт**

Сумын нэр	Тариаланд ашиглагдах газар 2006-2013	Хадланд ашиглагдах газар				2013-2021	
		2013-2021	Үүнээс усалгаатай 2006-2013	2006-2013			
				2013-2021			
Эрдэнэбулган Их тамир Булган Цэнхэр	-	-	-	-	-	-	
	1629.0	-	-	-	2245.0	-	
	454.9	-	-	274.0	3965.0	-	
	643.0	-	408.0	-	13286.0	-	
	Төвшрүүлэх	8420.5	4052.2	-	-	2737.0	-
	Батцэнгэл	1279.5	1634.0	255.0	-	1393.0	-
	Дүн	12426.9	5686.2	663.0	274.0	23626.0	-

Ялангуяа Цэцэрлэг хотыг тойрсон бүсийн дагуул төвүүд байгуулах нь чухал бөгөөд хил залгаа сумдад МАА-н болон газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэх фермерийн бие даасан аж ахуйнуудыг олноор байгуулах шаардлагатай юм. Энэ шаардлагын үндсэн дээр тариаланд одоо ашиглагдаж байгаа болон атаршсан газруудыг эрчимжүүлсэн технологиор ашиглана гэж үзэж 2006-2013 онд 12.4 мянган га, 2013-2021 онд 5.7 мянган га тариалангийн ба атаршсан газруудыг цаашид бүрэн хэмжээгээр эргэлтэд оруулахаар төлөвлөлөө.

Үүнээс гадна 2006-2013 онд энгийн болон инженерийн хийцтэй 663.0 га, 2013-2021 онд 274 га усалгаатай тариалангийн талбайг ашиглан төв суурин газрын хүн амыг үр тариа, төмс-хүнсний ногоогоор хангаж чадна гэж үзэж байна. Түүнчлэн энэ бүсэд 646.6 мянган толгой мал төвлөрч байгаа нь МАА-н тэжээлийн хангамжийг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Энэ үндсэн дээр 23.6 мянган га хадлангийн талбайг 2006-2013 онд ямар нэг

хэлбэрээр усалгаажуулах, хамгаалж сайжруулах арга хэмжээ авч, бүрэн хэмжээгээр ашиглах нь зүйтэй гэж үзэв.

### **3.1.2.Бэлчээрийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент**

Архангай аймаг нийт 5 сая 531.4 мянган га нутаг дэвсгэртэй бөгөөд бэлчээрийн газар 3 сая 749.1 мянган га буюу 67.8 хувийг эзэлдэг. Үүнээс Хоргын бүс 35.1 хувь, Хануйн голын бүс 19.5 хувь, Өгийнуурын бүс 20.0 хувь, Булган уулын бүс 25.4 хувийг тус тус эзэлдэг аж.

Архангай аймгийн ИТХ, ЗДТГ, Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслөөс хамтран аймгийнхаа бүх баг, сум, хот айл, малчин өрхийн бэлчээр ашиглалтын өнөөгийн байдалд дүгнэлт хийхийн тулд ШУА-ийн газарзүйн хүрээлэнгийн НМС-ны төвтэй хамтран 70 гаруй хоног хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж, 5760 хот айлын хүн, малын тоо, бэлчээр, хадлан, уст цэг, өвөлжөө, хаваржааны байрлалыг тогтоон хөрс ургамлын 468 дээж авч шинжилжээ.

Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал ба хэтийн төлөвлөлтийг 1:100000 масштабын зурагт оруулан дүгнэлт гаргахын хамт “Бэлчээр ашиглалтын тогтвортой менежмент” зөвлөмжийг боловсруулж аймгийн ИТХ-ын ээлжит бус хурлаар хэлэлцүүлж тогтоол гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байгаа юм байна.

Иймээс аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнд бэлчээрийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийг тусгайлан дэлгэрэнгүй тусгах нь давхардсан ажил болох учраас ШУА-ийн холбогдох газраас боловсруулсан “Бэлчээр ашиглалтын тогтвортой менежмент” зөвлөмжийг энэхүү ерөнхий төлөвлөгөөний нэг хэсэг гэж үзэх нь зүйтэй болов уу.

Дээрх судалгааны явцад аймгийн нийт бэлчээрийн 22.8 хувь нь ямар нэг хэмжээгээр талхагдалд орсныг нарийвчлан тогтоож, бэлчээрийн даацыг тооцсоны үндсэн дээр өсгөвөл зохих малын тоо 3 сая 710.0 мянган хонин толгой байх нь зүйтэй гэж үзжээ. Энэ тооцоогоор бол аймгийн нийт малын тоо байвал зохих хэмжээнээсээ даруй 759.0 мянган хонин толгойгоор илүү байгаа юм.

Доктор (ph), дэд профессор Н.Надмидын бичсэн “Малчдын хоршоо, бэлчээрийн менежмент” номонд “Зарим эрдэмтдийн судалгаагаар улсын дунджаар 100 га бэлчээрт 62 хонь барих даацтай гэж үздэг” гэжээ. Тэгвэл дээрх тооцоонд үндэслэвэл Архангай аймгийн хувьд 4469.0 мянган хонин толгой малд 7208.0 мянган га бэлчээр шаардагдана гэвэл одоо байгаа бэлчээрийн газартай харьцуулахад 3 сая 459.0 мянган га бэлчээр дутагдана гэсэн үг юм.

**-Газрын мэргэжлийн байгууллага – Цогтхангай ХХК –**

Хэрэв манай эрдэмтэд улсын дунджаар 100 га бэлчээрт 62 хонь байвал зохимжтой гэж үздэг бол Архангай аймгийн бэлчээрийн даацыг доорх хүснэгтээр тооцож үзье.

д/д	Бүсийн нэр	Малын тоо /ХТШ-ээр/	Бэлчээрийн талбай /га/	100 га бэлчээрт ногдох хонин толгой	Хэтрэлт +/- Дутагдалт +/-
I	Хорго	1269830.1	1315214.6	96	+34
II	Хануйн гол	1014772.7	731435.7	138	+76
III	Өгийнуур	853338.9	751097.4	114	+52
IV	Булган уул	1331137.1	951384.7	140	+78
	Аймгийн дүнгээр	4469078.8	3749132.4	119	+57

Тайлбар: ХТШ коэффициент: - Тэмээ – 7  
 - Адуу – 6  
 - Үхэр – 6  
 - Хонь – 1  
 - Ямаа – 0.9

Дээрх хүснэгтээс үзэхэд аймгийн дүнгээр 100 га бэлчээрт 119 хонь ногдож байгаа нь байвал зохих хэмжээнээсээ даруй 57 хониор илүү байгаа бөгөөд эдийн засгийн дотоод бүсчилэлийн аль ч бүс нутагт бэлчээрийн даац үлэмж хэмжээгээр хэтэрсэн гэж тооцож болохоор байна.

Одоо бэлчээрийн тэжээлийн хангамжийг авч үзье.

**Бэлчээрийн тэжээлийн хангамж**

Бүсийн нэр	Индекс	Бэлчээрийн талбай /мян.га/	Бэлчээрийн 1 га-ын ургац /цн/га/	Бэлчээрийн нийт ургац /мян.тн/	Бэлчээрийн ургацыг тэжээлийн нэгжид шилжүүлвэл /мян.тн/	Шаардагдах тэжээлийн нөөц /мян.тн. тэж.нэгж/	Илүүдэл ба хомсдол /мян.тн. тэж.нэгж/
Хорго	Ху-2	351.3	4.3	151.0	63.4		
	Ху-3	542.0	4.4	238.5	100.2		
	Ху-4	421.9	3.5	147.7	62.0		
<b>Бүсийн дүн</b>		1315.2	-	537.2	225.6	266.6	-41.0
Хануйн гол	Ху-2	731.4	4.3	314.5	132.1		
<b>Бүсийн дүн</b>		731.4	-	314.5	132.1	213.1	-81.0
Өгийнуур	Ху-2	90.6	4.3	38.9	16.3		
	Ху-7	660.4	4.3	284.0	119.3		
<b>Бүсийн дүн</b>		751.0	-	322.9	135.6	179.2	-43.6
Булган сум	Ху-2	338.4	4.3	145.5	61.1		
	Ху-3	222.1	4.4	97.7	41.0		
	Ху-7	390.9	4.3	168.1	70.6		
<b>Бүсийн дүн</b>		951.4	-	411.3	172.7	279.5	-106.8

Тооцооноос үзэхэд аль ч бүсэд тэжээлийн хангамж хүрэлцээгүй байгаа нь харагдаж байна.

Тухайлбал: Хоргын бүсэд хонин толгойд шилжүүлснээр 1 сая 269.8 мянган малыг тэжээлээр хангана гэвэл бэлчээрийн тэжээлийн хангамжийг тооцоод цаана нь 41.0 мянган тн тэжээлийн нэгж дутагдаж байгаа нь харагдана.

Хамгийн их тэжээлийн хангамж дутагдалтай бүс нь Булган уулын бүс юм. Жилдээ 106.8 мянган тн тэжээлийн нэгж дутагдаж байна. Энэ мэтчилэнгээр малын тоо байх ёстой хэмжээнээсээ хэт өссөнөөс бэлчээр талхлагдаж тэжээлийн хомсдолд ордог учраас бүс тус бүртээ энэ чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэхээс өөр аргагүй юм. Атаршсан газар, хадлангийн газрын боломжтой хэмгийг аж ахуйн эргэлтэд оруулах талаас онцгой анхаарч ногоон тэжээл тариалах, бэлчээр ашиглалтын менежментийг сайжруулах, хадлангийн талбайг бордох, усалгаажуулах, зүй зохистой ашиглахын учир утга үүнд л оршино.

**ХАА-н газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийн талаарх дүгнэлт:**

ХАА-н газрын нөөц нөхцөлийн төлөвлөлт, түүний менежментийг боловсруулах явцад дараах дүгнэлтэд хүрлээ.

1.Аймгийн хэмжээнд 51.9 мянган га атаршсан газар, 53.9 мянган га хадлангийн талбайтай гэж Газрын нэгдмэл сангийн ангиллын тайланд тусгагдсаар ирсэн боловч 1980-аад оны дунд үеэс дээрх дэд ангиллын газрууд ашиглалтгүй явсаар өдий хүрчээ. Өөрөөр хэлбэл дээрх газрууд нь байгалийнхаа аясаар эргээд бэлчээрийн газар болон хувирсан байна. Манай эрдэмтдийн тооцоолсноор сүүлийн 60 жилд Монгол орны жилийн дундаж температур 1.56 хэмээр нэмэгдсэн гэж үзэж байсан бол хамгийн сүүлийн үеийн мэдээгээр энэ тоо 2 хэмээс хэдийн давж, түүний дотор сүүлийн 10 гаруй жилийн байдал улам ч тод улам хүчтэй өөрчлөлтийг харуулах боллоо.

Зөвхөн сүүлийн 30 жилд тариалангийн төв бүсийн хүйтрэлгүй хоногийн тоо 14 өдрөөр, +5<sup>0</sup>С хэмээс дээш дулаантай хоногийн тоо 12 өдрөөр нэмэгдсэн байна. Энэ нь гангийн давтагдах магадлалыг өндөрсгөж байгаа бөгөөд газар тариалангийн үйлдвэрлэлд хөрсний элэгдэл, эвдрэл гамшгийн шинжтэйгээр явагдаж, хөрсний унаган үржил шим огцом буурч, цөлжилтийн явц эрс эрчимжиж, Хангайн бүсэд ч цөлжилтийн голомтууд үүсэж байна. Ингэж байгальцаг уурын нөхцөл өөрчлөгдөж байхад атаршсан газрыг дахин эргэлтэд оруулах тухай асуудлыг хатуу шаардах боломжгүй юм.

Ялангуяа өндөр уулын Хоргын бүс, Хануй голын бүсэд байгаль-экологийн нөхцөлийг нь харгалзахгүйгээр тариалангийн болон атаршсан газрыг ашиглахаар төлөвлөлт хийх нь утга учиргүй санагдана. Ер нь сүүлийн үед



усалгаагүй газар тариалан асар их эрсдэлтэй ба зарцуулсан хөрөнгө, хүч ямар ч үр дүнд хүрэхгүй үрэгдэх явдал түгээмэл болсон байна. Ийм учраас Хоргын бүсийн 2827.5 га Хануйн голын бүсийн 8250.5 га, Өгийнуурын бүсийн 4965.6 га атаршсан газруудыг бэлчээрт шилжүүлэх нь зүйтэй гэж үзсэн юм. Бэлчээрт шилжүүлэх тохиолдолд “Тариалангийн тухай” хуулийн 14-р зүйлийг баримтлах хэрэгтэй.

Харин 2006-2013 онд цаашид ашиглагдах тариалангийн 1.2 мянган га талбайд 61.9 сая төгрөгийн нөхөн сэргээлт хийхээр улсын ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнд тусгасныг хэвээр үлдээж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хадлангийн талбайн хувьд мөн л сүүлийн 20 гаруй жил ашиглагдаагүй бөгөөд “хадлангийн газар” гэдэг мөн чанараа алдаж бэлчээрт ашиглагдсаар иржээ. Сүүлийн жилүүдэд хадланг усгүй, эсвэл хэт алслагдсанаас ашиглагддаггүй бэлчээрээс хадах болсныг ч анхаарах хэрэгтэй. Иймээс Хоргын бүсийн 2062 га, Хануйн бүсийн 1894.6 га, Өгийнуурын бүсийн 4965.6 га хадлангийн газрыг бэлчээрт шилжүүлэхээр төлөвлөв. Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд ер нь бүх аймгуудын атаршсан газар болон хадлангийн газруудыг эргэн харж “ашигладаг”, “ашигладаггүй” – ээр нь ялгаж салган нэг тийш нь болгох нь зүйтэй гэж үзэж байна. Цаашид хөрөнгө нь батлагдвал 2006-2013 онд 1.2 мянган га, 2013-2021 онд 2.2 мянган га хадлангийн талбайг нөхөн сэргээх шаардлагатай.

2.Олон жил ашиглаагүй атаршсан газар болон хадлангийн газрыг бэлчээрт шилжүүлж байгаатай холбогдуулан хүн амыг үр тариа, төмс-хүнсний ногоогоор хангах, МАА-н тэжээлийн хангамжийг сайжруулах чиглэлээр орчин үеийн зах зээлийн нөхцөлд тохирсон бодлого боловсруулан мөрдөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, усалгаатай газар тариалан, хүлэмжийн аж ахуй, ашиглагддаггүй бэлчээрээс хадлан бэлтгэдэг фермерийн аж ахуй зэргийг хөгжүүлэх нь чухал байна.

Архангай аймгийн хувьд Хоргын бүсийг зөвхөн МАА-н үйлдвэрлэлийн, Хануйн голын бүсийн Хайрхан сумаас бусад сумдыг МАА-н үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг болгох нь зүйтэй. Мэдээжийн хэрэг, хүлэмжийн аж ахуй, аялал-жуулчлал бусад үйлдвэрлэл-үйлчилгээ давхар явагдах нь ойлгомжтой.

Байгалийн бэлчээр хүний үйл ажиллагаа болон байгаль-экологийн нөхцөлөөс шалтгаалан талхлагдах, цөлжих, ургамлын төрөл зүйл нь өөрчлөгдөх зэргээр мал бэлчээрлэх нөхцөл нь улам муудсаар байна. Хэдийгээр бэлчээрийг зүй зохистой ашиглуулах талаар маш олон төрлийн гадаадын болон дотоодын төсөл хэрэгжиж байгаа нэртэй боловч эцсийн үр дүн тун хангалтгүй байгаад

анхаарах цаг болжээ. Бэлчээр ашиглалтын талаар шинжлэх ухааны болон мэргэжлийн байгууллагуудаас олон янзын хөтөлбөр, заавар зөвлөмж аймаг, орон нутагт хүргүүлдэг боловч бэлчээрийг нөхөн сэргээж, жил, улирлын хуваарьтай ашиглах асуудал үндсэндээ жигдрэхгүй байна. Энэ нь бэлчээр усжуулалттай нягт холбоотой. Нэгэнт усжуулагдаагүй бэлчээр учраас хичнээн сайхан бэлчээр байгаад мал тогтохгүй нь мэдээж. Үүнээс үүдэн тодорхой хэмжээний бэлчээрт малын бөөгнөрөл үүсэж, түүнийг дагаад машин техник, хүний үйл ажиллагаа идэвхиждэг нь бэлчээр талхлагдалтын үндсэн шалтгаан болж байна. Улсын ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний дагуу 2006-2013 онд 331.7 мянган га, 2013-2021 онд 331.7 мянган га нийт 663.4 мянган га бэлчээрт нөхөн сэргээх арга хэмжээ авах нь чухал. Үүнд улсаас 10612.8 сая төгрөг зарцуулагдахаар төлөвлөгдсөн болно.

### **3.2.Хот, тосгон бусад суурин газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент**

Аймгийн хэмжээнд хот, тосгон бусад суурин газарт 9486.7 га газар хамрагддаг бөгөөд үүний дотор Хоргын бүсэд 398.1 га, Хануйн бүсэд 528.1 га, € гийнуурын бүсэд 520.8 га, Булган уулын бүсэд 8039.7 га газар тус тус ногддог. Сумдын ИТХ, ЗДТГ-аас санал авахад Эрдэнэбулган сумаас бусад сумд сумын төвийн тэг гортигоо өөрчлөх саналгүй байлаа. Иймээс ерөнхий төлөвлөгөөнд талбайг нь хэвээр тусгахаар төлөвлөв.

Харин Эрдэнэбулган сумын хувьд Цэцэрлэг хотын төвийг зүүн, зүүн урагш гэсэн чиглэлээр нэмэгдүүлэх шаардлагатайг Засаг даргын Тамгын газраас санал болгож байв. Гэвч газрын орон зайн сонголтоор Их тамир сумын Шивэртийн халуун рашааны чиглэлд Эрдэнэбулган сум буюу Цэцэрлэг хотын тэг гортигийг тэлэхээр төлөвлөж байна. Энэ нь Хойт, урд Тамирын голын дунд орших нутаг бөгөөд нийт 62.5 мянган га талбай юм.

Хот, тосгон бусад суурин газрын ангилалд багтах газраас Хоргын бүсийн Тариат сум, Хануйн бүсийн Эрдэнэмандал сум, Өгийнуур бүсийн Өгийнуур сум, Булган уул бүсийн Эрдэнэбулган сум буюу Цэцэрлэг хот нь бүлэг суурингийн тогтолцоогоор тус тусын бүсүүдийн төв болгохоор төлөвлөгдөж байна. Иймээс эдгээр бүсийн төвүүдийн ирээдүйн хөгжилд онцгой анхаарч, бүсийн төвийн хот байгуулалтын төлөвлөгөөг бүсийн татлалцал, хөгжлийн онцлог, давуу талыг харгалзан үзэж боловсруулах зайлшгүй шаардлагатай. Ялангуяа бүсийн төвийг тойрсон төмс-хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй, мах, сүү үйлдвэрлэлийн фермерийн аж ахуй, жимс-жимсгэний аж ахуйг түлхүү хөгжүүлэх нь аймгийн нийгэм-эдийн засгийн бодлогын нэг хэсэг болох учиртай. 2006-2013 онд Тариат,

**-Газрын мэргэжлийн байгууллага – Цогтхангай ХХК –**

Өгийнуур, Цэцэрлэг хотын орчим, 2013 оноос Эрдэнэмандал сумын эргэн тойронд дээрх чиглэлийн аж ахуйнуудыг төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Уурхайн дэвсгэр газрын хувьд Их тамир сумын нутаг дэвсгэрт 9 га, Цэнхэр сумын нутаг дэвсгэрт 4904 га бүгд 4913 га газарт хамрагддаг. Иймээс хамгийн гол нөхөн сэргээлт хийж, анхаарах ёстой газар нь Цэнхэр сумын алтны уурхай юм. Жил бүр алт олборлосон газраа нөхөн сэргээхэд хяналт тавьж байх ёстой.

Хот, тосгон бусад суурины газарт хамгийн чухал байр суурийг аялал жуулчлал, амралт, рашаан сувиллын газар эзэлдэг.

**Архангай аймгийн аялал жуулчлал, рашаан сувилал, рекреацийн газрын байршил, хэмжээ /га-гаар/**

д/д	Сумын нэр	Газрын нэр	АЖ, РС, РЦ	Талбайн хэмжээ	Тайлбар
1	Хашаат	Номгон уул	АЖ	2.0	1. УТХГН-т байрладаг газруудыг тооцоогүй 2. АЖ – аялал жуулчлал РС – рашаан сувилал РЦ – рекрсацн гэж төрөлжүүлэв 3. Газрын балансад тусгагдаагүй хэсгийг оруулав  Нийт дүн 13.7 га
2	Хотонт	Цагаан сүм	РС	1.2	
3	Өгийнуур	Баярт хясаа	АЖ	2.5	
4	Цэнхэр	Цэнхэрийн ХР	РС	1.0	
5	Эрдэнэбулган	Булган уул	АЖ	2.0	
6	Их тамир	Тайхар чулуу	АЖ	2.0	
7	Чулуут	Чулуут, Улаан эрэг	РС	1.0	
8	Батцэнгэл	Шивэртийн ХР	РС	2.0	
	Дүн			13.7 га	

Дээр дурдсан ангиллын газрыг төлөвлөхдөө Хоргын болон Хануйн бүсийг байгалийн үзэсгэлэнт газрын, Булган уул, Өгийнуурын бүсийг түүх дурсгал, танин мэдэхүйн чиглэлээр аялал-жуулчлал хөгжүүлнэ гэж үзэв. Түүнээс гадна Цагаан сүм, Цэнхэр, Шивэрт, Чулуут, Ноёнхангай зэрэг азотын халуун рашаануудыг түшиглүүлэн гадаадын болон дотоодын эмчилгээ, сувилгааны газрууд байгуулах нь зүйтэй юм. Аялал-жуулчлал хөгжүүлэх, эмчилгээ сувилгааны чиглэлээр одоо ашиглагдаж байгаа болон цаашид ашиглагдах газруудын тодорхойлолтыг дараах байдлаар дэлгэрэнгүй тусгаж байна.

Архангай аймагт аялал жуулчлал голлон хөгжиж байгаа газар нь Өвөрхангай аймгийн Хархорин сумаас цаашхи төв замын дагуух хил залгаа нутаг, Хорго-Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолбор газар, Ноён Хангайн байгалийн цогцолбор газар, хангайн нурууны байгалийн цогцолбор газрууд юм.

**Аяллын боломжит чиглэлүүд**

Улаанбаатараас Хархорин 370 км, Хотонт 37 км, Төвшрүүлэх 52 км, Цэнхэр сум 15 км, Цэцэрлэг хот 29 км, Аялах замын урт 150 км, аялах хугацаа 1.2 хоног. Хархориноос Хашаат сум 42 км, Өгийнуур сум 50 км, Хотонт сум 35 км, буцаад Хархорин 37км. Аялах замын урт 200 км, аяллын хугацаа 1-2 хоног.

### Эдгээр чиглэлд үзэх зүйлс

“МТС” ХХК-ийн “Бүрд” жуулчны бааз Архангай аймгийн Хашаат сумын Номгон уулын энгэрт Хүрийн дэнж гэдэг газар байрладаг. 30 гэртэй, 120 хүн нэг зэрэг хүлээн авах бололцоотой. 2 га газар ашигладаг.

**Хар балгас** Хархорин хотоос баруун хойш 40 км орчимд Хотонт сумын төвөөс зүүн хойш 11 орчим км-т Орхон голын зүүн гар талд Хар балгас оршдог. 751 онд байгуулагдсан 1Х зууны үеийн Уйгар улсын нийслэл Ордубалык буюу Балыклык хотын туурь Харбалгас нь Төв Азиар дайрч өнгөрч байсан торгоны замын салааны төв газруудын нэг нь бэхэлгээтэй цайз, худалдааны төв байжээ.

Хар балгас, Хархорум хотууд нь Монголын нутгаар явах торгоны замын салааг 400 жил хянаж байсан газар гэж үздэг.

Хааны хэрэмт орд харш, гар үйлдвэр, цайз, агтны хашаа, цэргийн ба худалдааны агуулах, захиргааны барилгын хэрэмт туурь байдаг. Энэ дурсгалыг 1971 онд улсын хамгаалалтад авч, 1996 онд ЮНЕСКО дэлхийн соёлын өвд бүртгэн авчээ.

Хотонт сумын нутагт Хар балгаснаас хойш холгүй орших Дойтын толгойн туурийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**Хөшөө цайдам** Хархорин хотоос хойш 40 км-т Хар балгаснаас зүүн тийш 20 гаруй км-т орших Ү1-ҮШ зууны үед мандаж байсан Түрэг улсын Билгэ хаан, түүний ах Культиген жанжин нарт зориулан 732 онд Культигений ач хүү Йолугтегиний бичсэн бичигт хөшөө, түүхийн шинжлэх ухаанд Орхоны бичээс гэж алдаршсан ховор нандин энэ чулуун хөшөө 3.3 м өндөр, 1.3 м өргөн. Энд 68 мөр бичээс байдаг. Энд бүхэл бүтэн цогцолбор байсан бөгөөд одоо зөвхөн хөшөө л үлджээ. 1961 онд улсын хамгаалалтад авсан. ЮНЕСКО 1996 онд дэлхийн соёлын өвд бүртгэн авчээ.

**Цагаан сүмийн халуун рашаан нь** далайн түвшнээс дээш 1840 м өндөрт оршино. Рашаанаас 4 км зайтай газарт эртний том хот балгасын эвдэрхий үлдэгдэлтэй. Мөн рашаанаас дээш 24-25 км орчимд Цагаан сүм гэдэг эртний эвдэрхий балгастай. Эн энх Хархорин хотыг нийслэл байх үед хаадын зуслан Цагаан орд гэж байжээ. Рашааны хавьд булш олон байхын дээр рашааны ундарга дээр нүхтэй бөмбөгөр хэлбэртэй засмал боржин чулуу тавиад түүний нүхээр оргилуулж, бас ховилтой засмал боржингоор урсган онгоцонд орж байжээ. Цагаан сүмийн рашааныг Чонот, Хан Өндөр, Гүгэш уул, Төмөр хайрхан, Өндөр сант зэрэг ой модтой уулс хүрээлнэ. Цагаан сүмийн голын цэлгэр уудам хөндийн орших ба рашаанаас урагш 4-5 км-д шинэсэн ой модтой.

Цагаан сүмийн голын хөндийд энэ рашааны дэргэдүүр дөрөвдөгч галавын буюу одоо цагийн голын хурдас их бөгөөд эргэн тойрон зүлэг хучсан хувирмал занар чулуун сайрнаас энэ рашааны 5-6 булаг оргилон арваад метр урсаад голд цутгана. Нөөц нь хоногт 88 м<sup>3</sup>. Халуун нь 42-69 хэм байна. 0.46 г.л эрдэмжилттэй, гидрокарбонат-сульфат-карбонат-натрийн найрлагатай рН 8.85, Eh 10 MB, цахиурын хүчил, фтортой, азотын халуун рашаан.

“Мон-Оса” ХХК-ийн жуулчны бааз Хотонт сумаас баруун урагш 55 км Цагаан сүмийн халуун рашааны дэргэд байрладаг. 1.2 га газар ашигладаг. Нэг ээлжид 24 хүн хүлээн авах бололцоотой.

Хархориноос Орхоны Хар балгас 40 км, зүүн тийшээ Орхоныг гаталж Хөшөө цайдам 25 км, Хашаат сумаар дайрч зүүн хойш Хар бухын голын балгас 87 км, Дашинчилэн сум 13 км, Чинтолгойгоор дайрч Цогтын цагаан байшин 50 км, цааш Баян нуур сум, Төв аймгийн Лүн сумаар дамжин Улаанбаатар хотод ирнэ.

### **Энэ чиглэлд үзэх зүйлс**

**Өгий нуур** Өгий нуур сумын нутагт далайн түвшнээс дээш 1387 м өндөрт өргөгдсөн загас агнуурын ач холбогдол бүхий алгана, цурхай зэрэг загас элбэг. Жилд 50 тонн загас агнах нөөцтэй. Халбаган хушуут, борцгор хотон, хушуу галуу, цэн тогоруу зэрэг ховор шувууд байдаг.

Өгий нуураас баруун тийш 5 км орчимд Хөгшин Орхон, Орхон, Өгий нуурын хоолойн хооронд усан хүрээлэлд орших Чилин хийдэд очиход бэрхшээлтэй тул 1 км орчим зайнаас харна.

“Загасчин” ХХК-ийн “Өгий нуур” жуулчны бааз Өгий нуур сумын төвөөс зүүн тийш 25 км, Өгий нуурын зүүн эргийн Баярт хясааны урд байрладаг. 2.5 га газар ашигладаг. Нэг ээлжинд 65 хүн хүлээн авах бололцоотой. Улаанбаатар хотоос 400 км зайд орших бөгөөд нийт замын 310 км нь хатуу хучилттай замаар, 90 км шороон зам болно. Хархорин хүртэл 75 км, Булган аймгийн Рашаант сум хүртэл 21 км.

Загасчлах цэг, загас хадгалах зоорь, усанд сэлэх, наранд шарлагын газар катарман, сэлүүрт завь, моторт болон резинэн завиар үйлчилдгээрээ орчны бусад баазуудаас давуу талтай.

Монгол оронд Түрэг бичээстэй хөшөө 40 гаруй байдгийн 10 гаруй нь Орхоны хөндийд байдаг.

Хангайн нурууны Байгалийн цогцолбор газрын Аялал жуулчлалын бүсийн хэсэг 29400 га Архангай аймгийн Булган, Цэнхэр сумын нутаг Хашлага, Их бага Дөрвөлжин, Үйзэн бүрхээр, Манхан, Гялаан, Шар булуу уулсаар бүсийн хил нь тогтоогдсон Суварга хайрхан, түүний араас эх авсан Цэнхэр, Ширдгийн

голуудын эхний ой хөвч бүхий газар нутаг орно. Энд хушин тайга багахан хэсэгт бий. Ховор амьтан ургамалтай. 3 аймгийн хил залгаа сумдын ард иргэд аяллын журмаар зун, намрын улиралд Суварга хайрхан ууланд байнга гардаг.

**Цэнхэрийн халуун рашаан** Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт Цэнхэрийн голын зүүн салаанд цутгах Цэнхэрийн халуун рашаан далайн түвшнээс дээш 1860 м өндөрт байдаг. Цэцэрлэг хотоо зүүн урагш шулуунаар 25 км, Төвшрүүлэхээс баруун урагш 24 км тус тус зайтай. Аль ч талаас нь машин тэрэг саадгүй хүрдэг хойд энгэрээрээ өвс ногоо ихтэй, урд араараа битүү модтой.

Цэнхэрийн гол, Халуун усны амны горхи зэрэг ам хөндий жалга болгон устай. Рашааны хавьд хуучин төрмөлийн эриний их хувирсан тунамал чулуулгаас гадна герциний үеийн бүдүүн ширхэгт цайвар боржинтой. Халуун усны амны урд хажуугийн хувирмал хөх занар дотроос 65-90 хэмийн халуунтай 5-6 булаг оргилон зүүн хойшоо 20-30 м урсаад Халуун усны горхинд нийлнэ. Рашааны ихээр хувирмал занар, хадан цагаан, жижиг хайр, үйрмэг чулуу рашаанаас ялгарсан эрдэс бодистой наалдаад хөр чулуу шиг шавалдан тогтжээ. 0.33 г/л эрдэсжилттэй, гидрокарбонат-сульфат-карбонат-натрийн найрлагатай, рН 8.8, Eh 70 MB, фтор цахиурын хүчил, хүхэрт устөрөгчтэй, азотын халуун рашаан.

“Бриж” ХХК-ийн “Цэнхэр жигүүр” жуулчны бааз Цэцэрлэг хотоос зүүн урагш 27 км, Цэнхэр сумаас баруун урагш 25 км, Халуун усны аманд байрладаг. 8 гэртэй нэг ээлжинд 30 хүн хүлээн авах бололцоотой. 1 га газар ашигладаг.

Цэнхэр сумын нутагт Цэцэрлэг голын савд Эрдэнэтолгой гэдэг газар Их хүрээ 1700-гаад оноос 17 жил суурьшин Их хүрээ нэрийг авчээ. Батцагаан цогчин дуган энд баригдаж байжээ.

Цэнхэр сумын нутаг хуучин чулуун зэвсгийн дээд буюу 40-12000 жилийн өмнөх үеийн дурсгалын зүйлс байдаг.

**Булган уулын Байгалийн дурсгалт газар** Архангай аймгийн төв Цэцэрлэг хотыг хойд талаас нь нөмөрлөн орших сүрлэг сайхан 1980 м өндөр уул. Булган уулыг 1840 га талбайтайгаар 1965 оноос улсын тусгай хамгаалалтад авчээ. Эгц цавчим энэ уулын 40 орчим хувийг таг, царам, хад асга эзэлнэ. Ар, баруун, зүүн сугаар нь шинэс голлосон ой ургана. Ойн сан бүхий талбай нь 738 га. Энгэр өвөр нь эгц нүцгэн хадан халил болно.

Цэцэрлэг хот нь 1616 онд байгуулагдсан Зая бандид хутагтын хүрээний суурин дээр байгуулагдсан бөгөөд энэ хийдийн цогцолборыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

Ой, ан, жуулчин нэгтгэлийн харъяа “Гурван тамир” жуулчны бааз Цэцэрлэг хотоос зүүн тийш 1.5 км Булган уулын зүүн суганд оршдог. 4.33 га газар ашигладаг. 3 байшин, 13 гэртэй. Нэг ээлжид 40 хүн хүлээн авах бололцоотой. 2 га газар ашигладаг.

Цагаан давааны арын Арцатын аманд буган чулуун хөшөөнүүдэд амьтны зураг байдаг.

Цэцэрлэг хотоос Тайхар чулууг дайран Их тамир сум 27 км, Хужиртын даваа 16 км, Хануйн гол 25 км, Донгойн даваа 26 км, Тээлийн гол 24 км, Чулуут голын гүүр 24 км, Гучин хоёр салаа мод 5 км, Гичгэнэ голыг гарч Тариат сум 35 км, баруун хойшоо Суман голыг гаталж Хорго уул 10 км, Тэрхийн цагаан нуур, Өвгөн хад 10 км, эргээд Тариат сум 20 км. Аялах замын урт 250 км, аялах хугацаа 2-3 хоног.

Тариат сумаас зүүн тийшээ Суман голыг уруудан Чойдогийн боргио 55 км, Чулуут голын гүүр 40 км цааш Цэцэрлэг хот руу буцаж болно.

### **Энэ чиглэлд үзэх зүйлс**

Хангайн нурууны Байгалийн цогцолбор газрын Аялал жуулчлалын бүсийн В хэсэг 2400 га Архангай аймгийн Их тамир сумын хойд Тамирын голын эх, Хөх нуур орчмын газар нутаг хамрагддаг. Энэ маршрутаар Хангайн нурууны салбар уулын оройд тогтсон цэнгэг устай Хөх нуурыг үзэхээс гадна өвөрмөц сонин тогтоц, үзэсгэлэнтэй газрууд, амьтан ургамлыг үзэх боломжтой юм.

Хөх нуурын орчимд шинээр аялал жуулчлалын бааз байгуулах, загасчлах цэг тогтоох, амьтан, шувуу ажиглах цамхаг байгуулах бололцоотой.

Хөх нуур багийн төвөөс Хөх нуур хүртэл мориор юм уу явганаар аялах бололцоотой.

Хангайн нуруунаас Хойд, Урд тамирын голууд эх авч урсаад хоорондоо нийлж Тамирын гол болон 280 км урсаад Орхон голд нийлнэ.

**Тайхар чулуу** Тамирын голын хөвөөнд орших герциний үеийн бүдүүн ширхэгт боржингоос тогтсон 10 гаруй м өндөр цохиог Тайхар чулуу гэдэг. Эртний зосон хадны бичээс бүхий Тайхар чулууг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

“МАТ” ХХК-ийн “Тайхар” жуулчны бааз Цэцэрлэг хотоос 22 км, Их тамир сумаас зүүн тийш 5 км зайд Тайхар чулууны дэргэд ажилладаг. 20 гэртэй, нэг ээлжид 56 хүн хүлээн авах бололцоотой. 2 га газар ашигладаг.

Их тамир сумын нутаг Алтан Сандаг уулын шилд орших дөрвөлжин булшинд адууны зурагтай хүрэл зэвсгийн үед холбогдох буган чулуун хөшөө байдаг.

Их тамир сумын Бугатад буга агнуулах зорилгоор ангийн отог байгуулсан.

Хануйн гол Хангайн нуруунаас эх авч зүүн хойш 421 урсаад Сэлэнгэ мөрөнд цутгана.

Чулуутын гол нь Хангайн нурууны Эгийн даваанаас эх авч хойшоо 415 км урсаад Идэр, Дэлгэр мөрөнтэй нийлж Сэлэнгэ мөрөн болно. Чулуутын гол Тээлийн голын адгаас Ацатын гол хүртэл 100 км эгц гүнзгий 50 м орчим өндөр галт уулын хүрмэн чулуун хавцал дундуур урсдаг. Энэ хүрмэн чулуу нь Хорго ба түүний хавийн галт уулнаас бялхан гарсан магма юм. Чулуутын гүүрний орчимд спорт агнуур хөгжүүлэх бололцоотой.

Чулуут голын сав дагуу Чулуут, Тариат, Жаргалант, Цэцэрлэг сумдын нутгаар орших хадны сүг зургуудыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

Чулуут сумын нутагт Чулуутын рашааныг үе мөч, ходоод гэдэсний өвчинд ууж хэрэглэдэг. Нөөц нь хоногт 150 м<sup>3</sup>, 0.4 г/л эрдэсжилттэй, гидрокарбонат-сульфат-карбонат-натрийн найрлагатай, рН 8.8 – 9.3 Eh 45 МВ цахиурын хүчил, фтортой, азотын 45 хэмийн халуун рашаан.

Чулуут сумын нутагт Улаан эргийн рашааныг хоол боловсруулах эрхтний өвчнийг анагаахад хэрэглэдэг. Нөөц нь хоногт 10-12 м<sup>3</sup>.

### **Хорго - Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолбор газар**

**Хорго** – Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолбор газар Хангайн нурууны салбар Тарвагатайн нуруунд оршдог. Физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг мужийн уулын нуга, ян сарьдагийн дэд бүслүүрт багтана. Галт уулын гаралтай Тэрхийн цагаан нуур далайн түвшнээс дээш 2060 м өндөрт оршдог ба түүнээс 3 км зайд Хөдөө нуур байдаг. Эргэн тойрон уулсаар хүрээлэгдэнэ, уулсын дундаж өндөр нь 2500-3000 м, хамгийн өндөр цэг Хутаг уулын оргил нь 3132.6 м юм.

**Геологийн тогтоц:** Тэрхийн цагаан нуурын хавь орчмын уулс нь геологийн гарал үүслийн хувьд девоны үеийн боржин чулуу, дөрөвдөгч галбын галт уулын гаралтай хүрмэн чулуунаас тогтоно. Түүнчлэн хожуу үеийн гол мөрний хурдас чулуулаг нэлээд зузаан тархжээ. Энд илэрсэн ашигт малтмал ховор бөгөөд барилгын материал болох галт уулын хөнгөн чанартай үнс чандруу, хүнд хөнгөн янз бүрийн хүрмэн чулуу элбэг байдаг. Хоргоос урагш холгүй 20 км-т орших Шаварын царам уулнаас геологчид анар зэрэг эрдэнийн чулуу олжээ. Ойн сан бүхий газар нь 13854 га.

**Тэрхийн цагаан нуур нь** галт уулын хүрэм голуудын хөндийг боосноос үүссэн бөгөөд Хангайн гол нурууны салбар уулсын хоорондох давчуу хөндийд өргөргийн дагуу баруунаас зүүн тийшээ сунаж тогтсон зууван хэлбэртэй.



### Тэрхийн цагаан нуурын морфометрийн үзүүлэлтүүд

	Морфометрийн үзүүлэлтүүд	
1	Урт	16 км
2	Хамгийн их өргөн	10 км
3	Хамгийн бага өргөн	1.4 км
4	Дундаж өргөн	4 км
5	Эргийн шугамын урт	66 км
6	Усны гүн	6-20 м
7	Усны эзлэхүүн	0.368 м
8	Нуурын талбай	61 м

Нуур 7880 х.д.км. талбайгаас усжих 10 гаруй гол горхи цутгахаас хамгийн том нь Хойд, Урд Тэрхийн гол бөгөөд илүүдэл усаа Суман голоор дамжуулан Чулуутын голд өгнө. Нуурын хойноос Доод Нарийн, Шанаат, Нарийн, Өвөр Сөрт зэрэг голууд, өмнөөс нь Өлт, Элст, Ар Сөрт, Ар Хар Чулуут зэрэг олон гол горхи цутгана. Нуурын үндсэн тэжээл нь хур бороо, гадаргын урсац болно.

Нуур намар эрт 10-р сарын сүүлчээс хөлдөж, хавар орой 5-р сарын сүүлчээр гэснэ. Мөсний зузаан 4-р сард 150-180 см хүрнэ. Усны температур зун өнгөндөө 15-19 хэм, ёроолдоо 8-12 хэм бол өвөл 2 м гүнд 1.2 хэм, 4-5 м гүнд 2.3 хэм, 8-10 м-ийн гүнд 3 хэм, ёроолдоо 4.0-4.3 хэм хүртэл нэмэгдэж зундаа шууд, өвөлдөө эсрэг үелэл үүсгэнэ. Нуурын бүлээн урсгалын нөлөөгөөр Суман гол нуураас гарах хэсэгт 2 км орчим харзалж, усны шувууд өвөлжих удаа ч бий. Хөдөө нуурын талбай 10 гаруй км<sup>2</sup>.

**Чойдогийн боргио** Суман гол Тэрхийн цагаан нуураас эх аван урсахдаа 20-иод м зузаан хүрмэн хадыг зүсэж нарийн хавцал үүсгэн урсаад 50 гаруй км-ийн цаана Чулуутын голд цутгана. Чулуут Суман голуудын бэлчрээс доош 2 км орчимд 2 м орчим эгц хадан босго руу хүрхрээ болон буудаг. Хавартаа энд гол өгсөж яваа Сэлэнгийн савын загас цуглаж боргио өөд үсрэн дүүлэх нь сонин.

Тэрхийн цагаан нуурт алгана, цурхай, улаан нүдэг, зэвэг, сибирь хадран, гутаар, сахалт эрээлж, сахалт яралз, ердийн гүрц, нүцгэн жараа зэрэг 9 зүйлийн загас тэмдэглэгдсэний эхний 6 нь агнуурын ач холбогдолтой.

Байгаль орчны сайдын 1996 оны 12-р сарын 18-ны өдрийн 222-р тушаалын 1-р хавсралтаар Хорго – Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолбор газрын бүсүүдийн хилийг тогтоосон бөгөөд аялал жуулчлалын бүс нь 10350 га болж байна.

Хоргын тогооны орчныг Тэрхийн цагаан нуурыг аялал жуулчлалын бүсэд оруулсан. Энд аялал жуулчлалын сонирхон үздэг Шар нохойн там, Мөсөн

хонгил, Залуучууд агуй, Хорго доторх цэнгэг ус загас ихтэй жижиг нуурууд, Өвгөн цохио, загас барих цэгүүд зэрэг газрууд орсон.

Хорго – Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолбор газрын хязгаарлалтын бүсэд 64916 га Тариат сумын 3 багийн 1000 орчим хүн амтай 250 өрх айл оршин амьдардаг бөгөөд 20000 орчим толгой малтай, 63 өвөлжөө, хаваржаа байна. Тэрхийн цагаан нуурын хойд, урд хөвөө Тариат сумын төвийн орчин зун, намрын улиралд нэлээд эрчимтэй байдлаар ашиглагдан өвс ургамал сийрэгжин талхлагдаж байна.

**Зам харилцаа** Архангай аймгийн төвөөс Хорго – Тэрхийн цагаан нуур зорчих улсын чанартай сайжруулсан замд сүүлийн жилүүдэд засвар хийгдээгүй учир зам, жижиг гүүрнүүд нэлээд эвдэрч зорчиход хүндрэл бэрхшээл учруулах болсон.

### **Аялал жуулчлалын баазууд**

1.Сөртийн шанаанд байрладаг “Энигма” ХХК-ний “Цагаан нуур” жуулчны бааз 2000 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн, том жижиг 20 гаруй гэртэй, ресторан, дэлгүүр, агуулахын барилга байшинтай, нэг ээлжиндээ 50-60 хүн хүлээн авах боломжтой. 2 га газар ашигладаг.

2.Тариат сумын төвөөс баруун тийш 7 км, Хоргын тогоо уулнаас хойш 1 км зайтай, Өвөр хар чулуутын ам Зүрхэд байрладаг “Цолмон трэйвэл” ХХК-ийн “Хорго-1” жуулчны бааз том, жижиг 20 гаруй гэртэй, ресторан агуулахын зориулалттай барилга байгууламжтай, нэг ээлжиндээ 70 хүн хүлээн авах хүчин чадалтай, 6 га газар эзэмшдэг.

3.“Цолмон трэйвэл” ХХК-ийн “Хорго-2” жуулчны бааз Тариат сумын төвөөс 14 км, Тэрхийн цагаан нуурын зүүн хойд хөвөөнд нуураас 500 м зайтай Сөртийн аманд байрладаг, 1.5 га газар эзэмшдэг.

4.Ой, ан, жуулчин нэгтгэлийн харъяа “Цагаан нуур” жуулчны бааз Тариат сумын төвөөс 13 км зайтай, “Хорго – 2” жуулчны баазаас 1 км зайд байрладаг, 1.5 га газар эзэмшдэг, 15 гэртэй, нэг ээлжид 44 хүн хүлээн авах бололцоотой.

Нуурын орчимд төлөвлөх объектууд:

1. Шанаатад жуулчны бааз байгуулах, үйлчилгээний цэг нээн ажиллуулах, загас барих цэг тогтоох, усанд орох наран шарлагын цэг байгуулах бололцоотой.
2. Өвгөн хадны дэргэд загас барих цэг тогтоох, шувуу амьтад ажиглах цамх
3. Нуурын зүүн талд үйлчилгээний цэг нээх.
4. Нуурын урд талд үйлчилгээний цэг ажиллуулах
5. Нууцын зүүн хойд салаанд загас барих цэг тогтоох
6. Нуурын зүүн хойд элсэн тохойд усанд орж, наранд шарах газар

7. Нуурын овооны орчим шувуу, амьтад ашиглах цамхаг байгуулах
8. Алаг уулан дээрээс шувуу амьтад ажиглах, бэлд нь жуулчны бааз байгуулах
9. Гурван толгой дээрээс шувуу амьтад ажиглах
10. Майхан толгойд жуулчны бааз байгуулах
11. Их мухар жуулчны бааз байгуулах
12. Ар Хар хужиртад жуулчны бааз байгуулах
13. Тооройн буланд жуулчны бааз байгуулан

Суман голын гүүрнээс, нуурын овоо хүртэл мориор юм уу явганаар аялах бололцоотой.

### **Ноён Хангайн байгалийн цогцолбор газар**

Байгаль орчны сайдын 1999 оны 159-р тогтоолоор Ноён Хангайн байгалийн цогцолбор газрын бүсүүдийн хилийг тогтоосон бөгөөд аялал жуулчлалын бүс 2000 га болж байна.

Ноён Хангайн рашааны орчим, Ноён Хангайн голын дагууд энэ гол Хясааны голтой нийлэх бэлчир хүртэлх газар нутгийг аялал жуулчлалын бүсэд оруулсан.

**Ноён Хангайн рашаан** Ноён Хангайн уулын баруун хойд хормойн баруун хойшоо хэвгий хажуугийн боржин хад асган дороос ундрэн гардаг 30-37 хэмийн халуунтай 10 гаруй булаг нь анагаах хосги й чадвартай халуун рашаан юм. Үе мөчний хэрх өвчин, мэдрэл, арьс өнгөний өвчин, хоол боловсруулах эрхтний өвчнийг голлон эмчилдэг. Жил бүрийн 7, 8-р саруудад эмчлүүлж сувилуулах, амарч зугаалах зорилгоор Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Завхан аймгуудаас 300 орчим хүн ирдэг.

Хангай сумын төвөөс баруун урагш рашаан хүртэл 17-18 км, Цэцэрлэг хотоос 240 км зайтай далайн түвшнээс дээш 2370 м өндөрт оршино. Герциний үеийн бүдүүн ширхэгт цайвар боржин голлохоос гадна хадан цагаан элбэг байдаг. Гол горхи сайр дагуу хуучин төрмөлийн эриний дунд үеийн их хувирсан элсэн чулуу, занар зэрэг тунамал чулуулаг үзэгдэнэ. Тэр хавийн их уулсын доод талаар ургаа боржин их байхад уулсын орой хяраар хувирмал занар гэх мэт эрт галавын тунамал чулуулаг голлосон байгаа нь өргөлцөх, суух зэргээр анх тогтохдоо боржин сэвхэт зэрэг гүний чулуулаг нь тунамал чулуулгийг түрж өргөгдсөн бололтой. Хангайн гол нурууны төв хэсэгт оршдог хамгийн өндөр цэг

нь Дашдовдог уул 3320.5 м юм. Ноён хангай, Хатан хангай, Цурхын нуруу, Ястын нуруу, Түмэн Сантын нуруу зэрэг 3000 м орчим өндөр уулс хүрээлнэ. Эдгээр уулсын араар бага зэрэг ой модтой, ойн сан бүхий газар 8652 га. Оройд мөнх цас бага сага тогтохоос гадна эртний мөстлийн хунх, морений мөлгөр чулуу, мөс усанд идэгдсэн гүн харанхуй ганга хавцал маш сүртэй сүндэрлэнэ. Рашааны ойролцоо Урд Тэрх, Ноён хангай зэрэг гол горхи, булаг шанд, ам хөндий, хоолой жалга элбэг.

Рашааны орчим шавар намаг ихтэй боловч түүний баруун хойно намхан тавиун талбайд 1956 онд сувилал байгуулсан. Амрагчид байрлах модон сууц 6, рашаанд орох 2 өрөө бүхий байшин 3 байдаг. 2 га газар ашигладаг.

Морин аяллаар Ноён, Хатан хангай хүртэл, түүнчлэн Хөх ониор давж, Ширэвгэр, Баяндулаан, Цэцэгт гэх мэт 70 гаруй жижиг нуурууд бүхий Бүдүүн Гичгэний эхний байгалийн үзэсгэлэнт газрыг сонирхон үзэх, шувуу амьтад ажиглах бололцоотой.

Урд Тэрхийн голын эх орчимд спорт агнуур хөгжүүлэх бололцоотой.

Рашааны дэргэд янз бүрийн үйлчилгээний цэг болон наран шарлагын газар, жуулчны бааз байгуулах бололцоотой. Түүнчлэн Бүдүүн гичгэний эхэнд шинээр аялал жуулчлалын бааз байгуулах бололцоотой.

Хязгаарлалтын бүсийн 41486 га нутагт Хангай сумын Ноён хангай, Баян-Улаан багуудын 2400 гаруй толгой малтай 28 өрхийн 100 гаруй хүн оршин суудаг.

Цэцэрлэг хотоос Батцэнгэл сум 48 км, Өлзийт сум 91 км, Өгий нуур 115 км, Хашаат сум 174 км, Хархорин 137 км.

### **Энэ чиглэлд үзэх зүйлс**

Батцэнгэл сумын өнөөгийн төв нь 1846 онд байгуулагдсан Сайн Ноён Хан аймгийн Түшээ гүн Лувсанхайдавын Лу гүн хүрээний суурь дээр оршино. Энэ хийдийн уран барилгын дурсгал өнөө болтол хадгалагдаж байдаг.

Батцэнгэл сумын төвөөс урагш Тамирын голын урдуур орших Тогтохын талд дөрвөлжин булш, тамга бүхий хөшөө, зэл чулуу бүхий цогцолбор бий. Эдгээрийг Жужаны үеийн дурсгал гэж үздэг.

Батцэнгэл сумын Цацын дэнж гэдэг газар орших 6 ш буган чулуун хөшөө, булш, хиргисүүрүүдийг мөн Худгийн толгой гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнуудыг хамтад нь 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

Батцэнгэл сумын нутаг Шивэртийн аманд хүрэл, төмрийн үед холбогдох дөрвөлжин булш байдаг.

Шивэртийн халуун рашаан Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Тоомын нурууны ар, Шивэртийн голын 2 захад далайн түвшнээс 1720 м өндөрт

Шивэртийн халуун рашаан байрлана. Цэцэрлэг хотоос зүүн хойш 21 км, сумын төвөөс 3 км зайд оршино.

Рашааныг өндөр Шивээт, Ацат гозгор, Тоомын нуруу, Хөх чулуутын нуруу, Галавын улаан, Булагийн овоо зэрэг ой мод бүрхсэн дунд зэргийн өндөр уулс хүрээлнэ. Орчин тойрондоо үржил шимт хар хүрэн хөрстэй. Хус, хуш, бор, цагаан бургас, далан хальс, яргай торлог, боролзгоно зэрэг мод бут, үхэр нүд, гүзээлзгэнэ зэрэг жимс, жимсгэнээр баян.

Герциний үеийн боржин, болронцор, чулуу сэвхэт чулуу суурь дээр мөн хуучин төрмөлийн эриний үеийн их хувирсан занар, элсэн чулуу гэх зэрэг тунамал чуулгаас гадна одоо цагийн хурдас хайр сайр хучсан голын шавар намагтай зүлгэн дотроос энэ рашааны хэд хэдэн булаг оргилон гарна.

Голлох 2 булгийн ундарга цагт 1880 л, температур нь 60 ба 37 хэм байна. 0.33 г/л эрдэсжилттэй, гидрокарбонат-карбонат-натрийн найрлагатай, азотын халуун рашаан рН 9.1 Eh 160 МВ рашааны нөөц хоногт 400-450 м3. Шивэртийн амралт зуны улиралд нэг ээлжид 150, өвлийн улиралд 50 хүн хүлээн авах хүчин чадалтай. Энд Нохой унадаг нуурын шаврыг эмчилгээнд хэрэглэдэг.

Хайрхан сумаас Эрдэнэмандал сум 50 км, Жаргалант сум 62 км, Цэцэрлэг сум 47 км, буцаад Хайрхан сум 80 км. Аялах замын урт 250 км. Аяллын хугацаа 1-2 хоног. Энэ чиглэлд Булган аймгийн төвөөс Сайхан сумаар дамжин хүрч болно.

### **Энэ чиглэлд үзэх зүйлс**

Хангайн нурууны арын салбар уулс Бугатын нурууны зүүн хажуугаас эх авч хойшоо Хануй голд цутгах Хүнүй голын хөвөөнд адууны зураг бүхий буган чулуун хөшөө байдаг.

Хайрхан сумын төвөөс баруун урагш холгүй Гол мод гэдэг газар Хүннүгийн язгууртны булш олон хүн чулуун хөшөө байдаг. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

Хайрхан сумын нутагт Уйгарын Трояны хааны 1Х зууны үеийн гэрэлт хөшөө байдаг.

Эрдэнэмандал сумын төвөөс баруун тийш Хануй голын хойд биед оршдог дөрвөлжин шавар хэрэмтэй дотроо олон байшингийн ор мөртэй балгас байдаг. 16-р зууны Анагаахай дархан хун тайжийн ач хүү Мингай Хархулд зориулсан ордон гэдэг энэ балгасыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

Эрдэнэмандал сумын төвийн баруунхан талд Баруунцүүр гэдэг газар орших буган чулуун хөшөөг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

Цэцэрлэг сумын нутагт спорт агнуур хөгжүүлэх бололцоотой.

**-Газрын мэргэжлийн байгууллага – Цогтхангай ХХК –**

Архангай аймгийн нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын баазууд, амралт сувиллын газрын эдэлбэр газар 74.85 га газар байна. Хойшид аялал жуулчлал, амралт сувиллын эдэлбэрийн зориулалтаар 38.26 га газар ашиглахаар төлөвлөв.

Аялал жуулчлал, хүн амын байгалийн экологийн нөхөн сэргээлтийн бүсийн хэлбэрээр ашиглагдахаар нутаг 329.8 мянган га байна. Үүнд:

1. Цэцэрлэг орчмын бичил бүс 260000 га
2. Хорго-Тэрхийн цагаан нуурын Байгалийн цогцолбор газар 67850 га
3. Ноён хангайн байгалийн цогцолбор газар 2000 га.

Хот, тосгон бусад суурин газрын ангилалд одоо дөнгөж судалгааны явцдаа байгаа дараах уул уурхайн газрууд нэмж орж ирэх магадлалтай байна. Үүнд:

1. Жаргалант сумын “Их Элэгдэй”-н гол дахь алтны уурхай
2. Өлзийт сумын Тосонгийн хоолой, Их тамирын Баянцагаан, Баяндүүрэх, Өгийнуурын Их, бага тогооны орчмын нүүрсний уурхай
3. Хотонт сумын Цагаан сүмийн голын цагаан тугалганы илэрц
4. Хангай сумын Хэц дөрөлжийн гянтболд, төмрийн уурхай
5. Их тамирын Мөнгөт, Бэрх, Овоот уулын төмрийн хүдрийн уурхай
6. Тариат сумын Шаврын царамын гоёл чимэглэлийн болон өнгөт чулууны орд
7. Батцэнгэл сумын Шохойн чулууны орд

зэрэг нь одоо зөвхөн хайгуулын шатандаа байгаа бөгөөд баялгийн нөөц, эзлэх талбай нь тогтоогдоогүй байгаа юм.

**3.3.Зам, шугам сүлжээний газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент**

**3.3.1.Автозамын ашиглалтын менежмент**

Хэтийн төлвөөр Архангай аймгийн Өгийнуур, Батцэнгэл, Тариат, Цахир сумдын нутгаар “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэг, Хашаат сумаар босоо тэнхлэг тус тус дайран өнгөрөх юм.

**Мянганы замын хэвтээ тэнхлэгийн чиглэл,  
замын зурвас газрын тооцоо**

№	Замын чиглэл	Замын урт /км/	Замын зурвас газрын талбай /га/	Тайлбар
1	Дашинчилэн - Өгийн доод гүүр /зөвхөн Архангайн хэсэг/	40	400	Архангай аймгийн зүүн хилээс гүүр хүртэл тооцов
2	Өгийн доод гүүр – Батцэнгэл	61	610	
3	Батцэнгэл – Хануйн гүүр	160	1600	
4	Хануйн гүүр – Тариат	36	360	
5	Тариат – Цахир	63	630	
6	Цахир – Загастайн даваа	25	250	Зөвхөн Архангайн хэсгийг тооцов
	Дүн	385	3850	

Тооцооноос үзэхэд “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэгийн хар замын нийт урт 385 км бөгөөд түүний зурвас газар 3850 га газар хамрагдахаар төлөвлөгдөж байна. Төлөвлөлтийг хийхдээ зөвхөн Архангай аймгийн зүүн ба баруун хилийг хүртэл тооцлоо. “Мянганы зам”-ын босоо тэнхлэг нь Бага Илэнхи – Тэшиг – Булган – Хархорин – Арвайхээр – Шивээхүрэн гэсэн маршрутаар төлөвлөгдсөн бөгөөд Архангай аймгийн хувьд Хашаат сумыг дайрсан 40 км зам нь түүнд хамаарагдах юм. Иймээс түүний зурвас газар нь 400 га-аар төлөвлөлтөд тусгалаа.

Дээрхээс гадна Архангай аймгийн дотооддоо Эрдэнэбулган – Цэнхэрийн 20.1 км хар зам /зурвас газар нь 201 га/, Цэнхэр – Хашаат сумын хоорондох 45 км хайрган хучилттай сайжруулсан зам /зурвас газар нь 360 га/-ыг 2006-2013 онд тавихаар төлөвлөгдөж байна. Энэ зам нь цаашид ч улсын чанартай зам байх бөгөөд Хархориноос Цэцэрлэг хотоор дайран өнгөрч Хануйн гүүрийг дайрсан хэвтээ тэнхлэгтэй нэгдэх юм.

### **3.3.2. Эрчим хүч, холбооны шугамын ашиглалтын менежмент**

Архангай аймгийн зам, шугам сүлжээний ангиллын газарт нийт 2305.1 га газар хамрагддаг бөгөөд үүнээс эрчим хүчний шугам, станцын доорх газарт 1370 га, холбооны шугамд 892.1 га, ус, дулаан дамжуулах хоолойд 40 га ногдоно.

“Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “ХХ1 зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр” зэрэг хэтийн хөгжлийн стратегийн бодлогын баримт бичгүүд дээр тулгуурлан “Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөрийг ТЭХЯ-наас боловсруулан гаргажээ.

Энэ хөтөлбөрт тусгагдсанаар ойрын хугацаанд буюу 2007 онд багтаан УБ-Улиастайн хооронд 400 квт-ын хүчин чадалтай томоохон транзит шугам татаж,

баруун бүсийн ЭХ-ний нэгдсэн системийг төвийн ЭХ-ний нэгдсэн системтэй холбосноор Монгол Улсын хэмжээний ЭХНС бий болох ажээ. Хэрэв энэ хөтөлбөр хугацаандаа хэрэгжвэл Өвөрхангайн Хархорин, Архангайн Төвшрүүлэх – Цэнхэр – Эрдэнэбулган – Их тамир - Өндөр-Улаан – Тариат – Цахир – Их уул /Завхан/ гэсэн маршрутаар дээр дурдсан эрчим хүчний шугам тавигдах учир төлөвлөлтөд зөвхөн Архангайн хэсгийг тусгаж өглөө.

**Төлөвлөгдөж буй ЦШС-ний газар**

д/д	Чиглэл	Шугамын урт /км/	Дэд станцын чадал /МВА/	Нийт өртөг /сая төг/	Ачаалал /КВТ/	Өртгөө нөхөх хугацаа /жил/
1	Хархорин-Төвшруулах-Цэнхэр-Эрдэнэбулган-Их тамир-Өндөр-Улаан-Тариат-Цахир-Их уул /Завхан/	382	2 x 125	25500	80000	12 жил

Дээр дурдсан ЦШС нь аймгийн нутаг дэвсгэрт нийт 3269.9 га газар хамрах ба үүний дотор ТХГН-т 26 км урттай шугам 220 га-д, ойн сан бүхий газарт 14 км урттай шугам 119.8 га-д, бусад нь бэлчээрийн газраар дайран өнгөрөх юм.

Одоогийн байдлаар аймгийн бүх сумдад өндөр хүчдэлийн шугам тавигдсан байгаа. Гэвч сум орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл сайн хөгжөөгүй учраас ЭХ-ний системийн суурь хүчин чадлын дөнгөж 40 орчим хувийг ашигладаг.

Судалгаанаас үзэхэд тус аймагт жилийн нартай байх хугацаа 2800-2900 цаг, үүнээс зун дунджаар 9.5 цаг, өвөл 5.3 цаг, салхины дундаж хурд уулархаг нутгаар 2 м/сек, тал хээрт 4 м/сек тус тус байдаг нь нар, салхины энергийг ашиглаж малчдын ахуйн цахилгаан хангамжийг шийдвэрлэх боломжтойг харуулж байна. Иймээс эдийн засгийн дотоод 4 бүсийн 15.0 мянга гаруй өрхийг /малчин өрх/ байгалийн сэргээгдэх эрчим хүчээр хангах ажлыг үргэлжлүүлж 2013 он гэхэд бүх малчин өрхийг ахуйн цахилгааны эх үүсвэртэй болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Үүнээс гадна аймгийн ерөнхий төлөвлөгөөнд Хануй, Чулуут, Суман гол дээр байгуулах УЦС-ыг тусгаж өглөө. Бага оврын УЦС нь 1 квт цахилгаан эрчим хї ч үйлдвэрлэх өртөг нь хямд бөгөөд 25-50 төг. Юм.

**Аймгийн нутаг дэвсгэр дэх судалгаа хийгдсэн УЦС-ууд:**

д/д	Сумын нэр	Голын нэр	Суурилагдсан хүчин чадал /	Солбицлолын цэгүүд	Эзэмшлийн талбай /га/
1	Чулуут	Чулуут	65	x = 100.2332 y = 47.5997	447.0
2	Тариат	Суман	60	x = 99.8829 y = 48.1667	411.0
3	Жаргалант	Чулуут	30	x = 100.2832 y = 47.9662	254.0
	Дүн				1112.0



Дээрх төлөвлөгдсөн УЦС-ын талбайг хамгаалалтын бүсээр нь авсан учир бэлчээрээс хасагдахаар тооцлоо.

Аймгийн хэрэгцээт нүүрсийг 402 км-т орших Өвөрхангай аймгийн Баянтээгээс тээвэрлэдэг нь 1 тн нүүрсний өөрийн өртгийг өндөрсгөж иргэд, ААН, байгууллагад бэрхшээл учруулдаг. Иймээс аймгийнхаа нутаг дэвсгэрт орших Баянцагаан, Баяндүүрэн, Агуйтын гол, Бүрдийн хөндийд байгаа нүүрсний ордуудад нарийвчилсан судалгаа хийж, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Түүнчлэн газрын гүнд байгаа 150-270<sup>o</sup>C-ын дулааны нөөцийг ашиглан Цэцэрлэг хотыг дулаанаар хангах Геостанцыг байгуулахаар төлөвлөлтөд тусгалаа.

Холбооны шугам сүлжээний хувьд орчин үеийн тоон радиорелейний шугам, тоон АТС, шилэн кабель шугам Булган, Орхон аймгаас холбогдох боломжтой. Ялангуяа “Мянганы зам”-ын босоо тэнхлэг Хашаат сумаар дайран өнгөрөх бөгөөд үүнийг дагасан шилэн кабель харилцаа холбооны салбарт эерэгээр нөлөөлөх магадлал бий. Дулааны хангамжийг сайжруулах зорилгоор цаашдаа Шивэрт, Цэнхэрийн азотын халуун рашааныг дулааны системд ашиглах боломжтой юм.

### **3.4.Усны сан бүхий газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент**

#### **3.4.1.Газрын гадаргын усны ашиглалтын менежмент**

Архангай аймаг нь гадаргын ус элбэгтэй аймагт тооцогддог. Аймгийн нутаг дэвсгэрт орших голууд нь Хойт мөсөн далайн ай савд багтах бөгөөд тус аймаг нь нийт 9404 км урттай 856 гол, горхитойгоос гадна 188 нуур, тойром, 576 булаг шандтай. Хоргын бүсэд багтах нуурууд нь /тухайлбал: Тэрхийн цагаан нуур/ галт уулын, тектоникийн дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн гэж үзэж болно. Тус аймагт Хангайн нуруунаас эх авсан Хойт, урд Тэрх, Гичгэнэ, Суман, Чулуут, Хануй, Хойт, урд Тамир, Цэнхэр, Орхон голуудаас гадна Хүнүй, Хөгшин Орхон голууд бий.

Эдгээр нь баруун өмнөөс зүүн хойш чиглэсэн урсгалтай. Хөгшин Орхон гол нь усны эх үүсвэрийн дутагдлаас болж их хэмжээгээр багассан тул түүнийг тэтгэх үүднээс Орхон голоос зүүн тийш сэтэлж Хөгшин Орхонтой гольдролыг нь холбох арга хэмжээг төлөвлөлтөд тусгав. Энэ холболт нь 3.7 км урттай 4 м өргөнтэй голуудыг холбосон зурвас байх юм. Талбай нь 1.5 га болно.

Дээрх голуудаас хэмжээгээрээ арай том зарим голын үзүүлэлтийг авч үзье.

### Голын үзүүлэлтүүд ба хамгаалалтын бүсийн талбай

д/д	Голын нэр	Ус хураах талбай /км <sup>2</sup> /	Урт /км/	Хамгаалах бүсийн өргөн /м/	Голын дундаж өргөн /м/	Хамгааллын бүсийн нийт талбай /га/
1	Суман	6458	50	100	45	1225
2	Чулуут	19900	415	300	50	26975
3	Хануй	14620	421	300	42	27028
4	Урд Тамир	2642	165	300	55	10808
5	Хойт Тамир	2993	180	300	55	11790
	Дүн	46613	1231	-	-	77826

Хүснэгтэд заагдсан 5 голын ус хураах талбайн нийлбэр 46613 км<sup>2</sup> буюу 4661300 га, хамгаалалтын бүсийн нийт талбай 77826 га болж байна. Улсын ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дээрх голуудын ус хураах талбайг аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээтэй харьцуулахад түүний 84.3 хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд гадаргын усны хангамж нэн сайн гэдэг нь нотлогдож байгаа аж. Өөрөөр хэлбэл нийт ХАА-н газраас 14.5 хувиар илүү хэмжээний газар ус хураах талбайд ногдож байна. Эдгээр нь бэлчээрийн газарт ашиглагдсаар байх болно.

Гадаргын усны талбайн хэмжээг ус хамгаалах бүсийг оролцуулан тооцвол гол хамгаалах бүсийн хамт 108151.6 га, булаг, рашаан хамгаалах бүсийн хамт 6829.9 га, нуур хамгаалах бүсийн хамт 67402.9 га бүгд 182384.4 га газар гадаргын усны талбайд тооцогдохоор төлөвлөгдөж байна.

Энэ хэмжээгээр цаашид бэлчээрийн талбай болон бусад ангиллын газраас хасагдаж, усны сан бүхий газрын ангилалд орохоор байна. Гэвч эдгээр нь нэгэнт улсын ГЗБЯ-ын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан учир хөндөлгүй орхисон ба цаашид ч бэлчээрт ашиглагдах учраас бэлчээр болон усны сангийн газарт нөлөөлөхгүй билээ.

Гадаргын усны нэг чухал хэсэг бол азотын халуун болон нүүрсхүчлийн хүйтэн рашаанууд юм. Архангай аймгийн хувьд халуун, хүйтэн рашаан элбэг бөгөөд гол төлөв улирлын чанартайгаар эмчилгээ-сувилгаанд ашиглагддаг. Иймээс рашаануудыг цаашид эмчилгээ-сувилгаанд эрчимтэй ашиглах төлвийг харгалзан үзэж, тэдгээрийг тохижуулах, ариун цэврийн бүс тогтоох, байнгын үйлчилгээтэй амралт-сувиллын цэг байгуулах арга хэмжээг аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнд тусгав. Зарим өргөн хэрэгцээтэй рашаануудын анги, төрөл, солбилцлыг дараах хүснэгтээс харж болно.

**Рашааны анги, төрөл /бүсээр/**

д/д	Бүсийн нэр	Сумын нэр	Рашааны нэр	Солбилцлол	T°C	Анги, төрөл
I	Хорго	Хангай	Ноёнхангай	X47°45'00" Y99°25'00"	37	CS <sup>Na</sup>
		Чулуут	Чулуут	X47°05'00" Y100°15'00"	44	X <sup>Na</sup>
		Тариат	Ангархай	X48°03'00" Y99°54'00"	1	
		Өндөр-Улаан	Билгэх	X47°59'00" Y100°54'00"		
		Тариат	Хадат	X48°23'30" Y99°27'00"	2	C <sup>Ca</sup>
II	Хануй	Цэцэрлэг	Мухар хужир	X48°45'00" Y101°30'00"	2	C <sup>Ca</sup>
		Цэцэрлэг	Хануйн 2 өгөг	X48°44'00" Y101°34'00"	3	C <sup>MgCa</sup>
		Эрдэнэмандал	Асгат түрүү	X48°26'00" Y101°33'00"	7	C <sup>Ca</sup>
		Эрдэнэмандал	Хан-Өндөр	X48°33'00" Y101°03'00"	2	C <sup>Na</sup>
III	Өгийнуур	Хотонт	Чулуун даваа	X47°17'00" Y102°25'00"	3	C <sup>Ca</sup>
		Хотонт	Байшингийн булаг	X47°13'30" Y102°34'00"	3	C <sup>Ca</sup>
		Өгийнуур	Сарлаг	X47°37'00" Y102°34'00"	8	C <sup>NaCa</sup>
		Өгийнуур	Тамирын улаан хошуу	X47°44'00" Y102°29'00"	4	C <sup>X</sup>
		Өгийнуур	Цац толгой	X47°48'00" Y102°37'00"	6	C <sup>Ca</sup>
		Өлзийт	Цайдам нуур	X47°52'30" Y102°37'30"	20	C <sup>Na</sup>
IV	Булган уул	Цэнхэр	Цэнхэрийн халуун рашаан	X47°20'02" Y102°39'05"	90	C <sup>Na</sup>
		Цэнхэр	Бор талын халуун рашаан	X47°12'00" Y101°36'00"	42	C <sup>Na</sup>
		Цэнхэр	Гялааны халуун рашаан	X47°12'15" Y101°33'00"	37	C <sup>Na</sup>
		Цэнхэр	Цагаан сүмийн халуун рашаан	X47°04'00" Y102°06'00"	66	X <sup>Na</sup>
		Цэнхэр	Хөх сүмийн халуун рашаан	X47°15'00" Y101°56'05"	8	C <sup>Ca</sup>
		Цэнхэр	Шарт	X47°03'00" Y101°46'00"	4	C <sup>Ca</sup>
		Батцэнхэр	Алтан-Овоо	X47°21'01" Y101°45'00"	3	C <sup>Ca</sup>
		Цэнхэр	Өлзий толгой	X47°37'00" Y102°00'00"	7	C <sup>Na</sup>
		Булган	Их тээл	X47°16'00" Y101°19'30"	6	C <sup>X</sup>
		Эрдэнэбулган	Жамган	X47°29'00" Y101°26'00"	1	C <sup>X</sup>
		Батцэнгэл	Шивэртийн халуун рашаан	X47°38'30" Y101°31'15"	60	C <sup>SNa</sup>
		Батцэнгэл	Цац	X47°59'00" Y101°57'00"	6	C <sup>Ca</sup>

- Тайлбар:
- C<sup>Ca</sup> - гидрокарбонат кальцийн ус
  - CS<sup>Na</sup> – сульфат, гидрокарбонат натрийн ус
  - C<sup>MgCa</sup> – гидрокарбонат магни-кальцийн ус
  - C<sup>X</sup> – гидрокарбонатын холимог ус

Дээрх хүснэгтээс харахад эдийн засгийн дотоод бүсчилэл бүрт бүсийн рашаан сувилал-эмчилгээний тохилог орчинг бий болгох бүрэн боломжтой байна.

Иймээс тодорхой бүсийн судлагдсан рашаануудыг эхний ээлжид тохижуулж, бусдыг нь зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан сувилуулагчдын таатай орчныг бүрдүүлэх нь зүйтэй.

**Тохижуулж, өргөжүүлэх шаардлагатай рашаанууд**

Бүсийн нэр	Рашааны нэр	Рашааныг тохижуулах, өргөжүүлэх	
		2006-2013	2013-2021
Хорго	1. Ноёнхангай 2. Хадат	Ноёнхангай	Хадат болон бусад
Хануй	1. Мухар хужир 2. Хан Өндөр 3. Хануйн 2 өтөг	Мухар хужир Хан Өндөр	Хануйн 2 өтөг бусад
Өгийнуур	1. Байшингийн булаг 2. Сарлаг 3. Цайдам нуур	Байшингийн булаг Сарлаг	Цайдам нуур бусад
Булган уул	1. Цэнхэр 2. Хөх сүм 3. Шивэрт	Цэнхэр Шивэрт	Хөх сүм бусад

**3.4.2. Газрын гүний ус ашиглалтын менежмент**

Архангай аймагт 1990-ээд оны үед инженерийн хийцтэй 1397 гаруй уст цэг ашиглагдаж, жилийн 4 улиралд нийт бэлчээрийн талбайн 80 гаруй хувь нь усжуулагдсан байжээ.

1996-1997 оны улсын үзлэг, тооллого тайлангийн материалаас үзэхэд нийт уст цэгийн 70 гаруй хувь нь эвдэрч тоногдсон, байгаль цаг уурын хүчин зүйлээс болж усгүй болсон, усны түвшин буурсан, лайд дарагдсан, эзэнгүйдсэн зэргээс шалтгаалан ашиглагдахгүй байгаа тухай тайланд өгүүлжээ.

2003 оны уст цэгийн үзлэг, тооллогын дүнд тус аймагт 965 уст цэг байгаагаас инженерийн хийцтэй 861, энгийн уурхайн 104 уст цэг байгаа гэж тодорхойлсон байна. Эдгээрээс 770 уст цэг буюу инженерийн хийцтэй 689, энгийн уурхайн 81 худаг бэлчээрт байдаг гэжээ. Үүнээс үзэхэд инженерийн хийцтэй уст цэгийн тоо 1990-ээд онтой харьцуулахад 432 уст цэгээр буурсан байна. Үүнтэй зэрэгцэн бэлчээр усжуулалт 36 орчим хувиар буурчээ гэж үзвэл одоогийн байдлаар бэлчээр усжуулалт 45 хувьтай байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм.

Архангай аймгийн гадаргын усны ашиглаж болох нөөц  $0.20\text{км}^3$ , газрын доорх усны нөөц  $0.63\text{ км}^3$  гэж судалгаагаар тогтоожээ. Энэ нь усны нөөцийн хэмжээгээр “бага”-д тооцогдоно. Түүнчлэн тус аймгийн хувьд газрын доорх усны нөөцийн орд нь Урд Тамирын гол – Цэцэрлэг хотын орчимд илэрсэн бөгөөд 0.1 гр/л эрдэсжилттэй, А + В усны нөөцийн зэрэглэлтэй,  $10082.8\text{ м}^3/\text{хоног}$  хэмжээтэй ажээ.

Ер нь газрын гүний усны ашиглалтын менежмент нь хамгийн эхлээд суурин хүн амын ахуйн усан хангамжийн хэрэгцээг хангах, дараа нь ХАА-н салбарын хэрэгцээг хангахад чиглэгдэх ёстой.

Хүн амын ахуйн хэрэгцээний усыг газрын гүний усаар хангасан гэж үзвэл бэлчээрийн МАА, газар тариалангийн үйлдвэрлэлийн усан хангамж хангалтгүй

байгаа юм. Иймээс бэлчээр усжуулалтыг газрын гүний ус ашиглан эрчимжүүлэх шаардлагатай.

Бэлчээр усжуулалтыг 2000 оны үеийнхтэй ижил түвшинд хүргэнэ гэвэл 400 гаруй гүний уст цэгийг сэргээн тохижуулах, хямд төсөр аргаар энгийн уурхайн худаг гаргах, шинээр цооног өрөмдөх, гаргасан худгийг эзэнтэй болгох асуудал яригдана. Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд 2006-2013 онд 200 гүний худаг, 2013-2021 онд 230 орчим гүний худгийг сэргээн засварлах ба шинээр гаргах тооцоо гарна. Хэрэв ингэвэл 2006-2013 онд бэлчээр усжуулалт 65 хувь, 2013-2021 онд 80 гаруй хувь болж, 2000 оны түвшинд эргэж очих юм. Энэ нөхцөлд газрын гүний усны түвшингээс шалтгаалан өртөг зардал нь янз бүр байх нь мэдээж. Гэхдээ сүүлийн үед энэ чиглэлийн мэргэжлийн байгууллагууд зөвхөн цооног өрөмдөхөд 80.0-100.0 мянган төгрөг/тууш метр үнээр өрөмдөж байгааг тооцох нь чухал. Бэлчээр усжуулалтын ажлыг эрчимтэй сайн хийвэл бэлчээрийн талхагдал харьцангуй багасах эерэг нөлөөтэй.

### **3.5.Ойн сан бүхий газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент**

Тус аймгийн ойн сан бүхий газар 1082621 га бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 19.6 хувийг эзэлдэг. 1996-1997 онд ой, ан судлалын хүрээлэнгийн ойн экспедиц аймгийн ойн сан бүхий газарт ой зохион байгуулалтын иж бүрэн судалгаа явуулж, бүх ойн 80 гаруй хувь нь нас гүйцсэн буюу өтөлсөн, 20 орчим хувь нь залуу, зулзган ой байгааг тогтоожээ.

Аймгийн хэмжээгээр ойд явуулж болох үндсэн ашиглалтын огтлолын тооцоог хийж үзэхэд жилдээ 300 гаруй га талбайгаас 8.2 мянган м<sup>3</sup> модыг түүвэрлэн огтлох аргаар бэлтгэж болох тооцоо гардаг. Энэ нь ойн нөөцийн ихэнх нь ТХГН-т оршдогтой холбоотой. 1996 оны үед ой ашиглаж үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгж 5 байсан бол үүнээс хойш 150 гаруй болж нэмэгдсэн байна. Гэвч эдгээрийн ихэнх нь татан буугдсанаар ойгоос хэрэглээний мод авч ашиглах нь багассан гэж үзэж байна.

Аймгийн хэмжээгээр жилд дунджаар 50.0 мянга гаруй м<sup>3</sup> мод бэлтгэж 400-800 га-д нөхөн сэргээлт хийдэг. Цаашид ч ой нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх шаардлагатай. Одоогийн байдлаар ой модыг нь огтолсон 2764 га газар бий. Үүнийг жил бүр нөхөн сэргээх ёстой бөгөөд 2006-2013 онд 2000 га, 2013-2021 онд 800 га ойг нөхөн сэргээхээр төлөвлөгдөж байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт орших ойн нөөцийн 90 гаруй хувь нь шилмүүст ой байдаг. Цаашид ойг гал түймэр, хортон шавьжаас хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

Ойн нөөцийг хамгаалахын тулд:

1. Мод бэлтгэлийн үйлдвэрлэл эрчимтэй явагддаг Хойт, урд Тамир, Цэнхэр, Хануйн голын зарим хэсэг болон ой бүхий сумдад мод үржүүлгийн бага оврын хүлэмж, ойн түр титоиник байгуулах
2. Түймэрт өртсөн болон огтолсон ойг тэргүүн ээлжид нөхөн сэргээх
3. Ойжуулалтын ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх

### **3.6.Улсын тусгай хэрэгцээний газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт, түүний менежмент**

#### **3.6.1.Улсын тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт, түүний ашиглалтын менежмент**

Архангай аймгийн нутаг дэвсгэрт улсын тусгай хэрэгцээний газар 546882.8 га талбай буюу 9.9 хувийг эзэлдэг.

Одоогийн байдлаар улсын тусгай хэрэгцээний газарт УТХГН-ний 546.9 мянган га /үүний дотор Хангайн нурууны болон Ноёнхангайн БЦГ – 545.0 мянган га, дурсгалт газар – 1.9 мянган га/ хамрагддагаас гадна байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 26 га газар ордог байна.

УТХГН-ийн захиргаа нь Өвөрхангайн Хархорин суманд байрладаг. Аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнд Орхоны хөндийн БЦГ-ыг шинээр байгуулах Засгийн газар, БОЯ-ны үзэл баримтлалыг тусгав.

Энэхүү шинээр байгуулагдах БЦГ-т Хотонт сумын Дойтын овооноос зүүн урагш 23.0 мянга орчим га газар, хашаат сумын Манхан элс, Хүрэнчулуутын уул, Эмээл толгойгоос урагш 31.0 мянган га нийт 54.0 мянга орчим га газар харъяалагдах юм.

Үүнээс гадна байгалийн муж, бүс бүслүүрийн үндсэн хэв шинж иж бүрдлийг төлөөлж чадах унаган төрхөө харьцангуй хамгаалсан, ховор, ховордсон ургамал бүхий Тариат сумын Хөнжил, Алтаад, Цэцэрлэг сумын Дулаанхаан, Өндөр-Улаан сумын Бугатын нуруу зэрэг газруудыг 2013-2021 онд тодорхой үе шаттайгаар УТХГН-т хамруулах асуудлыг шийдвэрлэх юм.

Ингэснээр аймгийн нийт нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдах боломжтой.

### **3.7.Архангай аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын зөвлөмж**

Архангай аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөг 2005 оны 7 дугаар сараас 2006 оны 5 сар хүртэлх хугацаанд боловсруулж дуусгав. Ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа “Улсын ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөө”, “Архангай аймгийн ХХ1 зууны хөгжлийн хөтөлбөр”, “Архангай аймгийн эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх чиглэл”, “Хангайн бүсүүдийн хөгжлийн зорилтууд”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг эх сурвалжуудыг үндэслэн, хээрийн судалгааны ажлын материалуудад тулгуурлан боловсрууллаа.

Уг төлөвлөгөө нь аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлогыг газрын нөөцийн ашиглалттай уялдуулан хэрэгжүүлэхэд чухал түлхэц болно гэж үзэж байна.

Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах явцдаа төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх мөнгө санхүүгийн дотоод боломж, хэрэгжих нөхцөл бүрдсэн эсэхийг илүү анхаарав. Аливаа төлөвлөгдсөн арга хэмжээ нь аймгийн санхүүгийн төсөв, эдийн засгийн хүчин чадалтай салшгүй холбоотой тул хий хоосон мөрөөдлийн чанартай, практик үйл ажиллагаанаас хөндий зүйлүүдээс аль болох зайлсхийлээ.

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд дээрээс нь хатуу лимит тогтоох эсвэл зааж зааварлах асуудал үеэ өнгөрөөсөн гэж хэлж болно. Иймээс сум, орон нутаг өөрийн байгаль-цаг уурын нөхцөл байдал, газрын нөөцийн орон зайн боломжийг тооцон, тулгамдсан асуудлыг шийдвэрлэснээр аймаг, орон нутгийн нийгэм-эдийн засгийн бодлогод нөлөөлөхүйц арга хэмжээнүүдийг авч явуулах нь зүйтэй гэж үзэв.

Иймээс дараах асуудлуудыг ойрын болон хэтийн хугацаанд шийдвэрлэх шаардлагатайг зөвлөмж болгож байна.

1. 20 гаруй жилийн хугацаанд ашиглагдаагүй атаршсан газар, хадлангийн талбайг нэн даруй ялгаж салган “цаашид ашиглагдахгүй” гэж үзсэн хэсгийг бэлчээрт шилжүүлэх арга хэмжээ авах нь чухал. Үүнтэй уялдуулан хүн амыг үр тариа, хүнсний ногоогоор хангах, малын тэжээлийн баазыг нэмэгдүүлэх өөр аргыг сонгох шаардлагатай тул дээрх чиглэлийн фермерийн аж ахуйнуудыг бүс бүрт олноор бий болгож, тэдэнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

2.Газар бол үл хөдлөх хөрөнгө. Ялангуяа төрийн мэдэлд байгаа тодорхой ангиллын газар бүр өөрийн гэсэн 1 га-ын суурь үнэлгээтэй. Тухайлбал Архангай аймгийн хувьд 3749.1 мянган га бэлчээрийн суурь үнэлгээ 2 тэрбум 55 сая 256.6

мянган төгрөг болдог. Тэгвэл төрөөс яагаад энэ их өртөгтэй хөрөнгөдөө хайр гамгүй, хэнэггүй, зөнд нь хандаад байна вэ? гэдэг асуудал гарч ирнэ. Энэ мэтчилэн ХАА-н газрууд бүгд л өөрийн гэсэн суурь үнэлгээтэй байдаг. Бүгдийг нь тооцвол нэлээд их хэмжээний тоо гарах болно.

Ийм учраас газрын үнэ цэнийг сайн бодолцож ашиглалтыг сайжруулах шаардлагатай юм.

3.Газар тариаланг усалгаажуулж, байгаль-цаг уурын эрсдэлийг багасгах, одоогийн баримталж байгаа технологийг өөрчилж, эрчимжүүлсэн технологид шилжих зайлшгүй шаардлагатай.

Ялангуяа тус аймгийн Булган уул, Өгийнуурын бүсэд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээний нэг чухал хэсэг нь энэ юм.

4.Бэлчээрийн даацын зохистой түвшинг барьж, бэлчээрийн газрыг хамгаалах, усалгаажуулах, сэлгэх, хуваарьтай ашиглах бүхий л нөхцөлүүдийг баримтлах хэрэгтэй байна. Зун-намрын улиралд өндөр уулын бүсийн бэлчээрийг түлхүү ашиглах, үүний тулд усалгаажуулах арга хэмжээ авах нь чухал. Хашсан бэлчээрийг олноор бий болгох, бэлчээрт өнгөн сайжруулалт хийх, ургамлын төрлийг нь зохистой хэмжээнд барих шаардлагатай.



**Аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад ашигласан ном,  
хэвлэлийн жагсаалт**

1. Монгол улсын статистикийн эмхтгэл 2004 он.УБ хот
2. Монгол улсын ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөө 2003 он
3. “Монгол орны гадаргын ус” БОЯ. Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Ус цаг уурын хүрээлэн 1999 он. УБ хот.
4. “Схема землеустройства административного района” (практическое пособие)<Росземкадастр>,<Рос НИИ земпроект> 2002 г. г.Москва
5. “Газрын менежментийн онолын үндэс”. Г.Пүрэвцэрэн, Ж.Наранцацралт 2000 он
6. “Бүс нутгийн хөгжил” Онол практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2003 он. Арвайхээр хот
7. Хангайн бүсийн хөгжлийн зорилтууд. 2005 он. Арвайхээр хот “Үндэсний хөгжлийн хүрээлэн”, “Хангайн бүсийн зөвлөл”
8. Малчдын бүлэгт суурилсан бэлчээр, эрсдлийн менежмент. Өрхийн амьжиргааны чадавхи дэмжих үндэсний хөтөлбөр. 2005 он
9. Малчдын хоршоо, бэлчээрийн менежмент Н.Надмид. 2005 он
10. Монгол улсын ТХГНутаг. 2000 он БОЯ
11. Монгол улсын эрдсийн баялаг. У.Мавлет 1998 он
12. Архангай аймгийн хөгжлийн XXI-р зууны хөтөлбөр. ЗДТГ
13. Архангай аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр. 2004 он ЗДТГ
14. Архангай аймгийн эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. 1998 он ЗДТГ
15. Монгол орны ХАА-н уур амьсгалын лавлах. 1977 он. УБ хот.
16. Монгол улсын “Газарзүйн атлас” ГХГЗЗГ. 2004 он